



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО

**“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК, “ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН НҮҮРС ОЛБОРЛОЛТ,
БОРЛУУЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ, ЭКСПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН БУСАД
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ, НОТЛОХ БАРИМТЫГ ШИНЖЛЭН СУДЛАХ
НЭЭЛТТЭЙ СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ИРГЭД, ОЛОН НИЙТИЙГ
МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАНГ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД БАГТААН
ТАНИЛЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ**

ТАЙЛАН

АГУУЛГА

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ	4
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР	5
Хяналт шалгалтын зорилт:	5
Хяналт шалгалтын зарчим	6
Хяналт шалгалтын арга зүй.....	6
Хянан шалгагч, шинжээчдийн бүрэлдэхүүн, ажилласан хугацаа	7
Хяналт шалгалтын цар хүрээ	7
НЭГ. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	9
ХОЁР. НОТЛОХ БАРИМТ ИРҮҮЛЭХ ТОГТООЛЫН ТАЛААР	12
ГУРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, СОНСГОЛЫН ХУРААНГУЙ ...	13
Хянан шалгах түр хорооны СОНСГОЛ I үе шат	13
Хянан шалгах түр хорооны СОНСГОЛ II үе шат	27
ДӨРӨВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ДҮГНЭЛТ	54
ТАВ. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	57
ХАВСРАЛТУУД.....	58
Хавсралт 1.....	58
Хавсралт 2.....	60
Хавсралт 3.....	61
Хавсралт 4.....	62
Хавсралт 5.....	63

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЕРС	Engineering, procurement and construction
OECD	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АОУС	Аудитын олон улсын стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
АҮАТ	Ашиглалтын үйл ажиллагааны тайлан
АХБ	Азийн хөгжлийн банк
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХС	Батлан хамгаалахын сайд
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГХБ	Гаалийн хяналтын бүс
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон
ТАГ	Төрийн аудитын газар
ТББ	Тендерийн баримт бичиг
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТМТЗ	Татварын маргаан таслах зөвлөл
ТНАЛТ	Тавантолгой нүүрс ачилтын логистикийн төв
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТШХ	Тендер шалгаруулалтын хүснэгт
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБТЗ ХНН	Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
УМБГ	Улсын мөрдөн байцаах газар
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ХШТХ	Хянан шалгах түр хороо
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШУӨЗО	Шинжаан Уйгурын Өөртөө Засах Орон

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

2023.07.06	Монгол Улсын Их Хурлын 63 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хороог байгуулав.
2023.08.29	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны “Түр хорооны даргыг сонгох тухай” 01 дүгээр тогтоол;
2023.09.15	Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны “Хянан шалгах түр хорооны ажлын ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 02 дугаар, “Хянан шалгагч томилох, нотлох баримт гаргуулах тухай” 03 дугаар тогтоол;
2023.10.10	Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны “Хянан шалгах түр хорооны даргыг чөлөөлөх тухай” 04 дүгээр, “Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай” 05 дугаар, “Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 06 дугаар, “Шинжээч томилох тухай” 07 дугаар тогтоол;
2023.10.31	Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны “Хянан шалгах түр хорооны ажлын ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 08 дугаар тогтоол, “Хянан шалгагчийг чөлөөлөх тухай” 09 дүгээр, “Шинжээч томилох тухай” 10 дугаар, “Хянан шалгагч томилох тухай” 11 дүгээр тогтоол;
2023.11.07	Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны “Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай” 12 дугаар, “Хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх тухай” 13 дугаар, “Шинжээч томилох тухай” 14 дүгээр тогтоол;
2023.11.22	Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны “Хянан шалгах түр хорооны шинжээчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 15 дугаар тогтоол, “Нотлох баримт гаргуулах тухай” 17 дугаар тогтоол;
2023.11.27	Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны “Түр хорооны сонсголыг төвлөн зарлах тухай” 18 дугаар тогтоол, “Нотлох баримт шинжлэн судлах дараалал тогтоох тухай” 19 дүгээр тогтоол, “Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай” 20 дугаар тогтоол тус тус батлагдав.
2023.12.04-07	Сонсголын эхний үе шат дараах сэдвийн хүрээнд зохион байгуулагдав. <ul style="list-style-type: none"> - “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаа; - “Тавантолгой” ХК-д эрх бүхий байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтууд, тэдгээрийн үр дүнд авсан арга хэмжээ; - “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үүсгэн байгуулагдсанаас хойших үйл ажиллагаа, санхүүгийн мэдээлэл, ерөнхий мэдээлэл; - “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд 2011-2023 оны аравдугаар сарын гэрээт олборлогч компаниуд болон бусад бараа ажил үйлчилгээ худалдан авалт;
2023.12.11	Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны “Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай” 20 дугаар тогтоол батлагдав.
2023.12.18-22	Сонсголын II үе шат дараах сэдвийн хүрээнд зохион байгуулагдав. <ul style="list-style-type: none"> - “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн борлуулалт, экспортын үйл ажиллагаа; - “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа; - “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн охин болон хараат компаниуд оруулсан хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэгжилт; - “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүжүүлсэн төслийн хэрэгжилт; - “Эрдэнэс Тавантолгой” ХК-д эрх бүхий байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтууд, тэдгээрийн үр дүнд авсан арга хэмжээ - Хяналт шалгалтаар илэрсэн бусад асуудал

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 63 дугаар тогтоолоор байгуулсан Хянан шалгах Түр хороо (ХШТХ) хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хороо нь төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, орон нутгийн өмчийн оролцоотой “Тавантолгой “ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагааг иж бүрэн хянан шалгах чиг үүрэгтэй болно. ХШТХ-ны 2023 оны 08 дугаар тогтоолоор “Хянан шалгах түр хорооны ажлын ерөнхий төлөвлөгөө”, 12 дугаар тогтоолоор хянан шалгагчийн “Ажлын даалгавар”-ыг тус тус баталсан болно.

Хяналт шалгалтын зорилт:

УИХ-ын 2023 оны 63 дугаар тогтоолд Хянан шалгах Түр хороо дараах чиг үүрэгтэй гэж заасан байна.

- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх,
- нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах,
- хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах;

ХШТХ-ны 2023 оны 02, 08 дугаар тогтоолоор баталсан “Хянан шалгах түр хорооны ажлын ерөнхий төлөвлөгөө”, 12 дугаар тогтоолоор баталсан ажлын даалгаварт тодорхойлсноор Хүснэгт 1-д тусгасан байгууллагуудын холбогдох үйл ажиллагааг хамруулж, дараах үндсэн ажилбаруудыг гүйцэтгэсэн. Үүнд:

Хүснэгт 1

Д.д	Үндсэн ажлын нэр
1	Хяналт шалгалтын ажлын хүрээнд нотлох баримтын эх сурвалжийг тодорхойлох <ul style="list-style-type: none"> - Монголбанк, Үндэсний аудитын газар, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, - Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон салбар байгууллагууд, - Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба, Авто тээврийн үндэсний төв, - Өмнөговь аймгийн ИТХ, Засаг даргын тамгын газар, - Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Ханбогд сумын ИТХ, Засаг даргын тамгын газар, - Цагаанхад суурьшлын бүсэд гаалийн хяналтын бүс /Нүүрс ачих буулгах талбай/-ийн болон нүүрс тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага - “Монголын төмөр зам” ТӨХК, “Тавантолгой төмөр зам” ХХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН - Бусад төрийн байгууллага, хуулийн этгээд
2	Шаардлагатай нотлох баримтыг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд шаардаж гаргуулах
3	Нотлох баримт цуглуулах явцад болон Түр хорооны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар холбогдох этгээдээс тайлбар авах
4	“Эрдэнэс Тавантолгой” ХК, Тавантолгой ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт болон худалдан авалтын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төслийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах,
5	Цуглуулсан нотлох баримт болон холбогдох бусад бичиг баримтад дүн шинжилгээ хийх
6	Эрх бүхий байгууллагаас “Эрдэнэс Тавантолгой” ХК, Тавантолгой ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын материал болон шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлттэй танилцах,
7	Нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, худалдан авах ажиллагаанд оролцож буй хуулийн этгээдийн холбогдох хамаарлыг судлах
8	Нээлттэй сонсгол зохион байгуулах
9	Шинжээчийн дүгнэлт, хянан шалгагчийн тайлан боловсруулж, нэгтгэсэн тайланг УИХ-ын чуулганд танилцуулах

Хяналт шалгалтын зарчим

Хянан шалгагч, шинжээч нар нь ХШТХ-оос баталсан Ажлын ерөнхий төлөвлөгөө, Ажлын даалгаварт туссан ажилбаруудыг гүйцэтгэхдээ хууль дээдлэх, аливаа хөндлөнгийн нөлөөллөөс хараат бус байх, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллахыг эрхэмлэж, олон нийтийн эрх ашгийг хүндэтгэн ажилласан болно.

Хянан шалгах ажлыг гүйцэтгэхдээ анхаарсан асуудал,

- ⇒ *Хангалттай бөгөөд зохистой нотлох зүйлс олж авах үүднээс нэг эх сурвалжаас хараат бус байх;*
- ⇒ *Олон эх сурвалжаас ирүүлсэн дата, мэдээлэлд харьцуулалт хийх замаар үнэлэх, баримтжуулалтад анхаарч, нэмэлт материал бүрдүүлэх.*

Хянан шалгах ажлын талбар,

- ⇒ *Үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа, санхүүжүүлж буй төслийн хэрэгжилттэй газар дээр нь очиж танилцуулах, баримтжуулах,*
- ⇒ *Харуцсан мэргэжилтэн, хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах,*
- ⇒ *Шалгаагдагч, хамрагдагч байгууллагуудад ашиглаж буй цахим мэдээллийн системийн ашиглалт, мэдээллийн сангийн иж бүрэн, үнэн зөв байдлыг үнэлэх,*

Хянан шалгах ажлын тайлагнал,

- ⇒ *Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, харьцуулалт хийх боломжтой хугацааны интервалыг тодорхойлох,*
- ⇒ *Шалгаагдагч байгууллагын үйл ажиллагаа, үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон хугацааны интервалаар зэрэгцүүлэлт хийж, тайлагнах*

Хянан шалгах ажлын явцад хууль хяналтын байгууллага (УЕПГ, АТГ)-д холбогдох албан тушаалтнууд байгууллагад хохирол учруулсан байж болзошгүй асуудлаар шалгагдаж байгаа болон хяналт тавин ажиллаж байгаа хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд нөлөөлөхгүй байх зарчмыг баримтлан ажилласан.

ХШТХ-ны 2023 оны “Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай” 18 дугаар тогтоол, “Нотлох баримт шинжлэн судлах дараалал тогтоох тухай” 19 дүгээр тогтоолоор сонсголыг явуулах үе шат, хугацаа, нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын сэдэв агуулгыг батлан зохион байгуулахаар товлосны дагуу хэрэгжүүлсэн.

Хяналт шалгалтын арга зүй

Хянан шалгах ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Их хурлын Хяналт шалгалтын тухай хуулиар тодорхойлсон, Хянан шалгагчийн ажлын даалгаварт тусгасан нотлох баримт бүрдүүлэх, хянан шалгах дэд асуудлын дагуу нэмэлт нотлох баримт цуглуулж дүн шинжилгээ хийх, холбоотой талууд, албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар тодруулга авах, нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, түүвэр шалгалт явуулах, мэдээлэл тайлбар авч ажлын баримт материал үйлдэх, шаардлагатай тохиолдолд Түр хорооны бүрэн эрхийн дагуу тулган баталгаажуулалт хийх бусад нэмэлт горим, сорилыг хэрэгжүүлсэн¹.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан нотлох баримтын шаардлагыг хангасан байх хуулийн зохицуулалтын дагуу шалгаагдагч болон хамрагдагч хуулийн этгээдээс бүрдүүлсэн ажлын баримт материал нь баримтын хүчин төгөлдөр байдлыг хангуулахад анхаарч ажилласан болно.

Хянан шалгагч, шинжээчийн дүгнэлт нь “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК /шалгаагдагч байгууллага/-ийн нүүрс олборлолт, борлуулалт, худалдан авах ажиллагаа, санхүүжүүлсэн төсөл болон гаалийн хяналтын бүсийн болон тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, ААН, байгууллага, тэдгээрт хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд /хамрагдагч байгууллага/-аас албан бичгээр болон цахимаар ирүүлсэн баримт материал, цахим мэдээлэлд үндэслэсэн болно.

¹ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 44 дүгээр зүйл.

Хянан шалгагч, шинжээчдийн бүрэлдэхүүн, ажилласан хугацаа

ХШТХ-ны 2023 оны 9 дүгээр сарын 03 дугаар тогтоол, 10 дугаар сарын 06, 07, 10, 11 дүгээр тогтоол, 11 дүгээр сарын 14, 15 дугаар тогтоолоор нийт 8 хянан шалгагч, 11 шинжээч томилж, 10 дугаар сарын 06, 09 дүгээр тогтоолоор 3 хянан шалгагчийг чөлөөлсөн байна.

Нийт 5 хянан шалгагч, 11 шинжээч 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс ажлын төлөвлөгөө, ажлын даалгавар, томилолтын удирдамж боловсруулан эрчимтэй ажиллаж эхэлсэн бөгөөд Сонсгол I, II зохион байгуулагдаж дуусах хүртэлх хугацаанд 30-98 хоног буюу дунджаар 57.6 хуанлийн өдөр ажилласан байна.

Мөн хянан шалгагч, шинжээчдийн 5 хүний бүрэлдэхүүн бүхий баг Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн салбар, Тавантолгой ХК-ийн оффис, уурхайд 2023 оны 11 дүгээр сарын 03-08 өдрийн хугацаанд томилолтоор ажиллаж, тэдгээрийн олборлолт, борлуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа, санхүүжүүлж буй төслийн хэрэгжилт болон архивын баримт материалтай танилцсан болно.

Хяналт шалгалтын цар хүрээ

Улсын Их Хурлын 2023 оны 63 дугаар тогтоолд ХШТХ-ны шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, орон нутгийн өмчийн оролцоотой “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагааг иж бүрэн хянан шалгахаар заасан болно.

Шалгагдагч болон хамрагдагч байгууллагуудаас ирүүлсэн цахим мэдээллийн сан нь иж бүрэн бус, мэдээллийн найдвартай байдал бүрэн хангагдаагүй, цаасан суурьтай баримт материалын архив бүрдүүлэлт, хадгалалтын үйл ажиллагаа хангалтгүй байсан төдийгүй санхүүгийн анхан шатны баримт материалтай нэг бүрчлэн танилцах боломжгүй, цаг хугацаа хязгаарлагдмал байсан нь хяналт шалгалтын хамрах хүрээг хязгаарлаж, иж бүрэн дүгнэлт өгөх боломжгүй байдалд хүргэж байлаа.

Зарим шалгагдагч болон хамрагдагч байгууллагуудын архивын баримт болон цахим мэдээллийн сан иж бүрэн бус, ажил хүлээлцсэн байдал хангалтгүй, цаг хугацааны хязгаарлагдмал байдал зэргээс шалтгаалан “Тавантолгой” ХК-ийн 2013-2022 оны үйл ажиллагаа, гаалийн хяналтын бүс, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааны 2018-2023 он, тээврийн С зөвшөөрөл олголтын 2017-2023 оны үйл ажиллагааг хамрууллаа.

Хяналт шалгалтын ажлын хэсэг нь цаасан хэлбэрээр 136,282 хуудас, файл хэлбэрээр 3 сая гаруй хуудас нотлох баримт материалын хүрээнд хяналт шалгалт хийж, холбогдох асуудлыг нэгтгэн дүгнэсэн. Үүнд:


- *Өмнөх Хянан шалгах түр хорооны архивын нотлох баримт, ирсэн албан бичиг, Хянан шалгах Түр хорооны тогтоол, Хянан шалгах Түр хорооны хуралдааны тэмдэглэл 69 архивын нэгж 15393 хуудас, хяналт шалгалтын явцын тайлан 45 хуудас бүхий баримт материал; (Төрийн ордонд танилцсан болно.)*
- *ХШТХ-ны нэмж нотлох баримт гаргуулах тухай 3, 17, 21, 23 дугаар тогтоолоор нийт 40 байгууллагаас 82 нотлох баримт ирүүлэхээр зааснаас 38 байгууллага 78 нотлох баримтыг ирүүлсэн, 2 байгууллага ирүүлээгүй байна. Мөн шалгагдагч болон хамрагдагч байгууллагуудаас нотлох баримт, нэмэлт мэдээлэл гаргуулан авах тухай 137 албан бичиг явуулснаас 109 албан бичээр нийт 6575 хуудас баримт материал, цахим хэлбэрээр ирүүлсэн байна.*
- *“Эрдэнэс Тавантолгой” ХК нь дундын серверт хяналт шалгалтад шаардлагатай баримт материалуудыг байршуулж, хянан шалгагч, шинжээч нарт зөвхөн дотоод сүлжээнээс хандах эрх нээж өгсний дагуу энэхүү дундын сервер дэх мэдээлэлд хандаж, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашигласан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дундын сервер дэх 62.1 Gb хэмжээ бүхий үндсэн 21 фолдер, тэдгээрийн 915 дэд фолдеруудад байршуулсан 24,653 файл бүхий тээврийн болон пүүний мэдээлэл, ашиглалтын үйл ажиллагааны тайлан, борлуулалтын болон бусад гэрээ, худалдан авалтын материал;*

- “Тавантолгой” ХК-иас 19.6Gb хэмжээ бүхий 367 фолдер, 3315 файл бүхий 292078 мөр пүүний дата, хөрс хуулалтын ажлын болон нүүрс худалдах, худалдан авах гэрээ, тендер шалгаруулалтын 23957 хуудас боть материалууд, цахим хэлбэрээр 121 гэрээ, 812 хуудас бизнес төлөвлөгөө, 2014-2023 оны ерөнхий журнал зэрэг баримт материал;
- Хамаарал бүхий этгээд, нэгдмэл сонирхолтой этгээд, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдлыг тодорхойлохдоо Улсын бүртгэлийн ерөнхий газраас нийт давхардаагүй тоогоор 30997 хуулийн этгээдийн идэвхтэй, идэвхгүй байдлаар бүртгэгдсэн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигч, эрх барих этгээд, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд 68247 иргэн, хуулийн этгээдийн 77500 гаруй хуудас буюу 1.35GB файл бүхий улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа;
- Арилжааны банкнуудаас холбогдох шалгалтын удирдамжийн дагуу цаасан болон файл хэлбэрээр 12000 гаруй хуудас дансны хуулга;
- Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн 1.5 сая гаруй мэдүүлгийн дэлгэрэнгүй жагсаалт, пүүний програмын 270 мянга гаруй бүртгэл, 630 гаруй нүүрс худалдах, худалдан авах гэрээ, 110 гаруй олборлолтын гэрээ болон тус компанийн сүүлийн 10 гаруй жилийн уулын ажлын тайлан;
- Гашуунсухайт дахь Гаалийн ерөнхий газраас Цагаанхадад байрлах 36 хяналтын бүсүүдээс давхардсан тоогоор 2.5 сая гаруй нэвтэрсэн тээврийн хэрэгслийн бичлэг зэрэг нотлох баримтын хүрээнд шинжлэн судалж, холбогдох дүгнэлтийг гаргалаа.

НЭГ. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын нүүрсний нийт экспортын мэдээлэл

1.1 Монгол Улс 2013-2023.10 сар хүртэл нийт 315.5 сая тн нүүрсний экспорт хийсэн байна. Нийт нүүрсний экспортын 97.6 хувь буюу 308.0 сая тн нүүрсийг БНХАУ руу, Сингапур улс руу 2.3 хувь буюу 4.2 сая тн нүүрс, Их британи улс руу 0.54 хувь буюу 1.7 сая тонн нүүрс, бусад улс орнууд руу 1.4 сая тн нүүрс экспорт хийсэн байна. (ГЕГ-ын статистик мэдээ)



1.2 Монгол Улсын гаалийн байгууллага экспортолсон нийт нүүрсийг бүртгэхдээ тухайн худалдан авч буй талын бүртгэлтэй улсын нэрээр статистик мэдээлэлд оруулдаг байна.

1.3 Манай улсаас БНХАУ-аас бусад улс орнууд руу экспортолж буй нүүрс нь БНХАУ-ын хилээр гарч бүртгэгдэж байгаа бөгөөд тус улсын гаалийн байгууллага хэрхэн бүртгэж байгааг тодорхойлох боломжгүй байлаа.

1.4 Хятадын нүүрсний экспорт, импортын статистик мэдээллийн платформ дахь МУ-аас импортолсон нийт нүүрсний хэмжээг, Дэлхийн банк, НҮБ, дэлхийн худалдааны байгууллагуудын худалдааны статистикийн нэгдсэн мэдээллийн платформын мэдээлэлтэй харьцуулалт хийхэд зөрүү 39 мянган тонн байна.

1.5 Манай улсын 2013-2022 оны хооронд экспортолсон нийт нүүрсний биет хэмжээг, Хятадын нүүрсний экспорт, импортын статистик мэдээллийн платформ дахь МУ-аас импортолсон нүүрсний тоон мэдээлэлтэй тулган шалгахад БНХАУ-аас бусад улс орон руу экспорт хийсэн дүнг оруулж тооцоход 980.0 мян.тонн илүү, оруулаагүй тохиолдолд 6.1 сая тонны дутуу зөрүү үүсэж байна.

Хүснэгт 2 Монгол Улсын нийт экспортын статистик мэдээллийн харьцуулалт /мян.тн/

Он	*World integrated trade solution	**SX coal	***ГЕГ-ын мэдээ бусад улс орсон	***ГЕГ-ын мэдээ
2013	17,494.60	17,494.70	18,373.11	18,372.50
2014	19,269.10	19,268.90	19,498.97	19,479.00
2015	14,388.50	14,338.10	14,472.59	14,012.00
2016	26,396.70	26,396.70	25,810.60	25,414.00
2017	33,987.70	33,988.40	33,399.35	32,700.10
2018	36,241.90	36,241.90	36,264.68	35,867.20
2019	36,206.30	36,207.60	36,604.07	35,935.60
2020	28,546.90	28,551.10	28,676.87	27,299.90
2021	16,443.30	16,443.60	16,137.64	14,987.30
2022	31,143.20	31,148.20	31,821.57	29,905.50
Нийт	260,118.40	260,079.10	261,059.50	253,973.10

*<https://wits.worldbank.org/trade/country-byhs6product.aspx?lang=en#void>

**<https://www.sxcoal.com/en/data/detail/FW6002D>

***<https://gaali.mn/statistic/detail/04>

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ерөнхий мэдээлэл

1.6 Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций суманд оршдог Цанхи, Бортээг, Оорцог, Ончхараат, Бортолгой, Ухаахудаг гэсэн 6 үндсэн хэсгээс бүрдэх 2-30 метр зузаан 16 давхраастай 71,708.6 га ашиглалтын талбайг эзэлсэн эрчим хүчний болон коксжих чулуун нүүрсний орд болно.

1.7 УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолоор “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай”, УИХ-ын 2010 оны 39, Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулж, ТӨБЗГ-ын 2010 оны 425 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дүрмийг баталсан байна.

1.8 УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг бие даасан компани болгож, Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолоор төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК-аас шилжүүлж, УУХҮЯ 70 хувь, ТӨБЗГ 30 хувь тус тус хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Засгийн газрын 2021 оны “Эрдэнэс Монгол” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 367 дугаар тогтоолоор төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК-д 81.5 хувийг буцаан шилжүүлсэн байна. Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолоор (Засгийн газрын 2023 оны 424 дүгээр тогтоолоор хугацааг 6 сараар сунгасан) Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч томилсон байна.

1.9 Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь заалт болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д ТУЗ-ийн төрийг төлөөлж буй гишүүн нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллахаар заасны дагуу төрийн төлөөллийг хэрэгжүүлэгчээс (УУХҮЯ, ТӨБЗГ, “Эрдэнэс Монгол” ХХК) удирдамж ирсний дараа компанийн Хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийг хуралдуулдаг бөгөөд хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр удирдамж авахыг шаарддаг байна.

1.10 Тавантолгой ордын нийт нөөц 2018 оны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хүлээн авсан дүнгээр 6.3 тэрбум тонн, үүнээс коксжих нүүрс 3.3 тэрбум тн, эрчим хүчний нүүрс 2.8 тэрбум тн, исэлдсэн нүүрс 0.15 тэрбум тн байна.

Хүснэгт 3 Ордын нөөц, төрөл

№	Нүүрсний төрөл	Ордын нийт нөөц, нүүрсний төрлөөр				
		нөөцийн зэрэглэл, нөөц /сая.тн/ цэвэр нүүрс, 2018 оны ЭБМЗ-ийн хүлээж авсан дүн				
		A	B	C	P1	A+B+C+P1
1	Ордын нийт нөөц	396.1	2,006.0	1,618.3	2,287.6	6,308.0
1.1	Коксжих нүүрс	348.9	1,534.7	731.2	711.4	3,326.3
1.2	Эрчим хүчний	47.1	467.2	753.0	1,562.7	2,830.1
1.3	Исэлдсэн	-	4.1	134.1	13.5	151.6

Эх сурвалж: 2018 оны нөөцийн тайлан/

1.11 Цанхийн баруун уурхайн 2013 оны ТЭЗҮ болон 2020 оны ТЭЗҮ-ийн тодотголд 2013-2023 оны 10 сар хүртэл нийт 145.6 сая тонн нүүрс олборлохоор тусгаснаас гүйцэтгэлээр нийт 45.4 сая тонн нүүрс олборлосон. Цанхийн зүүн уурхайн 2011 оны ТЭЗҮ болон 2021 оны ТЭЗҮ-ийн тодотголд 2011-2023 оны 10 сар хүртэл нийт 146.0 сая тонн нүүрс олборлохоор тусгаснаас гүйцэтгэлээр нийт 72.4 сая тонн нүүрс олборлосон байна.

1.12 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2010-2023 оны 9 сар хүртэл нийт 595.2 сая м³ уулын цулын ажил, 511.5 сая м³ хөрс хуулалт, 117.8 сая тонн нүүрс олборлосон бөгөөд 110.1 сая тонн нүүрс борлуулж, түүхэн ханшаар тооцсоноор 20.2 их наяд төгрөгийн борлуулалт (нүүрсээр хийсэн борлуулалт орсон) хийсэн байна.

Хүснэгт 4 Уулын ажлын гүйцэтгэл /туслан гүйцэтгэгч компани тус бүрээр/

Туслан болон түншлэлийн гүйцэтгэгч компаниуд	Хэмжих нэгж	Нийт	Эзлэх хувь
Олборлосон нүүрс		117,230.2	22.9%
Цанхийн зүүн уурхай		72,157.5	61.6%
"Эрдэнэс Тавантолгой" ХК	мян.тн	8,707.3	12.1%
"Макмахон монголиа" ХХК		5,704.9	7.9%
"Ти ти жи ви си өү" ХХК		42,210.8	58.5%
"Хишиг арвин индустриал" ХХК		160.4	0.2%
"Моннис майнинг" ХХК		38.0	0.1%
Тавантолгой оператор түншлэл		946.1	1.3%
Ти эн түншлэл		14,389.9	19.9%
Цанхийн баруун уурхай		45,072.7	38.4%
"Эрдэнэс Тавантолгой" ХК		2,577.1	5.7%
"Хишиг арвин индустриал" ХХК		24,221.6	53.7%
"Саусгоби сэндс" ХХК		1,109.5	2.5%
"Моннис майнинг" ХХК		5,101.4	11.3%
Тавантолгой оператор түншлэл		12,063.1	26.8%
Хөрс хуулалт		511,453.4	100%
Цанхийн зүүн уурхай	317,402.7	62%	
"Эрдэнэс Тавантолгой" ХК	мян.м.куб	10,431.4	3%
"Макмахон монголиа" ХХК		20,831.9	7%
"Ти ти жи ви си өү" ХХК		200,472.7	63%
"Хишиг арвин индустриал" ХХК		1,935.0	1%
"моннис майнинг" ХХК		4.6	0%
Тавантолгой оператор түншлэл		4,397.1	1%
Ти эн түншлэл		79,329.9	25%
Цанхийн баруун уурхай		194,050.8	38%
"Эрдэнэс Тавантолгой" ХК		5,040.1	3%
"Хишиг арвин индустриал" ХХК		112,301.7	58%
"Саусгоби сэндс" ХХК		2,640.1	1%
"Моннис майнинг" ХХК		30,609.7	16%
Тавантолгой оператор түншлэл		43,459.2	22%

1.13 "Эрдэнэс Тавантолгой" ХК нь 2011-2023 оны 9 сар хүртэл 26.6-6,689.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, 17.9-1,576.9 тэрбум төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөгтэйгөөр ажиллаж 5.1-2,705.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2023 оны 9 сарын байдлаар нийт хөрөнгө 19,337.2 тэрбум төгрөг, нийт өр төлбөр 3,061.1 тэрбум төгрөг, хуримтлагдсан ашиг 5,080.1 тэрбум төгрөг, улсад 2,540.7 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна.

1.14 "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нийт хувьцааны 85.2 хувийг төр, 0.06 хувийг аж ахуйн нэгж, 14.7 хувийг иргэд эзэмшиж байгаа бөгөөд 2020 онд төрийн эзэмшлийн хувьд 880.2 тэрбум төгрөгийг бүртгэж, иргэд болон хүсэлт ирүүлсэн аж ахуй нэгжид нийт 180.1 тэрбум төгрөгийн ногдол ашиг шилжүүлсэн байна.

1.15 "Эрдэнэс Тавантолгой" ХК нь төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, усан хангамж, кокс-эрчим хүчний үйлдвэр зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хамаарах, нэмүү өртөг шингээх 8 төсөлд нийт 5,024.7 тэрбум төгрөг, Засгийн газар, ТУЗ-ийн холбогдох шийдвэрийн дагуу компанийн үндсэн үйл ажиллагаанд үл хамаарах Богдхан төмөр зам, Газрын тос дамжуулах хоолой зэрэг төсөлд нийт 463.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

1.16 "Эрдэнэс Тавантолгой" ХК нь 2010-2023 онд бараа үйлчилгээний худалдан авалтын нийт 10,388.3 сая төгрөгийн 932 гэрээ байгуулсан бөгөөд үүнээс хөрс хуулалт, нүүрс олборлолтын 7,103.3 сая төгрөгийн 17 гэрээ, нүүрс ачилтын 76.6 сая төгрөгийн 5 гэрээ, нүүрс тээврийн 164.7 сая төгрөгийн 18 гэрээ, техник машин механизмын 1,356.7 сая төгрөгийн 75 гэрээ, өрөмдлөг тэсэлгээний 42.5 сая төгрөгийн 30 гэрээ, дээж шинжилгээ, геофизикийн 14.4 сая төгрөгийн 10 гэрээ, туслах үйл ажиллагааны 1,630.1 сая төгрөгийн 777 гэрээ байгуулж худалдан авалт хийсэн байна.

1.17 "Эрдэнэс Тавантолгой" ХК нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор 2021 онд "ЭТТ-Бонд"-ын I болон II дугаар транчийн санхүүжилтээр төгрөгийн 10.0 хувийн хүүтэй нийт 543.4 тэрбум төгрөг, ам.долларын 6.8 хувь болон 5.8 хувийн хүүтэй 52.3 сая ам.долларын санхүүжилтийг босгосон. 2022 онд II-3 транчаар бодлогын хүү дээр нэмэх нь 4.0 хувийн хүүтэй 76.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татсан байна.

1.18 Үнэт цаас гаргаж татан төвлөрүүлсэн хөрөнгийн 342.3 тэрбум төгрөгийг дэд бүтцийн төслийн санхүүжилтэд, 98.6 тэрбум төгрөгийг уурхайн хөгжүүлэлтэд, 319.6 тэрбум төгрөгийг гэрээт олборлогчийн ажлын хөлсөнд зарцуулсан байна.

1.19 Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолыг үндэслэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой Майнинг” ХХК-ийг байгуулахаар шийдвэрлэсэн байна. “Эрдэнэс Тавантолгой Майнинг” ХХК-д толгой компанийн үйл ажиллагааны орлогоос 2019 онд 26.7 тэрбум, 2020 онд Цанхийн зүүн уурхайн нүүрсний борлуулалтаас 129.9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Тус охин компани нь Засгийн газрын шийдвэрээр гадаадын хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргах ажил 9 сарын хугацаанд үргэлжилж зөвлөх үйлчилгээ, албан хаагчдын цалин, гадаад томилолт зэрэг зардалд 48.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 146 дугаар тогтоолоор Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсоноор “Эрдэнэс Тавантолгой Майнинг” ХХК татан буугдсан байна.

Тавантолгой ХК-ийн ерөнхий мэдээлэл

1.20 Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах Тавантолгойн ордыг 1966 оноос үйлдвэрлэлийн аргаар ашиглаж эхэлсэн байна. Засгийн газрын өмч хувьчлалын комиссын 1994 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 42 дугаар тогтоолоор төрийн өмч давамгайлсан, УИХ-ын 1999 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Аймаг нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай” 29 дүгээр тогтоолоор орон нутгийн өмч давамгайлсан хувьцаат компани болсон байна.

1.21 “Тавантолгой” ХК нь Монголын хөрөнгийн биржийн хувьцааны бүртгэлийн I ангилалд бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани бөгөөд 2023 оны 10 дугаар сарын байдлаар нийт 4 газар, 8 албанд 278 ажилтантайгаар нүүрс олборлолт, борлуулах үндсэн үйл ажиллагаа явуулж байна.

1.22 “Тавантолгой” ХК нь 2011-2021 онд 25.3-472.9 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, 22.7-233.8 тэрбум төгрөгийн олборлолтын зардал, 2.6-194.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 2.53 сая тн нүүрс олборлож, аудитлагдаагүй тайлангаар 762.4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, 358.6 тэрбум төгрөгийн олборлолтын зардалтай ажиллаж 331.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 2014-2022 онд хувьцаа эзэмшигчдэдээ нийт 170.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг шилжүүлсэн байна.

ХОЁР. НОТЛОХ БАРИМТ ИРҮҮЛЭХ ТОГТООЛЫН ТАЛААР

2.1 ХШТХ-ны 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Хянан шалгагч томилох, нотлох баримт гаргуулах тухай” 03 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай бүхий л байгууллагуудаас нотлох баримтуудыг гаргуулан авч, дүн шинжилгээ хийхийг хянан шалгагч нарт үүрэг болгосон болно.

2.2 ХШТХ-ны 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Нотлох баримт гаргуулах тухай” 17 дугаар тогтоол /ХШТХ-ны 2023 оны 21, 23 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/-оор нийт 40 төрийн байгууллага, хуулийн этгээдээс 82 төрлийн баримт материалыг нотлох баримтаар гаргуулан авахаар баталснаас 38 байгууллага 78 нотлох баримтыг ирүүлсэн, 2 байгууллага ирүүлээгүй байна.

2.3 Мөн шалгаагдагч болон хамрагдагч байгууллагуудаас нотлох баримт, нэмэлт мэдээлэл гаргуулан авах тухай 137 албан бичиг явуулснаас хариуг 109 албан бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлсэн байна.

ГУРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, СОНСГОЛЫН ХУРААНГУЙ

ХШТХ-ны 2023 оны “Ажлын ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 08 дугаар тогтоол, “Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай” 12 дугаар тогтоол, “Хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх тухай” 13 дугаар тогтоолын дагуу ирүүлсэн баримт материалыг хүлээн авч, шаардлагатай материалыг нэмэлтээр гаргуулан хуульд заасны дагуу хянан шалгах ажлыг гүйцэтгэсэн.

ХШТХ-ны 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай” 18 дугаар тогтоолоор нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг 2 үе шаттайгаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

- 2023 оны 12 дугаар сарын 04-08 өдрүүдэд “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаа болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаа;
- 2023 оны 12 дугаар сарын 18-22 өдрүүдэд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, охин болон хараат компаниудын хөрөнгө оруулалт, тэдгээрийн үйл ажиллагаа;

Энэхүү тайланд шинжээчдийн дүгнэлтийг сэдэв тус бүрээр хураангуй байдлаар тусгасан болно.


Хянан шалгах түр хорооны СОНСГОЛ I үе шат

ХШТХ-ны 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай” 20 дугаар тогтоолын дагуу нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын I үе шатанд нийт 360 гэрч оролцохоос 272 гэрчид мэдэгдэх хуудас хүргүүлсэн бөгөөд үүнээс 213 гэрч оролцож, 37 гэрч оролцох боломжгүй байгаа тухай албан бичиг, өргөдөл хүсэлт ирүүлсэн байна.

Уг сонсголоор “Тавантолгой ХК-ийн үйл ажиллагаа, нүүрс олборлолт, борлуулалт болон эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн худалдан авах үйл ажиллагааны талаар танилцуулсан.

“Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн талаар

3.1 Өмнөговь аймгийн ИТХ нь “Тавантолгой” ХК-ийн 51 хувийн хувьцаа эзэмшиж байгаа бөгөөд бусад хувьцаа эзэмшигчид 2022 оны жилийн эцсийн байдлаар дараах байдалтай байна.



3.2 “Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн 2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн даргаар Д.Бат-Эрдэнийг сонгосон бөгөөд 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 120 дугаар тогтоолоор орон нутгийн төлөөлөл болон даргын үүрэгт ажлаас өөрийн хүсэлтийг нь үндэслэн чөлөөлсөн байна.

3.3 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийг орон нутгийн өмчийн төлөөлөгчөөр томилсон нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн тухай хуулийн 18, 21 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхтэй холбоотой Төрийн өмчийн хорооны 2005 оны 66 дугаар тогтоолоор баталсан

“Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх түр журам”-ын 10.3-т “Төрийн өмчийн төлөөлөгч нь хувийн өмчлөгчдөөс сонгогдсон ТУЗ, ХШЗ-ийн гишүүний ойрын төрөл буюу нэгдмэл сонирхолтой байж болохгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

3.4 ТУЗ-ийн дарга болон Гүйцэтгэх захирлыг томилох асуудлыг 51 хувийн хувьцаа эзэмшигч (Өмнөговь аймгийн ИТХ)-ийн саналаар шийдвэрлэх ёстой хэдий ч 2009 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 49 хувийн хувьцаа эзэмшигч тал шийдвэрлэж ирсэн байна.

Хүснэгт 5 Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлага

ТУЗ-ийн даргын нэр	Томилогдсон огноо	Чөлөөлөгдсөн огноо	Гүйцэтгэх захирлын нэр	Томилогдсон он	Чөлөөлөгдсөн он
Д.Бат-Эрдэнэ	2009.05.01	2011.12.13	Х.Түмэнбаяр	2007	2013
Б.Түвшинбаяр (Д.Бат-Эрдэнэ үеэл)	2012.04.30	2016.11.23	Ч.Цэцэг-Өлзий (Д.Бат-Эрдэнэ үеэл)	2013	2013
С.Мөнхбаяр	2016.12.07	2019.03.11	Р.Сэддорж (Д.Бат-Эрдэнэ туслах)	2014	2020
В.Мөнхбат	2019.04.29	2020.07.25	Ж.Доржсүрэн	2020	2022
Б.Түвшинбаяр (Д.Бат-Эрдэнэ үеэл)	2021.03.04	2023.03.01	П.Сайнзориг	2022	2023
Г.Цог-Өрнөх	2023.06.09	-	Д.Артаг	2023	-

3.5 ТУЗ-ийн тогтоол, мөнгөн гүйлгээний журналыг хянаж үзэхэд ТУЗ-ийн гишүүдэд 2014-2021 онд нийт 1,699.3 сая төгрөгийн урамшуулал болон дараах буцалтгүй тусламж, дэмжлэгийг олгосон байна.

Хүснэгт 6 “Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, удирдлагын багт олгосон буцалтгүй тусламж

Огноо	Агуулга	Тогтоолд тусгасан	Олгосон
2009 он	ТУЗ-ийн дарга Н.Наранбаатарт	Toyota Land cruiser-105 автомашин	
2010 он	ТУЗ-ийн гишүүн С.Сумъяад эмчилгээний зардал	43.6 сая төгрөг	
2013 он	ТУЗ-ийн гишүүн А.Жаргалсайханд буцалтгүй тусламж	35,000\$	31,500\$
2013 он	ТУЗ-ийн гишүүн Г.Цог-өрнөхөд буцалтгүй тусламж	36,000\$	32,400\$
2014 он	Ерөнхий нягтлан бодогч Г.Шүрэнхишигт буцалтгүй тусламж	25,000\$	25,000\$
2014 он	ТУЗ-ийн гишүүн Д.Ганболдод буцалтгүй тусламж	35.0 сая төгрөг	
2014 он	ТУЗ-ийн гишүүн А.Идэрцогтод буцалтгүй тусламж	25.0 сая төгрөг	
2015 он	ТУЗ-ийн дарга Б.Түвшинбаярт	Toyota Lexus-570 автомашин	

“Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нүүрсний нөөц, нүүрс олборлолтын үйл ажиллагаа

3.6 Тавантолгойн ордын нөөцийг эргэлтэд оруулж, ашиглах болсонтой холбоотойгоор тухайн бүлэг ордод 1984-1987, 1989-1990 оны нарийвчилсан хайгуулын ажлын тайлангийн үр дүнд үндэслэн Цанхийн төв хэсэгт орших “Тавантолгой” ХК-ийн эзэмшиж буй MV-000287 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нөөцийг /анхны хэмжээ болон өнгөрсөн хугацаанд олборлосон нүүрс, үлдэгдэл нөөцийн хэмжээ/ 2014.07.17-ны өдрийн байдлаар тооцсон байна.

Хүснэгт 7 “Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нөөц

Нүүрсний төрөл /MNS 6456-2014/		нөөцийн зэрэглэл***, нөөц /мян.тн/			
		А	В	С	А+В+С
1	Ордын нийт нөөц	36,302.60	101,609.54	80,884.60	218,796.74
1.1	Коксжих нүүрс /Ч3, Ч4, Ч5, Ч6, Ч7, Ч8/	36,302.60	96,939.20	80,545.50	213,787.30
1.2	Эрчим хүчний /Ч1, Ч2, Ч12/	-	2,945.64	-	2,945.64
1.3	Исэлдсэн	-	1,724.70	339.10	2,063.80

3.7 Ордын нийт нөөцийн 97.7 хувь буюу 213.7 сая тн коксжих нүүрс, 1.3 хувь буюу 2.9 сая тн эрчим хүчний нүүрс, 0.9 хувь буюу 2.0 сая тн исэлдсэн нүүрс эзэлдэг бөгөөд 2015-2023 онд нийт 22.9 сая тн нүүрс олборлолтын ажлыг дараах зохион байгуулалттайгаар гүйцэтгэсэн байна.

- Өөрийн техник болон худалдан авагч компанийн ажиллах хүчээр нүүрс олборлолт;
- Гэрээт, туслан гүйцэтгэгчийн оролцоотой өрөмдлөг, тэсэлгээ, хөрс хуулалт, хөрс тээвэр, овоолго

Хүснэгт 8 Уулын ажлын үзүүлэлт /мянган м³/

№	Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023.10
1	Нийт уулын цул	4,029.4	14,359.9	23,354.2	16,408.2	23,403.9	19,707.9	14,620.4	12,638.5	13,500.9
2	Хөрс хуулалт	3,552.0	11,098.2	20,354.9	15,062.8	21,673.4	17,756.6	13,460.0	10,828.0	11,746.8
3	Хөрс хуулалтын коэффициент	5.31	2.43	4.85	8.00	8.95	6.73	8.50	4.27	4.78

Эх сурвалж: Тавантолгой ХК


3.8 Хөрс хуулалтын ажил гүйцэтгэгч компаниудын гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг хянан шалгагч, шинжээч нарт ирүүлсэн хөрсний актын хэмжээнд хянан үзэхэд зарим оны дүнг нягтлах боломжгүй, зарим оны гүйцэтгэсэн нийт тоо хэмжээ Ашиглалтын үйл ажиллагааны тайланд тусгасан дүнгээс зөрүүтэй байна.

Хүснэгт 9 Хөрсний ажлын тоо хэмжээ

№	Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	АУАТ-нд тусгасан дүн	Нягтлах боломжгүй		5,207.0	11,098.2	20,354.9	15,062.8	21,673.4	17,756.6	13,460.0	10,828.0
2	Хөрсний актын дүн	693.8	4,767.6	5,170.8	7,311.4	20,354.9	10,729.4	21,673.4	17,756.6	7,128.3	8,932.6
	Зөрүү			36,2	3,786.8	-	4,333.4	-	-	6,331.7	1,895.4

Эх сурвалж: Тавантолгой ХК

3.9 “Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 05, 2021 оны 20, 2022 оны 09, 17 дугаар тогтоолоор хөрс хуулалтын зардлын хэмжээг өөрчлөн тогтоож ирсэн бөгөөд хянан шалгагч, шинжээч нар нь хөрсний актаар тогтоосон ажлын тоо хэмжээ болон ТУЗ-ийн тогтоолоор баталсан тарифыг үндэслэн хөрс хуулалтын зардлын нийт хэмжээг тойм байдлаар тооцож үзэхэд дараах байдалтай байна.



3.10 Хөрсний ажил гүйцэтгэгчийг 2023 он хүртэлх хугацаанд хэрхэн сонгон шалгаруулж, гэрээ байгуулж байсан талаар баримт материал хяналт шалгалтын явцад ирүүлээгүй, ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөөгүй байх бөгөөд ТУЗ-ийн 2009 оны 12, 2014 оны 08 дугаар тогтоолуудаар хөрс хуулах ажил гүйцэтгэх компаниудтай гэрээ байгуулахыг зөвшөөрч байжээ. Мөн гүйцэтгэгч компанитай байгуулсан “Хөрсний ажил гүйцэтгэх гэрээ”-г ТУЗ-ийн дарга баталж ирсэн байна.

3.11 Хөрс хуулалтын ажил гүйцэтгэсэн зарим компанийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага нь улс төрд нөлөө бүхий этгээд, ИТХ-ын төлөөлөгч, тус компанийн ТУЗ-ийн гишүүдтэй хамаарал бүхий, нэгдмэл сонирхол бүхий этгээд, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалтай байж болзошгүй байх тул ТБОНӨХБАҮХАТХ-ийг

мөрдөхгүйгээр ажил гүйцэтгүүлсэн нь хууль тогтоомжид нийцэх эсэхийг нягтлан шалгах шаардлагатай байна.

3.12 Тус компанийн 2013-2019 онд байгуулсан хөрс хуулалтын ажил гүйцэтгэх зарим гэрээнд гүйцэтгэх ажлын тоо хэмжээ заагаагүй, зарим компанийн хувьд 2013 онд байгуулсан гэрээний дуусах хугацаа хэсэгт “Тавантолгой” ХК өөрөө олборлох хүчин чадалтай болох хүртэл гэж гэрээ байгуулж байжээ. Тухайлбал:

- “Болор аграмба” ХХК-тай 2013 оны 12 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан 72/13 дугаар бүхий Ажил гүйцэтгэх гэрээнд “... гэрээнд гарын үсэг зурж хүчин төгөлдөр болсноос хойш Тавантолгой ХК өөрөө олборлох хүчин чадалтай болох хүртэл үргэлжилнэ”, “Сард ... м³-с доошгүй хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ”;
- “Бадрах од өгөөж” ХХК-тай 2016 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр байгуулсан ТГ/2016/02 дугаар бүхий Ажил гүйцэтгэх гэрээнд “Сард ... м³-с доошгүй хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ”;
- “Хавцгайт их хайрхан” ХХК-тай 2017 оны 5 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан ТГ/2017/05 дугаар бүхий Ажил гүйцэтгэх гэрээнд “Сард ... м³-с доошгүй хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ”;

3.13 “Тавантолгой” ХК-иас ирүүлсэн 2013-2022 оны хөрсний ажил гүйцэтгэх гэрээ, 55 компанийн хөрсний ажлын актын хэмжээнд хянаж үзэхэд 13 компани 5-аас дээш жил, 7 компани 3 жил, 11 компани 2 жил, 24 компани 1 жил хөрс хуулалтын ажил гүйцэтгэсэн бөгөөд дараах компаниуд хамгийн олон жил хөрсний ажил гүйцэтгэсэн байна.

- “Бадрах од өгөөж” ХХК, “Ёл ази” ХХК, “Язгууртны говь” ХХК тус бүр 10 жил, “Болор аграмба” ХХК 8 жил, “Хавцгайт их хайрхан” ХХК 7 жил, “Бетеллэйд” ХХК 6 жил, “Асартайн говь” ХХК, “Ингүүмэл энх” ХХК, “Таван хур” ХХК тус бүр 5 жил, “Говь түрүү” ХХК, “Их шижир булаг” ХХК, “Морин улаач” ХХК, “Эрдэнэт цэций хайрхан” ХХК тус бүр 4 жил тус тус ажил гүйцэтгэсэн,

3.14 “Тавантолгой” ХК-иас ирүүлсэн 2013-2022 оны хөрсний ажил гүйцэтгэх гэрээ, 55 компанийн хөрсний ажлын актын хэмжээнд хянаж үзэхэд 15 компани 2.0 сая м³-с дээш, 5 компани 1.0-2.0 сая м³, 8 компани 0.5-1.0 сая м³, 15 компани 0.1-0.5 сая м³, 12 компани 0.1 сая м³ хүртэл ажил гүйцэтгэсэн бөгөөд дараах компаниуд хамгийн их хэмжээний хөрсний ажил гүйцэтгэсэн байна.


- “Ингүүмэл энх” ХХК 14.5 сая м³, “Ёл ази” ХХК 13.8 сая м³, “Говь түрүү” ХХК 7.9 сая м³, “Бадрах од өгөөж” ХХК 6.1 сая м³, “Язгууртны говь” ХХК 5.4 сая м³, “Хавцгайт их хайрхан” ХХК 5.0 сая м³, “Болор аграмба” ХХК 4.5 сая м³, “Zhi hang earthwork” 4.3 сая м³, “Hongli” 4.3 сая м³, “Таван хур” ХХК 4.3 сая м³, “Их шижир булаг” ХХК 4.0 сая м³, “Асартайн говь” ХХК 3.8 сая м³, “Бетеллэйд” ХХК 3.0 сая м³, “Морин улаач” 2.4 сая сая м³, “Голд магнет” ХХК 2.1 сая м³ ажил тус тус гүйцэтгэсэн.

3.15 “Тавантолгой” ХК-иас хөрсний ажил гүйцэтгэсэн компанитай төлбөрийг нүүрсээр барагдуулах нөхцөлтэй байгуулсан гэрээний хувьд гүйцэтгэгчид олгосон санхүүжилтийг нягтлах боломжгүй байлаа.

“Тавантолгой” ХК-ийн нүүрс борлуулалтын үйл ажиллагаа

3.16 Хяналт шалгалтын хугацаанд “Тавантолгой” ХК-иас нүүрс борлуулалтын гэрээ тус бүрээр дүгнэсэн актыг ирүүлээгүй, пүүний програмын дата, нягтлан бодох бүртгэлийн програмаас гаргаж буй мэдээлэл иж бүрэн бус, шаардлага хангахгүй байв.

3.17 “Тавантолгой” ХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлангаас үзэхэд тус компани 2013-2022 онд нийт 2,508.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна.



3.18 “Тавантолгой” ХК-ийн 2015-2022 онд борлуулсан нийт нүүрсний тоо хэмжээг АҮАТ болон АМНАТ-ийн тайланд тусгасан дүнтэй харьцуулж үзэхэд 362.16 мянган тн зөрүүтэй, АМНАТ-ийн тайлан, АҮАТ-нд тусгасан дүнг пүүний програмын дататай харьцуулж үзэхэд 3.7-4.5 сая тн зөрүүтэй байх бөгөөд хяналт шалгалтын хугацаанд /1 сар орчим/ пүүний падаан тус бүрээр тулган баталгаажуулах боломжгүй байлаа.

3.19 “Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн 2014, 2021, 2022 оны тогтоолоор нүүрс худалдан авагчтай гэрээ байгуулахыг зөвшөөрч байсан бөгөөд бусад хугацаанд нүүрс худалдан авагчийг хэн, хэрхэн сонгон шалгаруулж байсан нь тодорхойгүй, холбогдох баримт материалыг хяналт шалгалтын явцад ирүүлээгүй болно. Зарим компанийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага нь улс төрд нөлөө бүхий этгээд, ИТХ-ын төлөөлөгч, тус компанийн ТУЗ-ийн гишүүнтэй хамаарал бүхий, нэгдмэл сонирхол бүхий этгээд, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалтай байж болзошгүй байх тул холбогдох эрх бүхий байгууллага хууль тогтоомжид нийцэх эсэхийг дахин нягтлан шалгах шаардлагатай гэж үзлээ.

3.20 “Тавантолгой” ХК 2013-2022 онд байгуулсан нийт 74.9 сая тн нүүрс нийлүүлэх 610 гэрээ байгуулсан байх бөгөөд 21.6 сая тн нүүрс борлуулсан байна. Үүнээс:

- 55.7 сая тн нүүрс нийлүүлэх 503 гэрээг БНХАУ-ын хуулийн этгээд,
- 19.2 сая тн нүүрс нийлүүлэх 107 гэрээг Монгол Улсын хуулийн этгээд,

3.21 Гэрээнд тусгасан нүүрсний үнэ, нийлүүлэх хэмжээнд үндэслэн гэрээний үнийг тооцоход 40.2 сая тн нүүрс нийлүүлэх 559 гэрээ нь хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас бага дүнтэй буюу Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх заалт²-д заасан их хэмжээний хэлцэлд хамаарахгүй гэрээ байна.

3.22 Пүүний програмын датанд үндэслэн 2013-2022 оны хугацаанд нийт нийлүүлсэн нүүрсний хэмжээг компани тус бүрээр авч үзэхэд 272 компанид 100.0 мянган тн хүртэлх, 17 компанид 101.0-400.0 мянган тн, 6 компанид 401.0-1,000.0 мянган тн, 3 компанид 1.6-2.4 сая тн нүүрс нийлүүлсэн байна.

Тавантолгой ХК-аас нүүрс худалдах худалдан авах гэрээний дагуу Тавантолгой транс ХХК нүүрс худалдан авч, төлбөрөө төлөөгүй авлага үүсгэсэн асуудал

3.23 “Тавантолгой” ХК-ийн санхүүгийн харилцагчийн дэлгэрэнгүй журналд “Тавантолгой транс” ХХК-ийн өр төлбөр 2023.11.01-ний өдрийн байдлаар 6.8 тэрбум төгрөг гэж бүртгэгдсэн бөгөөд өр төлбөр 2015 онд их хэмжээгээр буурч байсан тул хяналт шалгалт хийсэн болно.

3.24 “Тавантолгой” ХК-ийн 2015 оны авлагын дэлгэрэнгүй журнал, тайланг шалгахад “Тавантолгой транс” ХХК-аас авах авлага оны эхэнд 29.5 тэрбум төгрөг байсан бөгөөд 2015.01.01-ний өдөр 8.8 тэрбум төгрөгөөр, 9.6 тэрбум төгрөгөөр, нийтдээ 18.5 тэрбум төгрөгөөр буурсан, нүүрс худалдан авсан өр төлбөр 3.4 тэрбум төгрөгөөр хасагдсан байна.

² Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1. Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно: 87.1.1. хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/; 87.1.2. компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

3.25 “Тавантолгой транс” ХХК-ийн 2015.01.01-ний өдрийн өр төлбөрийн эхний үлдэгдлээс 3 удаагийн гүйлгээгээр их хэмжээгээр хасагдсан байсан тул санхүүгийн баримт материалыг шалгахад “Тавантолгой транс” ХХК-ийн нүүрс худалдан авч, худалдан авсан төлбөрөө төлөхгүй өр төлбөр үүсгэж явж ирсэн байна. 2015.01.01-ний өдөр 8.8 тэрбум, 9.6 тэрбум төгрөгөөр хасагдсан өр төлбөр нь нүүрсний зах зээл уналттай байгаа тул өмнө худалдан авсан нүүрсээ буцаан өгсөн гэх санхүүгийн бүртгэл хийж, ТУЗ-ийн шийдвэр гаргуулсан байна. Гэтэл тус 323.0 мян.тн нүүрсийг буцаан орлогод авсан орлогын баримт падаан байхгүй, тооцоо нийлсэн акт байхгүй, ажлын хэсгийн нүүрсийг хэрхэн буцааж авсан тухай тэмдэглэл байхгүй байв. Энэ талаар “Тавантолгой” ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч, санхүүгийн холбогдох хэлтсийн ажиллагсад тодорхой тайлбар гаргаж өгөөгүй болно.

3.26 Гүйлгээг шалгах зорилгоор санхүүгийн программ хангамжийн компани болох “Интерактив би ай” ХХК-д хандаж, 18.5 тэрбум төгрөгийн авлагын бүртгэлийг хэзээ бууруулж бичсэн талаар санхүүгийн программын бүртгэлээс /лог/ нягтлан үзэхэд “Тавантолгой транс” ХХК-аас авах авлагыг анх 2015.01.01-ний өдөр бус 2016.09.05-ны өдөр үүсгэж, 2019.4.24-ний өдөр гүйлгээг засварласан байна. Түүнчлэн орон сууц гэсэн утга бүхий гүйлгээг мөн адил засварласан байна

3.27 “Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн дарга нь 2015.08.27-ны өдөр 136 дугаартай 123 мянган тонн нүүрсийг өр төлбөртөө буцаан авах тухай тогтоол, “Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн дарга нь 2015.12.17-ны өдөр 16а дугаартай 199 мянган тонн нүүрсийг өр төлбөртөө буцаан авах тухай тогтоол тус тус гаргасан. Гүйцэтгэх захирлын 2015.03.09-ний өдрийн тушаалаар “Тавантолгой транс” ХХК-ийн худалдан авсан нүүрсний үлдэгдлийг тооцох 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг тус компанийн төлөөллийг оролцуулан байгуулжээ.

3.28 Гэтэл 123 мянган тонн, 199 мянган тонн нүүрсийг буцаан авах тухай тогтоол гарахаас өмнө 323 мянган тонн нүүрсийг буцаан авах тогтоол гарч байсан нь өмнөх түр хорооны ажлын хэсгийн баримтаас олдсон. “Тавантолгой” ХК-ийн албан бичгийн хариугаар болон компанийн архиваас гаргаж өгсөн ТУЗ-ийн хурлын тогтоол, тэмдэглэлд 323 мян.тн нүүрс буцаан өгөх тухай ТУЗ-ийн тогтоол олдоогүй. Мөн ТУЗ-ийн хурлын 2015 оны тэмдэглэлийн 9 дүгээр хуудас байхгүй байсан нь тухайн асуудлыг хэлэлцсэн тэмдэглэл байсан. Энэ нь үйлдлээ нуух оролдлого байх боломжтой байна.

3.29 Гаалийн байгууллагаас авсан мэдээллээр “Тавантолгой транс” ХХК нь “Тавантолгой” ХК-иас худалдан авсан нүүрсний үлдэгдэл 123 мян.тн нүүрсийг “ЭНК” ХХК-ийн талбайд буулгасан байна. “ЭНК” ХХК-ийн гаалийн хяналтын бүс дээр байсан 123 мян.тн нүүрсийг экспортолсон буюу худалдсан байна.

3.30 Түүнчлэн “Тавантолгой транс” ХХК өр төлбөртөө тооцуулан 3.4 тэрбум төгрөгөөр үнэлсэн Өмнөговь аймгийн Даланзадгад сум дээрх дутуу баригдсан орон сууцыг Тавантолгой ХК-д ТУЗ-ийн шийдвэрээр өгсөн байна. Тухайн орон сууцыг худалдан авах төлөвлөгөө байхгүй бөгөөд ТБОНӨХБАУХАТХ-ийн дагуу тендер сонгон шалгаруулалт зарлаагүй худалдан авсан байна.

- 3.4 тэрбум төгрөгийн дутуу баригдсан 48 айлын орон сууцыг “Тавантолгой” ХК өөрийн хөрөнгөөр дуусган, 41 орон сууцыг үнэ төлбөргүй болон тодорхой хэмжээний хөнгөлөлттэй үнээр зарим ажилтанд олгосон, 7 орон сууц “Тавантолгой” ХК-ийн нэр дээр бүртгэлтэй байна.

3.31 “Тавантолгой” ХК-ийн гадаад борлуулалтын падааныг архивын нэгж баримтуудаас шүүж үзэхэд “Тавантолгой транс” ХХК-д 2013-2016 онд нийт 1,776,993.27 тонн нүүрсийг худалдан борлуулсан болох нь нүүрсний падаан, нүүрсний тайлан /нэгтгэл/ баримтуудаар тогтоогдож байна.

3.32 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*” гэж заасныг зөрчиж “Тавантолгой транс” ХХК-ийн худалдан авсан нүүрсийг буцаан авсан гэж санхүүгийн анхан шатны баримтгүй буюу буцаан орлогод авсан бараа материалын орлогын баримт байхгүй байхад ажил гүйлгээг бүртгэсэн байна.

3.33 Шинжээчийн дүгнэлтээр урьдчилсан байдлаар хуурамч бичилт хийсэн байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тул хуулийн байгууллагад авлагын асуудлыг шилжүүлэх шаардлагатай гэж үзэв.

“Тавантолгой” ХК-ийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаа

3.34 “Тавантолгой” ХК-ийн 2013-2022 онуудад зохион байгуулсан худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг хянан үзэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.35 “Тавантолгой” ХК нь 2013-2022 онд нийт 24.4 тэрбум төгрөгийн дизель түлш, шатахуун, хоол, хүнс нийлүүлэх, сэлбэг түрээслэх, даатгалын үйлчилгээ зэрэг бараа, үйлчилгээг сонгон шалгаруулалтгүйгээр худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасантай нийцэхгүй байна.

3.36 Дээрх онуудад нийт 115.5 тэрбум төгрөгийн тендер шалгаруулалт зохион байгуулснаас 57.0 тэрбум төгрөгийн тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд зөрчил, дутагдалтай байна гэж дүгнэсэн бөгөөд худалдан авах ажиллагааны төлөвлөлт хангалтгүй, оновчгүй байгаа нь худалдан авах ажиллагаа үр ашиггүй, хариуцлагагүй зохион байгуулагдах үндэс болж байна.

3.37 Тендерийн баримт бичиг боловсруулахдаа техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, бусад шалгуур шаардлагыг зохих ёсоор заадаггүй, үнэлгээг хийхдээ шаардлага хангаагүй оролцогчид гэрээ байгуулах эрх олгодог, гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 хоногийг хүлээлгүйгээр гэрээ байгуулдаг зэрэг зөрчил илэрлээ.

3.38 Худалдан авах ажиллагааны хавтаст хэргийн бүрдэл дутуу, 2007-2012 онуудад зохион байгуулсан тендер шалгаруулалтын хавтаст хэрэгт шалгарсан компанийн тендерийн материалыг архивын нэгж болгож, хадгалаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт нийцэхгүй байна.

“Тавантолгой” ХК-д эрх бүхий байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтууд, тэдгээрийн үр дүнд авсан арга хэмжээ

Төрийн аудитын байгууллагын хяналт, шалгалт

3.39 Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар нь “Тавантолгой” ХК-ийн 2009-2016 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын тайланг Өмнөговь аймаг дахь ТАГ-ын даргын 2018 оны “Аудитын тайланг баталгаажуулах тухай” А/15 дугаар тушаалаар баталгаажуулсан байна.

- *Аудитаар 344,458.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 5,884.7 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасныг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж, 338,430.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 142.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.*
- *Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн “Тавантолгой” ХК-ийн ТУЗ-д 3 зөвлөмж, Гүйцэтгэх захиралд 9 зөвлөмж өгсөн байна.*

3.40 Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар нь “Тавантолгой” ХК болон эрх бүхий хувийн аудитын компани хооронд байгуулсан гурвалсан гэрээ /хэлцэл/-г үндэслэн “Тавантолгой” ХК-ийн тухайн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудитыг гүйцэтгүүлж ирсэн бөгөөд АТГ, ТЕГ, ЦЕГ-ын хамтарсан ажлын хэсэг мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотойгоор 2022 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

- *“Дөлгөөн хайрхан уул аудит” ХХК 2012 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт,*
- *“Их Монгол хөлөг аудит” ХХК 2013, 2014, 2020 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй санал дүгнэлт”,*
- *“Пантер мидланд аудит” ХХК 2015, 2016 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй санал дүгнэлт”,*
- *“Юнистар аудит” ХХК 2017, 2018, 2019 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй санал дүгнэлт”,*
- *“Гэрэлт хөхийн тэнцвэрт аудит” ХХК 2021 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй санал дүгнэлт”,*

3.41 Өмнөговь аймгийн Төрийн аудитын байгууллага 2012, 2015, 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг хянаж баталгаажуулаагүй, 2016 оны тайлан байгууллагын архивт байхгүй, баримт бичгийн иж бүрдэл дутуу, Өмнөговь аймгийн Архивын тасгаас 2023

оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 52 дугаар албан бичигт “Ардын хянан шалгах хороо, Аймгийн аудитын хөмрөгт Тавантолгой ХК-ийн 1995-1999, 2003-2005, 2008 онд хяналт шалгалт хийсэн материал байхгүй байна” гэж дурдсан байна.

3.42 Төрийн аудитын тухай хуульд: “санхүүгийн тайлангийн аудит гэж шалгаагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулахыг”, Монгол Улсын Ерөнхий аудитор “аудитын тайланг баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Хуульд “Монгол Улсын Ерөнхий аудитор энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ зарим хэсгийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч болон тэргүүлэх аудиторт шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь Монгол Улсын Ерөнхий аудиторыг энэ хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэснийг хэрэгжүүлээгүй, байгууллагын дотоод хяналт хангалтгүй ажилласан байна гэж үзэхээр байна.

Татварын байгууллагын хяналт, шалгалт

3.43 Татварын байгууллагаас “Тавантолгой” ХК-ийн 2006-2016 оны үйл ажиллагаанд дараах татварын хяналт шалгалт хийсэн бөгөөд 2020-2023 онд тус компанийг “Өндөр эрсдэлтэй” гэж тодорхойлсон хэдий ч 2016 оноос хойш татварын иж бүрэн шалгалт хийгээгүй байна.

Хүснэгт 10 Татварын байгууллагаас “Тавантолгой” ХК-д татварын ногдуулалт, төлөлтийн байдал хяналт шалгалт хийсэн мэдээлэл

№	Хяналт, шалгалт явуулах шийдвэрийн агуулга	Татварын улсын байцаагчийн акт баталгаажсан огноо
1	Татварын ерөнхий газрын даргын баталсан удирдамжаар 2006 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийсэн.	2007.10.08
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2009 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтэд хийх шалгалтын удирдамжаар 2004-2008 оны татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийсэн.	2009.4.14
3	Татварын ерөнхий газрын даргын татварын хяналт шалгалт хийх томилолт, Татварын хяналт шалгалт хийх ерөнхий удирдамжийн дагуу 2009-2013 оны татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийсэн.	2014.7.31
4	Татварын ерөнхий газрын даргын татварын хяналт шалгалт хийх ерөнхий удирдамжийн дагуу 2014-2015 оны татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хийсэн Төлөвлөгөөт (бүрэн) шалгалт хийсэн.	2016.12.20

Эх сурвалж: Татварын Ерөнхий газар

3.44 Татвар нөхөн ногдуулах, алданги, торгууль ногдуулах хөөн хэлэлцэх хугацааг УИХ-аас 2008 онд баталсан Татварын ерөнхий хууль /хүчингүй болсон/-д 5 жил, УИХ-аас 2019 онд баталсан Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-д 4 жил гэж тус тус хуульчлан тогтоосон бөгөөд 2016-2019 онд хамаарах татвартай холбоотой хэрэг, зөрчлийг “хөөн хэлэлцэх хугацаа” дуусгавар болсон үндэслэлээр хэрэгсэхгүй болгох нөхцөл бүрдсэн байж болзошгүй байна.

3.45 Татварын хяналт шалгалтын хүрээнд татварын улсын байцаагчийн тогтоосон актыг Татварын маргаан таслах зөвлөл /ТМТЗ/-өөр хэлэлцэж дараах шийдвэр гаргаж байжээ.

Хүснэгт 11 Татварын улсын байцаагчийн акт, ТМТЗ-өөр шийдвэрлэсэн байдал /сая төгрөг/

№	Шалгалтын хамарсан огноо	Актын огноо, дугаар	Актын дүн	ТМТЗ-ийн тогтоолын огноо дугаар	ТМТЗ-өөр шийдвэрлэсэн дүн	Тайлбар
1	2006	2007.10.08 №210886	1,797.4	2007.11.15, №28	1,797.4	Улсын байцаагчийн дүнг хэвээр үлдээсэн
2	2004-2008	2009.4.14 №0300908	80,452.6	2009.09.25, №24	80,435.8	Улсын байцаагчийн актыг 16.7 сая төгрөгөөр бууруулсан
3	2009-2013	2014.7.31 №210003850	4,492.4	2015.01.28, №02	1,181.3	Улсын байцаагчийн актыг 3.8 дахин бууруулсан
4	2014-2015	2016.12.20 №210022536	506.0	2017.04.28, №24	9.1	Улсын байцаагчийн актыг 56 дахин бууруулсан

Гаалийн байгууллагын хяналт, шалгалт

3.46 Гашуунсухайт дахь Гаалийн газраар 2010-2011 онд экспортод гарсан нүүрсний гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа Монгол Улсын Гаалийн тухай хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийн байдалд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, хууль тогтоомж хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх зорилготой ажлын хэсэг шалгалтын илтгэх хуудас бичиж, 2013 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр баталгаажуулж, Гаалийн улсын байцаагчийн дүгнэлт, нотлох баримтуудыг Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн III хэлтэст 2013 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 10/13 дугаартай албан бичгээр хүргүүлжээ.

- *2010.01.01-ний өдрөөс 2011.07.01-ний өдрийн хооронд Гашуунсухайт боомтоор 3758 тээврийн хэрэгслээр 379.0 мян.тн нүүрсийг Гаалийн байгууллагад мэдээлэлгүйгээр хууль бусаар хил нэвтрүүлсэн гэх асуудал урьдчилсан байдлаар тогтоогдсон байна.*

3.47 Гаалийн байгууллагаас ирүүлсэн Улсын байцаагчийн дүгнэлтийг УМБГ-ын Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн Ахлах мөрдөн байцаагч, ахмад н.Наранхүү 2013 оны 8 дугаар сарын 01-ний өдөр 201301000318 тоот хэрэг үүсгэн шалгасан бөгөөд Нийслэлийн прокурор хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24.1.1-д заасны дагуу хэрэгсэхгүй болгосон байна.

3.48 “Тавантолгой” ХК-ийн 2013-2017 онд экспортолсон, импортолсон барааг гаалийн байгууллагад үнэн зөв мэдүүлсэн эсэхийг гадаад худалдааны болон санхүүгийн баримтад тулгуурлан шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх шалгалтаар Бүрдүүлэлтийн дараах шалгалтын илтгэх хуудас бичиж, 2018 оны 7 дугаар сарын 09-ний өдөр баталгаажуулсан байна.

- *Шалгалтаар БНХАУ-аас импортоор авсан 745.2 сая төгрөгийн үнэ бүхий сэлбэг хэрэгсэл болон барааны тоо хэмжээ, үнийн дүнг дутуу мэдүүлэн гаалийн болон бусад албан татвар төлөхөөс зайлсхийснийг тогтоож, зөрүү татвар болох 115.5 сая төгрөг, төлбөл зохих татварын торгууль 34.6 сая төгрөг, нийт 150.2 сая төгрөгийг нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна.*

3.49 Сангийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай 109 дүгээр тушаалаар баталсан бүрэлдэхүүнд Гаалийн байгууллагын төлөөлөл орсонтой холбогдуулан тус газарт дэд ажлын хэсэг байгуулж, Гашуунсухайт дахь гаалийн газрын үйл ажиллагаа, экспортын гаалийн бүрдүүлэлтийг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг 2013-2017 оны байдлаар шалгах, үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын хэсэг ажилласан байна.

- *Шалгалтаар хилээр нүүрс тээвэрлэсэн автомашины судалгааг гаргах ажлын хүрээнд гаалийн байгууллагад 2013-2017 оны хооронд олон удаагийн давтамжаар 3964 машин хоосон гэж мэдүүлж улсын хилээр гарсан нь нүүрс тээвэрлэсэн байх магадлалтай тул шалгуулахаар Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанд 2018 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 01-2/3351 дугаар албан бичгээр, Сангийн яаманд 2018 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 01-2/3305 албан бичгээр тус тус хүргүүлсэн байна.*

3.50 “Тавантолгой транс” ХХК-ийн 2013-2017 онд импортолсон болон экспортолсон барааг гаалийн байгууллагад үнэн зөв мэдүүлсэн эсэхийг гадаад худалдааны болон санхүүгийн баримтад тулгуурлан шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөх шалгалтыг хийж бүрдүүлэлтийн дараах шалгалт хийсэн тухай Бүрдүүлэлтийн дараах газар илтгэх хуудас бичиж, 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдөр илтгэл хуудсыг баталгаажуулсан байна.

- *Шалгалтын бүрэлдэхүүнд холбогдох журнал, тайлан /бараа материалын тайлан, гадаад дотоод харилцаагчийн өглөг, авлагын тооцоо, касс, харилцахын тайлан, үндсэн хөрөнгийн тайлан, гүйлгээ баланс, ерөнхий журнал г.м холбогдох тайлан, журнал, туслах дансдын гүйлгээ/-г гаргаж өгөөгүй, гаргаж өгсөн баримт нь гаалийн байгууллагад үнэн зөв мэдүүлсэн эсэхэд дүгнэлт өгөхөд хангалтгүй байсан тул энэ тухай Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын удирдлагад танилцуулж цаашид шалгалтыг үргэлжлүүлэх боломжгүй гэж үзэж зогсоосон байна.*

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт нүүрсний үйл ажиллагаатай холбогдолтой газар олголтын байдал

3.51 Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт 2020-2023 онд 188 хуулийн этгээдэд эзэмших эрхийн гэрчилгээгээр, 774 иргэнд эзэмших эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлж, 12

хуулийн этгээдэд ашиглуулах эрхийн гэрчилгээгээр ашиглуулж, 445 иргэнд өмчлөх эрхийн гэрчилгээр газар өмчлүүлсэн байна.

3.52 Өмнөговь аймгийн Ханбогд сумын хэмжээнд 2020-2022 оны хооронд эрх бүхий этгээдийн шийдвэр гарч иргэн, хуулийн этгээдэд шинээр олгосон болон эрх шилжүүлэх, талбайн хэмжээ өөрчлөх зэрэг шилжилт хөдөлгөөн хийдсэн газар олголтын байдалд хэсэгчилсэн байдлаар дуудлага худалдааны анхны үнэ төлөгдөөгүй олгогдсон болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд олгогдсон газрыг хамруулан хяналт шалгалт хийсэн.

3.53 Мөн Газрын тухай хуулийн 33.1.2-т “энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.” гэж заасныг зөрчиж дуудлага худалдаа зохион байгуулахгүйгээр, дуудлага худалдааны анхны үнэ төлөгдөөгүй байхад газар эзэмшүүлсэн байна.

3.54 Хяналт шалгалтаар Үндсэн хууль Гуравдугаар зүйлийн 5-д “Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.” гэж заасныг, Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8.-д “Газар ашиглах эрхийн гэрчилгээ” гэж энэ хуулийн дагуу гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүний газар ашиглах эрхийг баталгаажуулсан баримт бичгийг., 6 дугаар зүйлийн 6.3-т “Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүн тодорхой зориулалт, хугацаа, болзол, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу газар ашиглагч байж болно.” 44 дүгээр зүйлийн 44.5-д “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг Засгийн газар тогтооно.” гэж заасныг зөрчиж Өмнөговь аймгийн Ханбогд суманд гаалийн хяналтын талбай, автотээврийн зогсоол, кемпийн зориулалттай газрыг 2020-2022 онд дуудлага худалдаагаар худалдаагүй бөгөөд дуудлага худалдааны анхны үнэ төлөгдөөгүй байхад газар олгон дараа нь нөхөн төлүүлж, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалттай 34 аж ахуйн нэгжид, 42 эзэмших эрхийн гэрчилгээгээр 475.3 га газар олгосон байна. Мөн 2 хуулийн этгээдэд 4100 га газрыг эрчим хүчний зориулалтаар хууль бусаар газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон байна. Үүнд:

- *Нэгдүгээрт, газрын дуудлага худалдааны үнэ төлөөгүй байхад газар олгодог. Дуудлага худалдааны анхны үнэ төлөгдөөгүй 81.5 га газрыг 11 аж ахуй нэгжид олгосон. /Энэ нь зөвхөн Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын албан бичгээр ирүүлсэн хүрээнд болно./ Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт 2020-2023 онд 188 хуулийн этгээдэд эзэмших эрхийн гэрчилгээгээр, 774 иргэнд эзэмших эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлж, 12 хуулийн этгээдэд ашиглуулах эрхийн гэрчилгээгээр ашиглуулж, 445 иргэнд өмчлөх эрхийн гэрчилгээр газар өмчлүүлсэн байна. Эдгээр газруудад дуудлага худалдаа зохион байгуулаагүй бөгөөд зарим газрын дуудлага худалдааны анхны үнийн доод үнийг газрын гэрчилгээ гарсны дараа нөхөн төлүүлсэн байна.*
- *Хоёрдугаарт, нүүрсний үйл ажиллагаатай холбоотой автотээврийн зогсоол, гаалийн хяналтын талбай, кемп гэх мэт зориулалттай 1-40 га, нийт 475.3га газрыг шууд болон шууд бус гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд их хэмжээгээр олгосон байна. Эдгээр газрыг олгохдоо дуудлага худалдааны анхны үнэ төлөгдөөгүй байхад олгож, дараа нь нөхөн төлүүлж ирсэн байна. Тавантолгой ХК гаалийн хяналт, нүүрсний талбайн зориулалтаар 12 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 20 га газар худалдаж авах тендер зарласан байна. /Нэг га газар нь 600 сая төгрөгийн төсөвт өртөгтэй./ Гадаадын хөрөнгө оруулалттай компани эзэмшиж буй газраа 11.5 тэрбум төгрөгөөр худалдах санал өгч байсан байна. Энэ нь тухайн гаалийн хяналтын талбай, автотээврийн зогсоол, кемп гэх мэт зориулалттай газрын зах зээлийн үнэлгээг харуулсан нотлох баримт болсон байна.*
- *Гуравдугаарт, эрчим хүчний зориулалттай 100га, мөн 4000га газрыг эзэмших эрхийн гэрчилгээгээр гадаадын хөрөнгө оруулалттай 2 компанид олгосон байна.*

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2010-2017 оны худалдан авах ажиллагаа, санхүүжилтийн үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцсэн эсэх

Он	ХАА-ны тоо	Төсөвт өртөг
2011	-	-
2012	-	-
2013	-	-
2014	82	438,460.09
2015	125	81,298.05
2016	164	175,898.84
2017	191	261,162.49
2018	354	814,137.55
2019	276	3,724,115.85
2020	181	976,554.10
2021	243	4,610,093.78
2022	439	3,411,329.11
2023	374	4,067,560.81
Нийт	2429	18,560,610.66

3.55 Эрдэнэс Тавантолгой Хувьцаат компанийн 2011-2023 онд зохион байгуулсан, компанийн өөрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайлан, зарим тендер шалгаруулалтын баримтыг хянан үзсэн. /2011-2013 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг архивын баримтаар болон цахим сууриар хадгалаагүй тул нягтлах боломжгүй байсан/

3.56 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2011-2023 оны худалдан авах ажиллагааны нийт төсөвт өртгийг төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний тоогоор харуулбал:

3.57 2014-2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 18.56 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 2,429 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулахаар төлөвлөж, захиалагч төлөвлөгөөг баталсан байна. /Шууд худалдан авалтын тоо, үнийн дүн ороогүй/.


3.58 Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ /цаашид “цахим систем” гэх/-д компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2017 оноос нийтэлж эхэлсэн байна. Тендер шалгаруулалтыг хуулийн 7 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулсан байдлыг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт 13. Худалдан авах ажиллагааны журам сонгосон байдал: /сая.төг/

Он	Тендер шалгаруулалтын арга				ТШ-ын тоо	Гэрээний дүн
	Нээлттэй тендер шалгаруулалт	Харьцуулалтын арга	Гэрээ шууд байгуулах арга	Зөвлөх үйлчилгээ		
2011	-	28	19	2	49	3,613.2
2012	-	-	-	-	-	-
2013	-	-	-	-	-	-
2014	-	-	-	-	-	-
2015	22	13	-	2	37	4,650.0
2016	7	15	-	1	23	6,045.9
2017	34	14	6	3	57	216,972.6
2018	38	36	16	10	100	104,621.6
2019	77	22	10	11	120	1,949,471.7
2020	51	22	13	6	92	910,759.5
2021	76	29	12	10	127	4,000,490.8
2022	123	34	30	6	193	2,579,061.1
2023	77	28	13	13	130	2,580,074.7
Нийт	505	241	119	64	928	12,355,761.0

3.59 2011-2023 онд нийт 928 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа дараахь байдлаар зохион байгуулсан байна:

- Нээлттэй тендер шалгаруулалт 505;
- Харьцуулалтын арга 241;
- Гэрээ шууд байгуулах 119;
- Зөвлөх үйлчилгээний журам 64.




3.60 Дээрх графикаас харахад 2011-2023 онд худалдан авах ажиллагааны журмын хувьд нээлттэй тендер шалгаруулалт 54 хувь, харьцуулалт 26 хувь, гэрээ шууд байгуулах 13 хувь, зөвлөх үйлчилгээний журмаар 7 хувь тус тус зохион байгуулсан байна.

Хүснэгт 14. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулсан байдал /сая.төгрөг/

Он	Төлөвлөгөө		Гэрээ хийгдсэн ХАА-ны тоо			Хэрэгжээгүй ХАА	
	ХАА-ны тоо	Төсөвт өртөг	ХАА-ны тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	ХАА-ны тоо	Төсөвт өртөг
2011	-	-	49	143.5	3,613.2	-	-
2012	-	-	-	-	-	-	-
2013	-	-	-	-	-	-	-
2014	82	438,460.0	-	-	-	-	-
2015	125	81,298.0	37	3,080.5	4,650.0	88	78,217.5
2016	164	175,898.9	23	6,738.8	6,045.9	141	169,160.0
2017	191	261,162.5	57	231,189.7	216,972.6	134	29,972.7
2018	354	814,137.5	100	224,860.2	104,621.6	254	589,277.3
2019	276	3,724,115.8	120	2,043,678.6	1,949,471.7	156	1,680,437.2
2020	181	976,554.1	92	920,173.1	910,759.4	119	56,452.8
2021	243	4,610,093.8	127	4,011,969.0	4,000,490.8	139	598,124.7
2022	439	3,411,329.1	193	2,780,834.5	2,579,061.0	311	630,494.6
2023	374	4,067,560.8	130	2,738,834.9	2,580,074.7	244	1,328,725.9
Нийт	2429	18,560,610.7	928	12,961,502.9	12,355,761.0	1586	5,160,862.9

3.61 2011-2013 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг архивын нэгж болгон хадгалаагүй боловч, 2011 онд 49 төсөл, арга хэмжээний 3.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ байгуулсан тухай тайлан байна. 2014 онд 438.5 тэрбум төгрөгийн төсөв өртөгтэй 82 төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг баталсан боловч, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан талаар тайлан, мэдээлэл ирүүлээгүй. 2015-2023 оны худалдан авах ажиллагааны тайлан, мэдээллийг ирүүлсэн.

График Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт



3.62 2014-2023 онд 2,429 төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс, 37 хувь буюу 928 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан бол, 63 хувь буюу 1,586 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

3.63 2014-2023 онд төлөвлөсөн тендер шалгаруулалтын 14-50 хувийг зохион байгуулсан нь худалдан авах ажиллагааны үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдөөгүй байна. Дээрх онуудад худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 50-86 хувь нь хэрэгжээгүй байна.

Хүснэгт 15. Хэрэгжээгүй төсөл арга хэмжээ

Он	Тендер шалгаруулалтын арга				ТШ-ын тоо	Төсөвт өртөг
	Нээлттэй тендер шалгаруулалт	Харьцуулалтын арга	Гэрээ шууд байгуулах арга	Зөвлөх үйлчилгээ		
2011	-	-	-	-	-	-
2012	-	-	-	-	-	-
2013	-	-	-	-	-	-
2014	-	-	-	-	-	-
2015	73	17	-	-	90	78,361.0
2016	90	52	-	-	142	169,168.5
2017	95	48	-	-	143	30,402.1
2018	66	84	-	120	270	590,923.5
2019	18	92	-	56	166	1,688,077.2
2020	52	47	1	19	119	56,452.8
2021	64	39	13	23	139	598,124.7
2022	165	74	3	69	311	630,494.6
2023	157	52	3	32	244	1,328,725.9
Нийт	780	505	20	319	1624	5,170,730.4

3.64 2011-2023 онд нийт 5,170,730.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,624 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулсан талаар

3.65 2011-2023 онд дараах байдлаар гэрээ шууд байгуулах аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Хүснэгт 16. Гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулсан байдал:

Он	Гэрээ шууд байгуулах тайлан						
	ХАА-ны төлөвлөгөөнд		Хэрэгжсэн			Хэрэгжээгүй	
	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
2011	-	-	19	-	1,847.0	-	-
2012	-	-	-	-	-	-	-
2013	-	-	-	-	-	-	-
2014	-	-	-	-	-	-	-
2015	-	-	-	-	-	-	-
2016	-	-	-	-	-	-	-
2017	-	-	6	239.3	141.0	-	-

2018	-	-	16	1,646.2	1,207.7	-	-
2019	-	-	10	7,640.0	6,924.0	-	-
2020	-	-	13	804,064.8	803,424.5	1	25.0
2021	25	1,162,275.8	12	978,185.1	976,561.1	13	184,090.7
2022	6	988,142.9	30	975,311.4	974,413.4	3	14,046.4
2023	15	662,768.7	13	13,051.7	1,222.5	3	649,717.0
Нийт	46	2,813,187.4	55	1,966,548.2	1,952,197.0	19	847,854.1

3.66 2011-2023 онд хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3-т заасан нөхцөл үүссэн /энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл гэрээ шууд байгуулах/ тул гэрээ шууд байгуулах аргаар 55 тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээ байгуулсан байна.

Шууд худалдан авалтын талаар

3.67 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т үндэслэн Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг тогтоосон бөгөөд 2021 онд нэмэгдүүлэн өөрчилсөн.

3.68 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд босго үнийн дээд хязгаараас давсан төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 17. Шууд худалдан авалтын хэрэгжилт

Он	Шууд худалдан авалтын тайлан						
	ХАА-ны төлөвлөгөөнд		Хэрэгжсэн			Хэрэгжээгүй	
	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
2011	-	-	-	-	-	-	-
2012	-	-	-	-	-	-	-
2013	-	-	-	-	-	-	-
2014	2	20.0	-	-	-	-	-
2015	30	150.6	-	-	-	-	-
2016	99	456.9	-	-	-	-	-
2017	84	866.8	-	-	-	-	-
2018	190	1,080.1	-	-	-	-	-
2019	237	1,705.4	-	-	-	-	-
2020	183	1,794.4	144	790.6	549.8	37	932.0
2021	226	2,944.5	150	2,674.1	1,475.8	80	673.7
2022	180	3,488.8	176	3,224.3	2,472.3	70	1,038.2
2023	187	2,862.6	121	1,156.8	872.0	66	1,705.8
Нийт	1418	15,370.1	591	7,845.8	5,369.8	253	4,349.6

3.69 2014-2019 онд шууд худалдан авалтаар 4.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 642 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн боловч, гүйцэтгэлийн тайлан, мэдээлэл ирүүлээгүй байна.

3.70 2020-2023 онд шууд худалдан авахаар 11.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 776 төсөл, арга хэмжээ худалдан авахаар төлөвлөснөөс 7.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 591 төсөл, арга хэмжээний гэрээг байгуулсан.

- 2020 онд 1,794.4 сая төгрөгийн үнийн дүн бүхий 183;
- 2021 онд 2,944.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий 226;
- 2022 онд 3,488.79 сая төгрөгийн үнийн дүн бүхий 180;
- 2023 онд 2,862.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий 187 төсөл арга хэмжээг худалдан авахаар төлөвлөсөн байна.

3.71 Хянан шалгагч, шинжээч нар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2011-2023 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд хяналт хийх, нотлох баримтыг шинжлэн судлахдаа түүврийн аргаар дор дурдсан аж ахуйн нэгжийн тендер шалгаруулалтын баримт бичгийг нягтлан шалгаж, дараах сэдвээр нээлттэй сонголд мэдээлэл бэлтгэж танилцууллаа. Үүнд:

- Хөрс хуулалт, олборлолтын чиглэлээр;
- Уурхайн техник, хүнд даацын машин механизм борлуулах, засвар үйлчилгээ явуулах чиглэлээр;
- Өрөмдлөг, тэсэлгээний чиглэлээр;
- Уул, уурхайн программ хангамжийн чиглэлээр;

- *Тээврийн чиглэлээр;*
- *Үйлдвэрлэлийн байгууламжийн чиглэлээр /нойтон болон хуурай аргаар нүүрс баяжуулах үйлдвэр/;*
- *Лаборатори, шинжилгээний чиглэлээр;*
- *Оффис түрээсийн чиглэлээр;*
- *Харуул хамгаалалтын чиглэлээр;*
- *Усны барилга байгууламжийн чиглэлээр;*
- *Бусад чиглэлээр.*

3.72 Тендерийн баримт бичиг боловсруулахдаа техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, бусад шалгуур шаардлагыг зохих ёсоор заагаагүй, шаардлага хангаагүй оролцогчид гэрээ байгуулах эрх олгосон, хуульд заасан гүйцэтгэлийн баталгааны шаардлага хангаагүй оролцогчтой гэрээ байгуулсан, худалдан авах ажиллагааны үндсэн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг хамруулан төлөвлөгөөнд тусгаж, зохион байгуулсан, худалдан авах ажиллагаагааны зохих журмын дагуу зохион байгуулаагүй зэрэг нь холбогдох хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

3.73 Худалдан авах ажиллагааны хавтаст хэргийн бүрдэл дутуу, 2011-2015 онд зохион байгуулсан зарим тендер шалгаруулалтын хавтаст хэрэгт шалгарсан компанийн тендерийн материалын архивын нэгжийг үүсгэсэн боловч иж бүрдэл дутуу байгаа нь хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасан шаардлагыг биелүүлээгүй байна.

3.74 2011-2023 онд нийт 928 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулж, 12.4 их наяд төгрөгийн гэрээ байгуулснаас худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналт шалгалт хийлээ.

3.75 Нийт 11.5 их наяд төгрөгийн 92 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичгийг хянан үзэхэд 3,2 их наяд төгрөгийн дүн бүхий 38 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь хуульд нийцээгүй байна.

3.76 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хууль, түүнд нийцүүлэн гарсан хууль тогтоомжийн актад дараах байдлаар нийцээгүй байна. Үүнд:

- *ТББ-т заасан ерөнхий шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан 4;*
- *ТББ-т заасан техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан 7;*
- *ТББ-т заасан санхүүгийн болон бусад шаардлага хангаагүй 20;*
- *Тухайлсан оролцогчид тохируулан ТББ-ийг өөрчлөлт оруулсан 2;*
- *Хуулийн шаардлага хангаагүй гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн 7;*
- *Гэрээнд үндэслэлгүйгээр нэмэлт өөрчлөлт оруулсан 3;*
- *Тендер шалгаруулалт зохион байгуулсан эсэхийг нягтлах боломжгүй 2;*
- *Тендер сонгон шалгаруулаагүй 1.*

3.77 Хянан шалгагч, шинжээч зөрчил бүхий төсөл, арга хэмжээ тус бүрт шинжээчийн дүгнэлт гаргаж, нотлох баримтыг архивын баримтын шаардлагад нийцүүлэн ажиллалаа.

Хянан шалгах түр хорооны СОНСГОЛ II үе шат

ХШТХ-ны 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн “Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай” 22 дугаар тогтоолын дагуу нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын II үе шатанд нийт 342 гэрч оролцохоос 302 гэрчид гэрчид мэдэгдэх хуудас хүргүүлсэн бөгөөд үүнээс 199 гэрч оролцож, 72 гэрч оролцох боломжгүй байгаа тухай албан бичиг, өргөдөл хүсэлт ирүүлсэн байна.

Уг сонсголоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс борлуулалтын үйл ажиллагаа, нүүрс тээвэрлэлт, С зөвшөөрөл олголт, санхүүжүүлсэн төсөл, хараат болон охин компанид оруулсан хөрөнгө оруулалт, хяналт шалгалтын хүрээнд илэрсэн бусад асуудлын талаар танилцуулсан.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс борлуулалтын үйл ажиллагаа

3.78 АМТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1.4-д “ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий хуулийн этгээд ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах” гэж заасан хэдий ч “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нүүрсний зах зээлийн жишиг үнийг хасагдах зардлаар хорогдуулж “ам” нөхцөлийн үнэ тооцсон байна. Шалгалт хамрах хугацаанд үнэ тогтоох аргачлалыг 2011-2015 оны хооронд Чалко трейдинг хонгконг ХХК-ийн гэрээний үнэ тогтоох аргачлалаар, 2015-2016 оны хооронд суурь үнийг ТУЗ-ийн тогтоолоор баталж, улирал тутам индексийн дагуу суурь үнийг шинэчлэн тогтоох, 2017-2020 оны хооронд “Эрдэнэс Тавантолгой” ХК сонгон шалгаруулалтын доод үнийг зарлах бөгөөд доод үнийг тооцохдоо Ганцмод дахь коксжих нүүрсний үнээс татвар, тээвэр, бусад зардлыг хасах, 2020-2022 оны хооронд сонгон шалгаруулалтын доод үнийг тогтоохдоо индексийн дагуу шинэчлэн тогтоох, 2023 оноос биржийн арилжаагаар тогтоож байна. (*“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн өгсөн тайлбараар*)

3.79 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2011-2023 оны 10 сар хүртэл хугацаанд 398 гэрээгээр 110.1 сая тонн буюу 20.2 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн бөгөөд нийт нүүрсний борлуулалтын гэрээний сарын дундаж үнийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тухай бүр мөрдөгдөж байсан үнэ тогтоох аргачлалын үнэтэй харьцуулан нийт гэрээний үнийн зөрүүг тооцоход алдагдсан боломжийн зардал ойролцоогоор 826.4 сая доллар гарахаар байна.

3.80 БНХАУ-ын “Чалко Трейдинг Хонг Конг” компанитай 2011 онд байгуулсан А-011-041 тоот борлуулалтын гэрээний дагуу IV давхаргын коксжих чанартай, өндөр илчлэг бүхий нүүрсийг Инкотермсийн **FCA-Цагаанхад** нөхцлөөр борлуулахаар /*Өмнөговь аймаг Цагаанхад дахь гаалийн хяналтын талбайд хүлээлгэн өгөхөөр*/ тохиролцсон бөгөөд нийт борлуулалтын гэрээний үнийн зөрүү 2011-2023.10 сар хүртэл индексжсэн гэрээний дундаж үнэтэй харьцуулж тооцоход ойролцоогоор 422.0 сая ам долларын зөрүү гарахаар байна.

3.81 Нүүрсний борлуулалтын оффтейк 4 гэрээний алдагдсан боломжийн зардал индексжүүлсэн дундаж үнээр тооцоход ойролцоогоор **330.5 сая ам доллар** болохоор байна.

Хүснэгт 18 Борлуулалтын оффтейк гэрээний мэдээлэл /тн/

№	Компанийн нэр	Гэрээний дугаар	Гэрээ байгуулсан огноо	Анхны үнэ	Нүүрсний хэмжээ /тн/ К-коксжих, И-исэлдсэн, С-сул кокс	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	“Бодь интернэшнл” ХХК /ТТ-ГС төмөр замын санхүүжилт/	ЭТТ-2019/784	2019.11.13	К-60 \$	20,294,000	11,584,103.1	8,709,896.9
				И-9.5 \$	К-17,994,000	К-11,260,227.55	К-6,733,772.45
					И-2,300.000	И-323,875.55	И-1,976,124.45
2	“Бодь интернэшнл” ХХК /Богдхан төмөр замын санхүүжилт/	ЭТТ-2022/488	2022.06.27	К-128.94 \$	7,450,000	515,566.30	6,934,433.7
				И-36 \$	К-6,750,000	К-515,566.30	К-6,234,433.7
				С-90.26 \$	И-200,000	И-0	И-200,000
					С-500,000	С-0	С-500,000
3	Norinco International Cooperation Ltd and Glory Town Holdings Limited	ЭТТ-2022/223	2022.04.14	К-113.46 \$	К - 2,500,000	988,,119.0	К-1,511,881
4	Norinco International Cooperation Ltd and Glory Town Holdings Limited	ЭТТ-2022/253	2022.04.22	К-113.46 \$	К-3,420,000	К-1,061,286	К-2,358,713

***“Эрдэнэс тавантолгой” ХК-ийн мэдээлэл*

3.82 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2017 оноос сонгон шалгаруулалтаар нүүрс худалдан авагчийг сонгож эхэлсэн ч 2017 онд зохион байгуулагдсан зарим сонгон шалгаруулалт “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын А/02 дугаар тушаалын дагуу явагдаагүй байна. Тухайлбал:

- *Сонгон шалгаруулалтад оролцоогүй этгээдүүдтэй шууд гэрээ байгуулсан, барьцаа хөрөнгийг хугацаанд нь байршуулаагүй байхад гэрээ байгуулсан, сонгон шалгаруулалтаар ирүүлсэн үнийн саналаар бус, хямдруулан гэрээ байгуулсан, гэрээний үнийг нүүрсний ачилт дуусаагүй байхад бууруулсан байна.*

3.83 Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2023 оноос зөвхөн нээлттэй цахим арилжаагаар нүүрс борлуулж эхэлсэн. Гэвч оффтейк болон урт хугацаат гэрээнүүдийн хүрээнд нүүрсний борлуулалт

хийгдсээр байгаа тул 2023 онд борлуулсан нийт нүүрсний 13 хувийг биржээр борлуулсан байна.

3.84 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн пүүний мэдээлэл бүрэн цахимжаагүй бөгөөд 2011-2013 оны мэдээ цаасан баримтаар архивлагдан хадгалагдаж буй, 2016 онд пүүний сервер шатсанаас шалтгаалж өмнөх мэдээллүүд эксел файл хэлбэрээр хадгалагдаж байгаа, пүүний серверийн өгөгдлийн санд хандах, мэдээлэл устгах болон өөрчлөх эрхийн зохицуулалт тодорхой бус нөхцөл байдалтай байна. Үүнтэй холбоотойгоор уурхайн ачилтын зарим мэдээ устсан, гэрээний дугаар өөрчлөгдсөн зэрэг шалтгаанаар 2011-2013, 2015, 2019 онуудад пүүний мэдээ нь борлуулалтын тайлангаас ихээхэн хэмжээгээр зөрсөн байна.

3.85 Нүүрс борлуулах замаар уулын ажил гүйцэтгэгч нарын төлбөрийг барагдуулж болохоор уулын ажлын гэрээнд тусгасан байдаг. Энэ хүрээнд байгуулагдсан нүүрс худалдах, худалдан авах гэрээнүүдийг шалгахад тухайн онуудад “Эрдэнэс Тавантолгой” ХК-нд мөрдөж байсан индексжүүлсэн үнээс 12 хүртэлх хувийн хөнгөлөлт буюу нийт 12.69 сая ам.долларын үнийн хөнгөлөлт үзүүлсэн байна.

3.86 Түүнчлэн уулын ажил гүйцэтгэгч нартай байгуулсан нүүрсний борлуулалтын гэрээний сарын дундаж үнийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тухай бүр мөрдөгдөж байсан үнэ тогтоох аргачлалын үнэтэй харьцуулан нийт гэрээний үнийн зөрүүг тооцоход алдагдсан боломжийн зардал ойролцоогоор 76 сая доллар гарахаар байна.

Нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа /2011-2023.10 сарын тээврийн компаниуд болон С зөвшөөрөл/

3.87 ГЕГ-ын CAIS систем дэх гаалийн бүрдүүлэлтийн (дотоод манифест) мэдээлэлд 2011-2023 оны 10-р сарын 31-ны өдрийг хүртэлх байдлаар 487 компани 104,134 удаагийн давтамжаар нийт 188,5 сая тонн нүүрсийг Гашуунсухайт хилийн боомтоор экспорт хийсэн мэдээлэл бүртгэлтэй байсан бол НАБТ эрхлэгч 36 ААН-ээс ирүүлсэн пүүний программын өгөгдөлд 2014-2023 онд хамаарах 487 компани 59,928 удаагийн давтамжаар нийт 63,4 сая тонн нүүрсийг Цагаан хад суурьшлын бүсээс Гашуунсухайт-Ганцмод чиглэлд тээвэрлэсэн мэдээлэл бүртгэлтэй байсан болно.

3.88 Нүүрс ачих буулгах талбай /НАБТ/-н пүүний программд бүртгэгдсэн ачилтын мэдээлэл болон CAIS систем дэх гаалийн бүрдүүлэлтийн дотоод манифестын өгөгдлийг MS Access програм уншуулан тулган баталгаажуулалт хийхэд олон улсын тээврийн С-зөвшөөрөл бүхий 487 ААН-ээс 246 тээвэрлэгч нь нийт 52,030 удаагийн тээвэрлэлтээр нийт 5,2 сая тонн нүүрсийг улсын хилээр гаалийн бүрдүүлэлтгүй гаргасан байж болзошгүй байна.

3.89 *Жич: Хяналт шалгалтын үр дүнд “Цагаан хад” суурьшлын бүсэд байрлах мэдээллээ явуулсан 36 НАБТ-д бүрдүүлэлт хийсэн мэдүүлгүүд хамрагдсан болно. Эдгээр НАБТ-аас бусад Чингэлэг тээврийн терминал зэрэг НАБТ-ууд ороогүй тул цаашид шалгах шаардлагатай болно.

Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтэд ашиглагдах хил нэвтрэх зориулалттай “С” төрлийн зөвшөөрлийн талаар

3.90 Монгол Улс, БНХАУ-тай 1991 онд Засгийн газар хоорондын Автотээврийн хэлэлцээрийг байгуулж, 2011 оны 06 дугаар сарын 16-ны өдөр шинэчлэн баталж, хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам, БНХАУ-ын Зам, Тээврийн яам хоорондын протоколыг үйлдсэн байна.

- *Протоколын 1 дүгээр зүйлд “Эрх бүхий байгууллага нь Монгол Улсын хувьд Зам, тээврийн хөгжлийн яам, эрх олгогдсон байгууллага нь “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, БНХАУ-ын талаас эрх бүхий байгууллага нь Зам, тээврийн яам, эрх олгогдсон байгууллага нь ӨМӨЗО болон ШУӨЗО-ны Зам, харилцаа, тээврийн танхимууд байна” гэж заасан.*

3.91 Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны болон ШУӨЗО-ны Зам харилцаа, тээврийн танхимтай жил болгон зөвшөөрлийн бичгүүдийн тоог тохирч, тохиролцсон тоогоор зөвшөөрлийн бичгийг ижил тоогоор харилцан солилцож байна

- *“С” төрлийн зорчих зөвшөөрөл нь байнгын ачаа тээвэр хийх тээврийн хэрэгсэлд хэрэглэх бөгөөд олгосон өдрөөс эхлэн 90 хоногийн дотор олон удаа хил нэвтрэхэд хүчинтэй зөвшөөрлийн бичиг баримт бөгөөд БНХАУ-ын ӨМӨЗО-той 2010-2023 онд нийт 563,500 ширхэг “С” төрлийн зөвшөөрлийн бичгийг харилцан солилцсон байна. Эдгээр зөвшөөрлийн*

бичгүүдийг Замын-Үүд, Баянхошуу, Бичигт, Ханги, Гашуунсухайт, Шивээхүрэн, Хавирга зэрэг 7 боомтод ашиглаж байна.

3.92 Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Автотээврийн газрын дарга Б.Цэнгэлийн 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 267 дугаар тушаалаар улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх “С” төрлийн зөвшөөрлийн бичгийн үнэ тарифыг НӨАТ ороогүй дүнгээр 90,000 төгрөг байхаар тогтоосон бөгөөд өнөөг хүртэл үнэ тарифт өөрчлөлт ороогүй байна.

3.93 “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-иудаас нүүрс худалдан авч экспортолсон аж ахуйн нэгжүүдэд олгосон “С” төрлийн зөвшөөрлийн бичгийн 2010-2017 оны холбогдох анхан шатны бичиг баримт “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ болон Зам, тээврийн хөгжлийн яаманд байхгүй байгаа нь дээрх хугацааны “С” төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийн зарцуулалт олголтод хяналт шалгалт хийх боломжгүй нөхцөл байдал тогтоогдсон.

3.94 Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирлын тушаалаар 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд “Улс хоорондын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуйн, нэгж байгууллагын хүсэлтийг хууль тогтоомжид заасан шаардлага болон холбогдох дүрэм, журам, стандартын хүрээнд судалж дүгнэлт гаргах” нийт 13 ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс тээвэрлэлтэд оролцсон давхардсан тоогоор 1529 аж ахуйн нэгжийн 80,399 тээврийн хэрэгсэлд 171,872 ширхэг “С” зөвшөөрөл олгож ажилласан байна.

3.95 Улс хоорондын ачаа тээвэрлэлт хийх “С” зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагаанд дээд шатны болон хөндлөнгийн аудитын байгууллагаас ямар нэгэн хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд “Улс хоорондын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуйн, нэгж байгууллагын хүсэлтийг хууль тогтоомжид заасан шаардлага болон холбогдох дүрэм, журам, стандартын хүрээнд судалж дүгнэлт гаргах” ажлын хэсгийн дарга нар нь ажил үүргээ гүйцэтгэх явцдаа авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдож ял шийтгэгдэж байсан нь дээрх ажлын хэсгийг хууль ёсны шийдвэр гаргаж ажиллаж байсан эсэхэд эргэлзээтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

3.96 Нүүрс тээврийн үнэ нь хилийн татан авалт, нүүрсний үнэ, гаалийн хяналтын бүсэд хуримтлагдсан ачааны хэмжээ зэргээс хамаарч тогтмол өөрчлөгддөг учир тээврийн орлогыг нарийвчлан тооцох боломжгүй байна.

3.97 “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-иуд нь 2010-2022 онуудын хугацаанд олборлосон нүүрсээ, уурхайн ам нөхцөлөөр худалдан борлуулахдаа дэлхийн зах зээлийн дундаж үнэ ханшнаас доогуур үнээр худалдан борлуулж байсны улмаас худалдан авагч аж ахуйн нэгжүүд нүүрс тээвэрлэлтийн үнийг өсгөж байсан нь улс хоорондын ачаа тээвэрлэлт хийх “С” зөвшөөрлийн бичгийн эрэлтийг өсгөж байсан байна гэж дүгнэж үзэхээр байна.

Улсын хилээр хууль бусаар хил нэвтэрсэн асуудлын талаарх Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын мэдээлэл

Гаалийн ерөнхий газрын хяналт шалгалт, 2013 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 10/13 дугаар гаалийн улсын байцаагчийн дүгнэлтээр Гашуунсухайт боомтоор 2010-2011 онд экспортолсон нүүрсний бүрдүүлэлтэд хийсэн шалгалт, Гашуунсухайт боомтын 2013-2017 оны хооронд хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн мэдээллийг шалгасан тайлан, 2022 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн Гашуунсухайт боомт дахь цагаан хад суурьшилд байршилтай ГХБ-ийн мэдээллийн санд шалгалт хийсэн ажлын хэсгийн танилцуулга зэргийг шинжээч нягталж үзэхэд улсын хилээр гаалийн мэдүүлэг, бүрдүүлэлтгүй хил нэвтэрсэн байж болзошгүй асуудлыг Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн газрын шаардлагаар хяналт шалгалт хийж холбогдох хариуг хүргүүлж байсан мэдээлэлд үндэслэж танилцуулга хийгдсэн. Мөн шүүхийн шийдвэрийн хүрээнд товч мэдээлэл танилцуулсан болно.

3.98 Хил хамгаалах ерөнхий газрын шалгалтын явцад авто хилийн боомтуудаар 2015-2022 онд хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн мэдээлэл устгагдсан асуудал үүсч, ISM программын супер админ эрхээр сэргээн шалгаж үзэхэд хил нэвтэрсэн авто тээврийн хэрэгслийн мэдээлэл нь хэрэглэгчийн эрхээр шүүсэн тооноос 30,905 /Гашуунсухайт 19202, Замын-Үүд 6591, Шивээхүрэн 2368, Хавирга 612, Булган 548, Баянхошуу 531, Ханги 508, Бичигт 397, Бургастай 91, Сүмбэр 28, Байтаг 13, ХХЕГ 9, Даян 7/-аар илүү буюу идэвхигүй төлөвт шилжсэн байсан тул уг асуудлыг шалгуулахаар Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн газарт хандсан байна.

3.99 Гаалийн байгууллагын шалгалтаар Гашуунсухайт боомтоор 2013-2017 онд улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн мэдээг Хил хамгаалах ерөнхий газрын мэдээтэй он тус бүрээр тулган шалгасан байна. Шалгалтын гол хөндсөн асуудал хилээр хоосон гэж нэвтэрсэн боловч нүүрс ачиж хил нэвтэрсэн байж болзошгүй байна.

Хүснэгт 19 ХХЕГ-аас улсын хилээр гарсан тээврийн хэрэгслийн мэдээлэл болон Гаалийн байгууллагын автотээврийн хэрэгслийн бүртгэлийн программтай харьцуулсан судалгаа

Харьцуулалт	2017 он	2016 он	2015 он	2014 он	2013 он
<i>Хил хамгаалах байгууллагаас өгсөн тээврийн хэрэгслийн мэдээ</i>	274,552	217,365	103,774	141,565	111,885
<i>Хамтарсан манифестын сан</i>	265,873	213,283	96,151	135,039	105,267
<i>Ачаагүй нэвтэрсэн тээврийн хэрэгсэл /Хоосон/</i>	8,679	4,082	6,267	6,526	6,618

3.100 Гаалийн байгууллагын 2022 онд хийсэн дотоод хяналт шалгалтаар Гашуунсухайт боомтоор 2017-2018 онд зөвхөн манифестаар хил нэвтэрсэн байж болзошгүй гэх асуудлыг тогтоосон байна.

3.101 Гаалийн байгууллагын ажлын хэсгийн шалгалтаар 2022 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн Гашуунсухайт боомт дахь цагаан хад суурьшилд байршилтай ГХБ-ийн мэдээллийн санд хяналт шалгалт хийсэн тайланг гаргасан байна. /Хамрах хугацаа 2017-2022 оны 4 дүгээр сар дуустал/

3.102 Экспортын нүүрсний гаалийн мэдүүлэг болон хамтарсан манифестийн зөрүү гарсан байна. Шалгалтын явцад дээрх бүртгэлээс гадна Гаалийн бүрдүүлэлтийн CAIS программын экспортын нүүрсний гаалийн мэдүүлэг болон хамтарсан манифестын мэдээллийг хооронд нь тулган шалгахад дараах 2 төрлийн зөрчил илэрсэн байна.

- *Нийт 2208 гаалийн хамтарсан манифестаар 186,019.6 тонн нүүрс 2017-2018 онд экспортын гаалийн мэдүүлэггүй улсын хилээр гарсан. Нийт 2208 гаалийн хамтарсан манифестаар 186,019.6 тонн нүүрс 2017-2018 онд экспортын гаалийн мэдүүлэггүй улсын хилээр гарсан.*

Хүснэгт 20 Манифест, гаалийн мэдүүлгийн харьцуулалт

Он	Манифестын тоо	Тээврийн хэрэгслийн тоо	Нүүрсний жин /тн/
2017	343	281	23,873.8
2018	1865	1467	162,145.8
Нийт	2208	1748	186,019.6

- *Гаалийн мэдүүлгийн жин тоо манифестын жин тооноос зөрүүтэй, илүү манифест бичиж нүүрсийг гаргадаг хэлбэр бий болсон гэж үзсэн байна.*

3.103 Гаалийн ерөнхий газрын “CAIS” системийн манифестаар 1,906 тээврийн хэрэгслийн гарах бүртгэлийг шүүж үзэхэд 44 тээврийн хэрэгсэл гаалийн мэдүүлэг, бүрдүүлэлт олдоогүй тул хууль бусаар хил нэвтэрсэн байж болзошгүй байна.

3.104 Гашуунсухайт хилийн боомтоор 2021 онд 29 хуулийн этгээд, иргэдийн 44 тээврийн хэрэгсэл нүүрс тээвэрлэн хил нэвтэрсэн нь Хил хамгаалах байгууллагын мэдээллийн санд бүртгэгдсэн боловч Гаалийн мэдүүлэг, бүрдүүлэлт хийгдээгүй байж болзошгүй байна. Хил, гаалийн байгууллагаас хуулийн байгууллагад асуудлыг шилжүүлсэн байна.

Гашуунсухайт дахь хилийн боомтоор гаалийн бүрдүүлэлт хийгээгүй хил нэвтрүүлсэн гэх зарим асуудлыг шүүхийн шатанд шийдвэрлэсэн байдал

3.105 Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн эрүүгийн хэргийн шүүхийн 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 2023/шцт/58 дугаар шийтгэх тогтоолоор улсын хил хууль бусаар нэвсэрсэн асуудлыг шийдвэрлэсэн байна.

- *Гаалийн ерөнхий газрын Гашуунсухайт дахь гаалийн газарт Хэрэг бүртгэгч гаалийн улсын ахлах байцаагч Э нь гаалийн бүрдүүлэлт хийгээгүй, Хил хамгаалах ерөнхий газрын харьяа хилийн цэргийн 0131 дүгээр ангийн Гашуунсухайт боомтын шалган нэвтрүүлэх албаны баримт бичгийн шалгагч нар хилээр бүртгэлгүй гаргасан. Дээрх үйлдлээр албан хаагчид Э-ийн эзэмшлийн “Ханбогд инженеринг” ХХК-ийн ачааны тээврийн хэрэгслийг Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн. Мөн “Тэнгэр анд Тэнгис” ХХК 70-69ӨМЭ улсын дугаартай нүүрс ачсан тээврийн хэрэгслийг хууль бусаар хил нэвтрүүлсэн гэж үзсэн байна.*

- Шүүгдэгч Д.Э-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтад зааснаар “Эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд, Шүүгдэгч У.Д, М.Д, Ж.Д, Д.А нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлийн 4 дэх заалтад заасан “Хахууль авах” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсон байна.

3.106 Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн эрүүгийн хэргийн шүүхийн 2023 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 2023/шцт/26 дугаар шийтгэх тогтоолоор улсын хил хууль бусаар нэвтэрсэн асуудлыг шийдвэрлэсэн байна.

- Гашуунсухайт хилийн боомтоор “Ц х Транс” ХХК-ийн нүүрс ачсан ..-73 УАХ улсын дугаартай ачааны машин хууль бусаар хил нэвтэрсэн асуудлыг шүүхээр хэлэлцэж шүүгдэгч Б овогт С-ийн Б, Х овогт Т-ын Г, БНХАУ-ын иргэн В /Бу/ нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 19.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад заасан “Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсон байна.

Санхүүжүүлсэн төсөл, охин болон хараат компаниудад оруулсан хөрөнгө оруулалт, олгосон санхүүжилтийн талаар

“Тавантолгой түлш” ХХК

3.107 ҮАБЗ-ийн 2017 оны 03-03 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолоор “Түүхий нүүрсний хэрэглээг хориглох тухай”, Засгийн газрын хуралдааны 2018 оны 18 дугаар тэмдэглэл “Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах тухай”, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 23 дугаар тогтоолыг үндэслэн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх чиг үүрэг бүхий “Тавантолгой Түлш” ХХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд компанийн нийт хувьцааны 51 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 39 хувийг Эрчим хүчний яам, 10 хувийг ТӨБЗГ эзэмшиж байна.

3.108 “Тавантолгой Түлш” ХХК нь 2023 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлангаар нийт 413.3 тэрбум төгрөгийн хөрөнгө, 997.2 тэрбум төгрөгийн өр төлбөртэй, 583.9 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай ажиллаж байгаа бөгөөд нийт хөрөнгийн 57.6 хувийг үндсэн хөрөнгө, 27.5 хувийг бараа материалын үлдэгдэл эзэлж байгаа бол нийт өр төлбөрийн 96 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт эзэлж байна.

3.109 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2018 оноос хойш “Тавантолгой Түлш” ХХК-д санхүүжилт олгох тухай үндсэн 15 гэрээгээр эргэн төлөгдөх нөхцөлтэй, нийт 1,069.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

- Санхүүжилтийн гэрээ тус бүрийн гүйцэтгэлээр “Эрдэнэс Тавантолгой” ХК авлагаар, “Тавантолгой Түлш” ХХК өглөгөөр санхүүгийн тайланд тусгаж ирсэн боловч 2022 оны санхүүгийн тайланд 6,381.7 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэн байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Hong Kong hengde компанитай байгуулсан ЭТТ-2022/518 дугаартай арилжааны гэрээгээр³ 10,381.25 тонн хатуу коксжих нүүрсийг нийлүүлж⁴ “Тавантолгой Түлш” ХХК-аас авах авлагаар 6,615.1 сая төгрөг бүртгэсэн бол “Тавантолгой Түлш” ХХК нь 408.5 тонн шахмал түлшийг Зүүн бүсийн үйлдвэртээ хүлээн авч, 233.4 сая төгрөгийн гаалийн татвар төлснөөр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт санхүүжилтийн өглөгийг 233.4 сая төгрөгөөр бууруулж бүртгэсэн байна.

3.110 ҮАБЗ-ийн 2017 оны 03/03 дугаартай “Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай” зөвлөмж, Тагнуулын ерөнхий газрын 2019 оны 01/414 албан тоот, ЗГХЭГ-ын 2019 оны Х/278 албан тоотыг үндэслэн “Тавантолгой Түлш” ХХК нь 2019, 2020, 2021, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх тусгай тоног төхөөрөмж, түүхий эд зэрэг бараа, ажил, үйлчилгээг нууцын зэрэгт хамруулан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан худалдан авсан байна.

3.111 “Тавантолгой Түлш” ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хянахад харилцах дансны хуулга, журналын дүн зөрүүтэй бүртгэсэн, анхан шатны баримт бүрдэл дутуу, гэрээний дагуу бараа материалыг хүлээн аваагүй байхад төлбөрийг урьдчилан шилжүүлсэн, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг бодитоор тооцож бүртгээгүй, ашиг алдагдлыг буруу илэрхийлсэн зэрэг нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж,

³ Тавантолгой түлш ХХК-ийн эрх үүргийг тодорхой дурьдаагүй бөгөөд тус гэрээнд Тавантолгой түлш ХХК-ийг төлөөлж гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

⁴ Hong Kong Hengde компаниас 109,000 тонн БНХАУ-н GB-34170-2017 стандартын шахмал түлшийг нийлүүлнэ.

тайлан тэнцэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3⁵ дахь хэсэгт заасантай нийцэхгүй байна. Гэвч Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Сүлд аудит” ХХК 2019-2021 онд санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэж, зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

3.112 Компанийн төлбөрийн чадвар муудсан, алдагдалтай ажиллаж байхад дээрх аудитын дүгнэлтийг үндэслэн “Тавантолгой Түлш” ХХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор /2019-2022 он/ ТУЗ-ийн гишүүдэд 410.3 сая төгрөгийн урамшуулал, компанийн гүйцэтгэх захирал М.Ганбаатарт ТУЗ-ийн 2019 оны 26 дугаар тогтоолоор 6 сарын цалинтай⁶ тэнцэх урамшуулал, ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор 24 сарын цалинтай тэнцэх урамшуулал олгосон байна.

3.113 “Тавантолгой Түлш” ХХК нь 2019-2022 онд ажилтан О.Жавхлант, Т.Тулгабат нарын хувь дансанд их хэмжээний буюу 4.6 тэрбум төгрөг шилжүүлж, гаалийн татвар, бүрдүүлэлтийн зардал, бараа хүлээн авахтай холбоотой ачиж буулгах зардал, агуулахын төлбөр, краны хөлс, барааны хадгалалтын хөлс, лабораторийн төлбөр зэрэгт зарцуулсан⁷ байна.

- *Ажилтан О.Жавхлант нь “Эм солар” ХХК-ийн хувьцаа эзэмшигч байх бөгөөд тус компани “Тавантолгой Түлш” ХХК-д 2018-2019 онд нийт 2.2 тэрбум төгрөгийн барьцалдуулагч нийлүүлсэн нь О.Жавхлантын Хаан банк дахь дансны гүйлгээгээр нотлогдсон болно.*

3.114 Шалгалтын хугацаанд гэрээний санхүүжилтийн гүйцэтгэлийг анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн журналын бичилттэй тулгахад тоон дүнгүүд хоорондоо зөрүүтэй тусгагдсан, санхүүжилтийг зориулалтын дагуу ангилж бүртгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байдлаас шалтгаалж мэдээллийн үнэн зөвийг батлах боломж бүрдээгүй бөгөөд “Тавантолгой Түлш” ХХК-ийн холбогдох албан тушаалтнууд Зерован ХХК-ийн нийлүүлсэн санхүүгийн программаас 2018-2022 оны санхүүгийн мэдээллийг гаргаж өгөх боломжгүй, тус программ ажиллахгүй байгаа тухай тайлбарыг өгсөн тул шинжээч нарийвчлан шалгах шаардлага үүссэн болно.

3.115 “Тавантолгой Түлш” ХХК болон “Зерован” ХХК-ийн хооронд 2018 оны 1023/2018 дугаартай гэрээгээр “Программ хангамжийн гэрээ” байгуулснаар, санхүүгийн Ахplorer программ нийлүүлэлт, ашиглалтын төлбөрт нийт 8 удаагийн гүйлгээгээр 57.6 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

- *“Зерован” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Энхчулуун компанийн данснаас бэлэн мөнгөөр зарлагдаж, улмаар иргэн Ө.Ууганбаярын Төрийн банк дахь хадгаламжийн дансанд шилжүүлсэн байна. Ө.Ууганбаяр нь “Тавантолгой Түлш” ХХК-ийн ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан П.Амарцэцэгийн нөхөр болох нь УБЕГ-ын лавлагаагаар нотлогдсон болно.*

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК

3.116 Засгийн газрын 2020 оны 175 дугаар тогтоолын дагуу “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийг 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулсан бөгөөд ЭХЯ 51 хувийн, ТӨБЗГ 19 хувийн, “Эрдэнэс Тавантолгой” ХК 30 хувийн хувьцааг тус тус эзэмшиж байна.

- *Санхүүжилтийн нөхцөлийг тодорхойлж шийдвэрлүүлэх, санхүүжилтийн эргэн төлөлтийг хариуцах;*
- *Барилгын ажлын захиалагчийн үүргийг гүйцэтгэж, хяналт тавьж, ашиглалтад оруулах;*
- *Станцын үйл ажиллагааг эрхлэн явуулж, цахилгаан үйлдвэрлэн Оюутолгой болон Өмнийн говийн уул уурхайн төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах;*

3.117 “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-д нийт 12.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосноос 9.3 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны санхүүжилт, 3.4 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын санхүүжилтэд тус тус зарцуулсан бөгөөд төслийн газрын байршил, тусгай зөвшөөрөл, холбогдох гэрээнүүдийг байгуулж, ТЭЗҮ

⁵ “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг ноголж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог ойлгоно.

⁶ Тавантолгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирал асан М.Ганбаатар нь нээлттэй сонголд оролцох үедээ 40.0 сая төгрөгийн урамшуулал авсан бөгөөд тус мөнгөн урамшууллыг өөрийн компанийн ажилтанд дэмжлэг үзүүлж шилжүүлсэн гэж тайлбар өгсөн. Гэтэл 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр М.Ганбаатарын Хас банк дахь дансанд 90,285,300.00 төгрөг шилжүүлснээс 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр 90.0 сая төгрөгийг Моннис моторс ХХК-ийн Голомт банк дахь дансанд “урьдчилгаа” утгатайгаар шилжүүлсэн байна.

⁷ холбогдох гэрээ, баримт материалыг авахыг хүссэн боловч АТГ-т шалгагдаж байгаа тухай тайлбар өгсөн болно

боловсруулах, батлуулах бэлтгэл ажил дууссан бөгөөд барилга, угсралтын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үе шатандаа явж байна.

Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл

3.118 УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан байна. Уг тогтоолоор Монгол Улсад бүтээн байгуулах төмөр замын нэгдүгээр үе шатанд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын 414.6 км трасс батлагдсан байна.

3.119 УИХ-ын 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд “...Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам зэрэг төслийг эхлүүлэх талаар шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх”-ийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна.

3.120 Засгийн газрын 2019 оны “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоол батлагдсан байна. Уг тогтоолоор 750.0 тэрбум төгрөгийн бонд гаргаж худалдахаар гаргах зөвшөөрлийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгохыг Сангийн сайдад, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд нарт тус тус даалгасан байна

3.121 Засгийн газрын 2020 оны “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, зөвшөөрөл олгох, төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээний тухай” 117 дугаар тогтоолоор “Монголын төмөр зам” ТӨХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хамтарсан “Зүүнбаян төмөр зам” ХХК-г байгуулж, тус компанийн хувьцааны 66 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д тус тус эзэмшүүлжээ.

3.122 “Эрдэнэс Тавантолгой” ХК ба “Монголын төмөр зам” ТӨХК нь ЭТТ-2020/693 дугаар бүхий “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан байна.

3.123 “Монголын төмөр зам” ТӨХК нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замтай холбоотой ТЭЗҮ-г дараах байдлаар гүйцэтгүүлж байжээ.

- *Даланзадгад-Тавантолгой-Цагаансуварга-Зүүнбаян-Сайншанд Баруун-Урт-Хөөт-Чойбалсан өртөө хүртэл нийт 1100 км “Шинэ төмөр зам”-ын ТЭЗҮ-ийг дараах компаниудаар 2011 оны 8 дугаар сард, 5.6 сая ам.доллараар гүйцэтгүүлсэн байна.*
 - *McKinsey and company, Liberty Partners LLC, Pillsbury Winthrop Shaw Pittman ба BNP Paribas limited компани*
- *Nippon Koei Co., LTD компанитай ТЭЗҮ-д нэмэлт тодотгол хийх /Ухаа худаг-Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Чойбалсан, Чойбалсан-Эрээнцавын одоо байгаа шугамыг сайжруулах, Хөөт-Бичигт өртөө хүртэл нийт урт 1580 км/ 9.1 сая ам.долларын үнийн дүн бүхий зөвлөх үйлчилгээний гэрээг 2014 оны 10 дугаар сард байгуулж, гүйцэтгүүлсэн байна.*
- *“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны А/53 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын 414.6 км трасст ТЭЗҮ-ийн тодотгол хийж ажиллахыг даалгасан байна.*
 - *Уг ТЭЗҮ-ийн тодотголоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьсны дараа Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замыг барихаар төлөвлөж байгаа бөгөөд энэхүү төмөр зам нь Тавантолгойн орд газрыг Хятадын Мандал боомттой холбоно.*
 - *Тавантолгой-Зүүнбаянгийн төмөр зам нь УБТЗ-ын төв магистраль шугамтай холбогдсоноор Хятадын Эрээн хотын боомтоор Тавантолгойн нүүрсийг экспортод гаргах боломж бүрдэнэ.*
 - *Төслийг хэрэгжүүлснээр Тавантолгойн бүлэг ордын уурхайнууд төдийгүй тухайн төмөр зам дайран өнгөрч байгаа бүс нутгийн нийгэм, эдийн засгийн нөхцөлийг сайжруулахад онцгой хувь нэмэр оруулна гэж тусгасан байна.*

3.124 Зам, тээврийн салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар ТЭЗҮ-д хийсэн тодотголыг хэлэлцэж, дэмжиж, Зам, тээврийн хөгжлийн төв 2019 оны 05-р сарын 17-ны өдрийн 53/2019 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлт гаргасан байна.

3.125 ЗТХС, УУХҮС нар 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын санхүүжилтийн хуваарийг 1,392.2 тэрбум төгрөг байхаар баталснаас “Эрдэнэс Тавантолгой” ХК 1,336.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 51.4 тэрбум төгрөгийн үлдэгдэл төлбөртэй байгаа ба “Зүүнбаян төмөр зам” ХХК татан буугдсантай холбоотой 4.8 тэрбум төгрөг хасагдсан байна.

3.126 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр зарлигаар “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам”-ыг шинэчлэн баталсан ба Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/134 дүгээр “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг оролцуулах тухай” тушаал баталсан байна.

3.127 “Монголын төмөр зам” ТӨХК ТБОНӨХБАУХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтын дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад дараах байгууллагуудтай гэрээ байгуулж, Ерөнхий гүйцэтгэгчээр ажиллуулсан байна. Үүнд:

- “Улаанбаатар төмөр зам” ХНН - төмөр замын дээд бүтцийн Ерөнхий гүйцэтгэгч (гэрээний дугаар ОГ/20/042 АГГ-20/21-20/06)
- Зэвсэгт хүчний жанжин штаб - Төмөр замын доод бүтэц хариуцсан Ерөнхий гүйцэтгэгч (гэрээний дугаар АГГ-Н/1901 Н/367)



3.128 Төслийн хүрээнд төслийн доод бүтцийн барилга угсралтын ажилд Зэвсэгт хүчний жанжин штабын харьяа Барилга, инженерийн цэргийн удирдах газартай Зэвсэгт хүчний 8 анги нэгтгэл, нийт 77 аж ахуйн нэгж туслан гүйцэтгэгчээр, төслийн дээд бүтцийн ажил, холбоо дохиоллын суурилуулах ажилд “Улаанбаатар төмөр зам” ХНН-тэй нийт 30 компани туслан гүйцэтгэгчээр ажилласан байна.

3.129 Тавантолгой-Зүүнбаян төмөр замыг Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 126 дугаар тушаалаар байгуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 123/008 дугаар дүгнэлтээр ашиглалтад оруулсан байна.

3.130 Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар 1 жилд 24 зүтгүүр, 1272 вагоноор 9.19 сая тонн ачааг тээвэрлэхэд алдагдалгүй ажиллахаар байгаа хэдий ч “Монголын төмөр зам” ТӨХК нь 8 зүтгүүр, 1 сэлгээний зүтгүүртэйгээс /2 нь ажиллагаагүй, 3 нь их засварт хүлээгдэж байгаа/ 4 зүтгүүр, 332 вагон тээвэрт ашиглаж 2022-2023 онд нийт 2.3 сая тн ачаа тээвэрлэсэн нь төмөр замын ашигт ажиллагаа ТЭЗҮ-д заасан хэмжээнд хүрэхгүй байгааг харуулж байна.

3.131 Засгийн газрын 2022 оны 434 дүгээр тогтоолоор “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр зогсоож, “Монголын төмөр зам” ТӨХК-д

нэгтгэн зохион байгуулж, ТӨБЗГ-ын 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн “Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 112 дугаар тогтоолоор, 168 нэрийн 475.9 тэрбум төгрөгийн балансын үнэ, 258.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг “Зүүнбаян төмөр зам” ХХК-иас “Монголын төмөр зам” ТӨХК-д хүлээлгэн өгсөн байна.

3.132 “Монголын төмөр зам” ТӨХК болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд ЭТТ-2013/731 дугаартай “Үнэт цаас худалдах, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны гэрээ”-г 2019 оны 10 сарын 24-ний өдөр байгуулжээ.

3.133 “Эрдэнэс Тавантолгой” ХК дээрх гэрээний дагуу “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн 750.0 тэрбум төгрөгийн 20 жилийн хугацаатай, хүүгүй, бондыг худалдан авсан бөгөөд уг гэрээний хавсралтаар баталсан эргэн төлөлтийн хуваарийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-д 2022 онд 3.0 тэрбум, 2023 онд 5.0 тэрбум төгрөгийг төлөх ёстой хэдий ч эргэн төлөлт огт хийгдээгүй байна.

Богдхан төмөр замын төсөл

3.134 Богдхан төмөр замын бүтээн байгуулалтын талаар “Улаанбаатар төмөр зам” ХНН-ээс 2010 онд хийсэн урьдчилсан ТЭЗҮ, АХБ-ны дэмжлэгтэй ТА-8935 МОН:Богдхан уулыг тойрох төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр трассын судалгаа 2017 онд хийгдэж байсан бөгөөд “Урбан девелопмент консалтинг групп” ХХК-ийн 2021 онд боловсруулсан ТЭЗҮ-ээр III зэрэглэлийн, гол замын урт 144.8 км, 4 өртөө, 6 зөрлөг, жилд 30 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай байхаар тусгасан төмөр зам нь дараах нийгмийн ач холбогдолтой байна.

- *Тээвэрлэлтийн дэд бүтцийн сүлжээг үүсгэж, бүтээгдэхүүнийг түргэн шуурхай тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ.*
- *Улаанбаатар хотоор тээвэрлэж буй аюултай ачааны асуудлыг шийдвэрлэнэ.*
- *Улаанбаатар хотын түгжрэлийн асуудлыг бууруулна.*

3.135 Богдхан төмөр зам төсөл нь нийгмийн ач холбогдолтой боловч эдийн засгийн үр ашиг багатай, зарцуулсан хөрөнгө оруулалтаа нөхөхөд хүндрэлтэй байдал үүсэхээр байна. Төслийн хөрөнгө оруулалтын нийт зардал 1,404.9 сая ам.доллараар ТЭЗҮ-д тусгасан байна. Санхүүгийн үр ашгийн тооцооллыг 3 хувилбараар бэлтгэснээс 2 хувилбар нь ашиггүй, зөвхөн 1 хувилбараар тооцоолсон нь ашигтай байхаар байна. Үүнд:

- *Хувилбар А. “УБТЗ” ХНН-ийн дундаж тарифаар тооцсон санхүүгийн үр дүнгээр эргэн төлөх хугацаа хонгилын элэгдлийн 96.86 жил их гарсан нь энэ төсөлд хөрөнгө оруулахад санхүүгийн үр ашиггүй байна.*
- *Хувилбар Б. Суурь бүтцийн тариф тооцох аргачлалын дагуу бодсон санхүүгийн үр дүнгээр хөрөнгө оруулалтаа эргэн төлөх хугацаа 32.2 жил байгаа нь санхүүгийн тооцооллын 30 жилээс их гарсан ч энэ төсөлд хөрөнгө оруулахад санхүүгийн үр ашиггүй байна.*
- *Хувилбар В. АХБ-ны 2014 оны судалгааны тайланд тусгасан Суурь бүтцийн тариф тооцох аргачлалаар бодсон тарифаар тооцоход хөрөнгө оруулалтаа эргэн төлөх хугацаа 17.4 жил санхүүгийн үр ашигтай байна.*

3.136 Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан бөгөөд Ерөнхий сайдын 2021 оны 76 дугаар захирамжаар “Богдхан төмөр зам” төслийн ТЭЗҮ боловсруулах, төсөл хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолоор “Богдхан төмөр зам” төслийн тусгай зөвшөөрлийг, 2021 оны 254 дүгээр тогтоолоор Богдхан төмөр зам төслийн барилгын ажлын зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д олгосон байна.

3.137 ЗТХС, УУХҮС нарын 2021 оны МН-02/МН-235 дугаартай “Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” тушаалын 6 дугаар зүйлд Богдхан төмөр зам төслийн ерөнхий гүйцэтгэгчтэй ЕРС гэрээ байгуулах асуудлыг холбогдох хууль тогтоомж, компанийн дүрмийн дагуу компанийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, санхүүжилтийн асуудлыг ТЭЗҮ-гийн дүнд багтаан шийдвэрлэж ажиллахын “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ, Гүйцэтгэх захирал, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн удирдлагад тус тус даалгасан байна.

3.138 “Урбан девелопмент консалтинг групп” ХХК 2021 онд Богдхан төмөр замын ТЭЗҮ-г боловсруулж Зам тээврийн хөгжлийн төвөөс 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 243/2021

дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлтээр, шинэчилсэн ТЭЗҮ-г Зам тээврийн хөгжлийн төвөөс 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 100/2022 дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлтээр тус тус баталгаажуулсан бөгөөд төмөр замын 1 дүгээр зэрэглэлийг 3 болгон бууруулснаар шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ 507.3 сая ам доллараар багасаж 1,404.9 сая ам.доллар болсон байна.

3.139 Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлийн 2-т Богдхан төмөр замын төслийн барилгын ажлын хүрээнд өмнө нь гарсан шийдвэрүүдийг судалж, холбогдох өөрчлөлт оруулсны үндсэн дээр төмөр замын доод бүтцийн барилгын ажлыг ЗХЖШ, дээд бүтцийн барилгын ажлыг УБТЗ ХНН, эстакадан гүүр, тунелийн барилгын ажлыг “Бодь интернэшнл” ХХК-аар тус тус гүйцэтгүүлэхээр тооцож, зохих арга хэмжээ авахыг ЗТХС, БХС, Тавантолгой төмөр зам ХХК-ийн Гүйцэтгэх захирал нарт даалгасан байна.

3.140 “Тавантолгой төмөр зам” ХХК нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтыг үндэслэн Богдхан төмөр зам төслийн хүрээнд дараах 2 хэлэлцээрийг байгуулсан байна. Үүнд:

- *Зэвсэгт хүчний жанжин штабтай 2022 оны 07 сарын 07-ны өдөр ТТЗ-МХ22/03, МН/482 дугаартай Богдхан төмөр зам төслийн доод бүтэц, өртөө зөрлөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний ерөнхий хэлэлцээр,*
- *“Бодь интернэшнл” ХХК-тай 2022 оны 8 сарын 31-ний өдөр ТТЗ-МН22/08, ВІ-ВВВ-CONT-0001 дугаартай Богдхан төмөр зам төслийн эстакад гүүр, тунелийн зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээний ерөнхий хэлэлцээр.*

3.141 Богдхан төмөр зам төслийн хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК нь дараах 3 гэрээг байгуулсан байна. Үүнд:

- *“Бодь интернэшнл” ХХК-тай 2022 оны 06 сарын 27-ны өдөр МН-ЭТТ2022/488, ВІ-ВВВ-CONT-0003 дугаартай Санхүүжилтийн гэрээ*
- *Тавантолгой төмөр зам ХХК-тай 2022 оны 06 сарын 28-ны МН-ЭТТ-2022/494, ТВ-МН22/02 дугаартай Нүүрс нийлүүлэх гэрээ*
- *“Бодь интернэшнл” ХХК-тай болон Тавантолгой төмөр зам ХХК-тай 2022.06.27-ны өдөр МН-ЭТТ-2022/487, ТТЗ-МН22/01, ВІ-ВВВ-CONT-0002 дугаартай Санхүүжилтийн гэрээ*

3.142 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Богдхан төмөр замын туннел, эстакадан гүүрний барилгын ажлын санхүүжилтийг нүүрс борлуулах замаар хийхтэй холбоотойгоор “Бодь интернэшнл” ХХК-ийн нэрлэсэн 7 худалдан авагчтай 6.75 сая тонн коксжих нүүрс, 200 мянган тонн исэлдсэн нүүрс, 500 мянган тонн сул коксжих нүүрс борлуулах 9 гэрээ байгуулсан.

3.143 Эдгээр нүүрсний борлуулалтын гэрээний сарын дундаж үнийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тухай бүр мөрдөгдөж байсан үнэ тогтоох аргачлалын үнэтэй харьцуулан нийт гэрээний үнийн зөрүүг тооцоход алдагдсан боломжийн зардал ойролцоогоор 4.05 сая ам доллар байна.

- *“Бодь интернэшнл” ХХК-ийн нэрлэсэн худалдан авагчдад нийт 88.1 тэрбум төгрөгийн нүүрс нийлүүлсэн,*
- *“Тавантолгой төмөр зам” ХХК-д 100.0 тэрбум төгрөг олгосноос 57.0 тэрбум төгрөгийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д буцаан шилжүүлсэн байна.*

3.144 ЗТХС-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 22 дугаар шуурхай хуралдааны VII.Төмөр зам, далайн тээвэрт бүлгийн 4-т Богдхан төмөр замын төсөлтэй холбоотой бүх гэрээг түдгэлзүүлэх тухай албан бичгийг “Бодь интернэшнл” ХХК болон Зэвсэгт хүчний жанжин штабт хүргүүлэхийг даалгасан байна.

3.145 Тавантолгой төмөр зам ХХК-иас 2022 оны 12 сарын 26-ны 1/1514 дугаартай албан бичгээр “Бодь интернэшнл” ХХК-д, 2022 оны 12 сарын 15-ны өдрийн 1/1471 дугаар албан бичгээр Зэвсэгт хүчний барилга инженерийн цэргийн удирдах газарт тус тус хандаж Богдхан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг түр зогсоосон байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл

3.146 УИХ-аас баталсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны

төлөвлөгөө, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” зэрэгт Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын талаар тусгасан бөгөөд “Монголын төмөр зам” ТӨХК нь Шинэ төмөр зам төслийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банк, улсын төсвийн санхүүжилтээр нийт 276.4 сая ам.долларын ажил гүйцэтгүүлсэн байна.

3.147 Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолоор төрийн өмчийн 51 хувиас доошгүй оролцоотой “Тавантолгой төмөр зам” ХХК-ийг байгуулсан бөгөөд ЗТХС-ын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 33 дугаар тушаалаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл, холбогдох тооцоо судалгааг шинэчлэн боловсруулж, 2019 оны 1 дүгээр улиралд багтаан дуусгахыг “Монголын төмөр зам” ТӨХК-д үүрэг болгож, зардлыг шийдвэрлэхийг тус компанийн ТУЗ-ийн дарга, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн ТУЗ-д зөвшөөрсөн байна.

3.148 “Тавантолгой төмөр зам” ХХК, “Бодь интернэшнл” ХХК нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажлыг санхүүжүүлэх, төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, цаашдын хамтын ажиллагааны хэлбэрийг тодорхойлох зорилгоор 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр санамж бичиг байгуулсан байна.

3.149 Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 304 дүгээр тогтоолоор “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцааны 66 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д эзэмшүүлж, төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д олгож, барилгын ажлыг 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үргэлжлүүлж, 2021 онд ашиглалтад оруулахыг ЗТХС, УУХҮС нарт үүрэг болгожээ.

3.150 Тагнуулын ерөнхий газрын 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн албан бичгээр Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажил нь төрийн нууцад хамаарах тухай хариу албан бичгийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д ирүүлсэн бөгөөд тухайн өдөр “Бодь интернэшнл” ХХК-иас дээрх төсөлд барилгын ажлын Ерөнхий гүйцэтгэгчээр оролцох сонирхлоо илэрхийлж, холбогдох баримт бичгийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д хүргүүлж байжээ.

3.151 УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын дарга нарын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А184/284/А239 дүгээр тушаалаар төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулж, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн ТУЗ-өөр хэлэлцүүлэн Засгийн газарт танилцуулсны үндсэн дээр ерөнхий гүйцэтгэгчийн ЕРС гэрээг байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал Н.Удаанжаргалд даалгасан байна.

3.152 “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хурлаар төслийн Ерөнхий гүйцэтгэгч сонгосон талаар Гүйцэтгэх захирал Н.Удаанжаргал танилцуулж, Тавантолгой – Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгчийн ЕРС гэрээг ТЭЗҮ /АЕСОМ/-д заасан дүнгээр “Бодь интернэшнл” ХХК-тай хэлцэл хийж, гэрээ байгуулахыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн байна.

- *ТУЗ-ийн 2019 оны 16 дугаар тогтоолд Ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахыг зөвшөөрч, ТЭЗҮ-ийн дүнгээс давсан зайлшгүй шаардлагатай нэмэлт ажлын гэрээг тодотгосон ТЭЗҮ-ээр тодорхойлсон дүнгээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар байгуулж ажиллахыг зөвшөөрсөн байна.*

3.153 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 47 дугаар тогтоолоор 110.0 сая ам.доллартай тэнцэх төгрөгийг 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор багтаан “Тавантолгой төмөр зам” ХХК-д шилжүүлэх, төслийн ТЭЗҮ-г тодотгосны үндсэн дээр шаардагдах санхүүжилтийн хэмжээг тогтоож, нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх саналыг боловсруулан ТУЗ-д танилцуулахыг Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт зөвшөөрсөн байна.

3.154 “Тавантолгой төмөр зам” ХХК ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтын дагуу болон “Бодь интернэшнл” ХХК-тай “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээг 2019 оны


10 дугаар сарын 29-ний өдөр байгуулжээ. Тус гэрээнд технологийн иж бүрдэлд дараах багц ажлууд багтааар тусгасан байна. Үүнд:

- БАГЦ 1 - Замын дээд, доод бүтцийн барилга угсралтын ажил
- БАГЦ 2 - Дохиолол төвлөрүүлэлт, харилцаа холбоо
- БАГЦ 3 – Өртөө зөрлөгийн болон депо, ажилчдын амьдрах барилга байгууламж
- БАГЦ 4 - Цахилгаан эрчим хүч, усан хангамж
- БАГЦ 5 - Хөдлөх бүрэлдэхүүн /Зүтгүүр, ачааны вагон/
- БАГЦ 6 - Хөдлөх бүрэлдэхүүний засварын тоног төхөөрөмж

3.155 Дээрх гэрээнд Хавсралт 2-д Нийт үнийн дүн 792.2 сая ам.доллар, Урьдчилгаа төлбөрийн дүн 110.0 сая ам.доллар байхаар тусгасан бөгөөд “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 17 дугаар тогтоолд урьдчилгаа санхүүжилтэд 293.8 тэрбум төгрөгийг урьдчилгаа төлбөрийн болон гүйцэтгэлийн баталгааг авсны үндсэн дээр шилжүүлэхийг зөвшөөрсөн байна.

- “Тавантолгой төмөр зам” ХХК нь “Бодь интернэшнл” ХХК-д 286.3 тэрбум төгрөгийн урьдчилгааг 2019.11.13-ны өдөр шилжүүлсэн.

3.156 “Бодь интернэшнл” ХХК төмөр замын бүтээн байгуулалтад гаднаас хөрөнгө босгож зарцуулсан эсэх нь тодорхойгүй байх бөгөөд “Тавантолгой төмөр зам” ХХК-иас шилжүүлсэн 286.3 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөр болон нүүрс борлуулалтын орлогоос тус төслийг санхүүжүүлж, хэрэгжүүлсэн байх магадлалтай байна.



3.157 БНСУ-ын Dongmyeong Engineering Consultants компани дээрх ТЭЗҮ-д Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам болгон 2020 оны 4 дүгээр сард тодотгол хийж, хөрөнгө оруулалтын төсөв 213.0 сая ам.долларын ажил нэмэгдэхээр тусгасан бөгөөд “Тавантолгой төмөр зам” ХХК, “Бодь интернэшнл” ХХК уг ТЭЗҮ-ийн тодотголд үндэслэн гэрээний үнийн дүн нийт 1,005.6 сая ам.доллар болгох нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээг 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан байна.

3.158 Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд технологийн бус, нийгмийн шинж чанартай барилга байгууламж барих зэрэг зарим ажлыг хойшлуулах замаар зохицуулалт хийж,

ТЭЗҮ-д заасан дүнгээр Гашуунсухайт өртөөнд вагоноос автомашин руу шилжүүлэн ачих терминалын барилгын ажлыг яаралтай эхлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн ТУЗ, гүйцэтгэх захиралд даалгасан байна.

3.159 “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн боловсруулсан Шилжүүлэн ачих терминалын ТЭЗҮ-г Зам тээврийн хөгжлийн төв 2020.02.23-ны өдөр магадлал хийсэн бөгөөд “Бодь интернэшнл” ХХК-тай шилжүүлэн ачих терминалын төслийн хувьд нэмэлт гэрээ байгуулалгүйгээр ерөнхий гэрээнд тусгасан Суурьшлын бүсийн барилга байгууламж хэсэгт тусгасан 45.0 сая ам.долларын ажлыг хасаж, 42.6 сая ам.доллар (НӨАТ тооцсоноор 46.8 сая ам.доллар) нэмж өөрчилсөн байна.

3.160 “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн ТУЗ-ийн 2022.12.30-ны өдрийн 30 дугаар тогтоолоор “бүтээн байгуулалтын төсөлд зарцуулсан хөрөнгөд хөндлөнгийн аудитын дүгнэлт, ... тус компанийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, худалдан авах ажиллагаанд хийх санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт, шалгалтын дүнд

үндэслэн гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулах эсэхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчид үүрэг болгосон байна.

- *Тус төслийн бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын бодит гүйцэтгэл захиалагчийн баталгаажуулснаар 2023.06.30-ны өдрийн байдлаар 589.3 сая ам.доллар буюу 59 хувьтай, гүйцэтгэгчээс 2022.09 дүгээр сараас хойших хугацаанд ирүүлсэн 24–30 дахь гүйцэтгэлийг захиалагч баталгаажуулаагүй байна.*

3.161 ХШТХ-нд “Тавантолгой төмөр зам” ХХК-иас 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс хойш ирүүлсэн 24-30 дугаар гүйцэтгэлийн нэхэмжилсэн дүнгээр ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлж тооцвол 898.5 сая ам.доллар буюу 93.9 хувьтай, “Бодь интернэшнл” ХХК-иас ирүүлсэн ажлын гүйцэтгэл 964.3 сая ам.доллар буюу 96 хувийн хэрэгжилттэй байна.

3.162 “Бодь интернэшнл” ХХК-иас ирүүлсэн албан бичиг, барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах комиссын актаас үзэхэд төслийн бүтээн байгуулалтад нийт 252 компани зураг төсөл боловсруулах, зохиогчийн хяналт хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ болон барилга угсралтын ажлын туслан гүйцэтгэгч, бараа материал ханган нийлүүлэгчээр ажилласан байна.

- *Дотоодын хуулийн этгээд 212,*
- *Гадаадын хуулийн этгээд 40.*

3.163 Хяналт шалгалтын хугацаанд “Бодь интернэшнл” ХХК-ийн дансны хуулга, төслийн туслан гүйцэтгэгч компаниудын гэрээний талаарх баримт материал иж бүрэн ирүүлээгүйгээс тус төсөлд нийт зарцуулсан дүн болон туслан гүйцэтгэгч тус бүрийн гэрээний үнийн дүнг нягтлах боломжгүй байна.

3.164 Тавантолгой-Гашуунсухайтын төмөр зам нь Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэл I зэрэглэлийн 233.6 км урт гол замтай, нийт дэлгэмэл урт нь 324.5 км, 2 өртөө, 6 зөрлөгтэй, Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын нутгаар дайран өнгөрдөг, жилд 30.0-50.0 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай, өргөн царигтайгаар баригдсан байна.

3.165 ЗТХЯ-аас ирүүлсэн мэдээллээс үзэхэд Засгийн газрын 2021 оны 89 дүгээр тогтоолын дагуу Монгол Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр зам хилийн шугам дайран өнгөрөх цэгийг 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр тохиролцсон байна.

3.166 Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам болон БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэчлэлийн хороо хооронд “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын холболтын тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдөр байгуулж, тус боомтын холболтын гол нөхцөл болох төмөр замын царигийн асуудлыг Хятадын талтай харилцан тохиролцсон байна.

- *“Тавантолгой төмөр зам” ХХК, БНХАУ-ын “Төмөр замын зураг төслийн корпораци” ХХК хооронд Боомтын сэргэлтийн хүрээнд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр техник, эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан байна.*
- *ЗТХЯ-аас баталсан ажлын даалгавар дагуу Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам нь урьдчилсан байдлаар 8081м урттай, UIC 60 зам төмөр бүхий өргөн /1520мм/, нарийн /1435мм/ царигийн тус бүр нэг гол замтай, 5441м урт гүүрэн байгууламжтайгаар баригдахаар төлөвлөсөн байна.*

3.167 Хил холболтын төмөр зам ашиглалтад орсноор /ТЭЗҮ-д тусгаснаар/ эхний жилд 10.6 сая тн, 2 дахь жилд 21.1 сая тн, 3 дахь жилд 26.4 сая тн, 4-20 дахь жилүүдэд тус бүр 31.9 сая тн, 21-30 дахь жилүүдэд тус бүр 50.2 сая тн нүүрс тээвэрлэхээр байгаа бөгөөд “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2022.07-2023.11 дүгээр сарын хугацаанд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар Шилжүүлэн ачих терминал хүртэл чингэлэг тээврээр нийт 488.4 мян.тн нүүрсийг тээвэрлүүлсэн байна.

Тавантолгойн нүүрс ачилтын логистикийн төв

3.168 “Тавантолгой нүүрс ачилтын логистикийн төв /ТНАЛТ”-ийн төсөл нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Баруун, Зүүн Цанхийн уурхайгаас олборлосон түүхий нүүрсийг “Тавантолгой-Гашуунсухайт”, “Тавантолгой–Зүүнбаян” чиглэлийн төмөр замын вагон тээвэрт

ачих, уурхайгаас 12.5 км-т байрлах Нүүрс баяжуулах үйлдвэрийг тэжээлээр тасралтгүй хангах, тэжээлийн чанарын дундажлалт хийх зорилготой байна.

3.169 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргаас УУХҮС, ЗТХС-д дараах агуулга бүхий “Санал авах тухай” 4/533 дугаар албан бичгийг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн бүхий хүргүүлсэн байна.

- *“Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаас “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн төсөөлөл, төмөр замын санхүүжилтийн төслийг ирүүллээ. Дээрх төсөлд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн ачилтын тойргийн нүүрс ачих байгууламжийг төмөр замын бүтээн байгуулалт, тээврийн зохион байгуулалттай ажилтай уялдуулан санхүүжүүлэхээр тусгасан байх бөгөөд уг асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахыг хүссэн юм. Иймд тухайн асуудлыг эрхэлсэн сайдын хувьд хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаатай уялдуулан уг төслийн талаар саналаа ирүүлж, шаардлагатай бол Үндэсний аюулгүйн зөвлөлд танилцуулахаар хуралдааны материал бэлтгэж ирүүлнэ үү”*

3.170 “Тавантолгой төмөр зам” ХХК 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/24 албан бичгээр төслийг хэрэгжүүлэх тухай УУХҮС-тай хамтарсан тушаал гаргуулах төслийг ЗТХС-д хүргүүлсэн байх бөгөөд ЗТХС уг төслийг хүлээн зөвшөөрөөгүй байна.

3.171 Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн “ТНАЛТ-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 89 дүгээр тогтоолоор уг төсөлтэй холбоотой дараах шийдвэрийг гаргажээ.

- *ТНАЛТ-ийн барилга байгууламжийг барьж байгуулах ажлын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулан хянан баталгаажуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, барилгын ажлыг 2021 оны II улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээ авахыг УУХҮС, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-д,*
- *Уг төвийг ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжүүлэхээр тооцож, тус компанийн хөрөнгөд бүртгүүлэх арга хэмжээ авахыг УУХҮС, ТӨБЗГ, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-д;*

3.172 “Бодь интернэшнл” ХХК нь 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдөр BI-TCTS-LTR-1797 дугаар албан бичгээр “Тавантолгой нүүрс ачилтын логистикийн төв /ТНАЛТ/-ийн бүтээн байгуулалтын ерөнхий гүйцэтгэгчээр ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн бөгөөд “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэх захирлын зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаартай тэмдэглэлээр дараах шийдвэрийг гаргасан байна.

- *ТНАЛТ-ийн эхний үе шатыг 2022 оны эхний хагаст багтаан ашиглалтад оруулах, ... тус төвийн ерөнхий гүйцэтгэгч “Бодь интернэшнл” ХХК-аар гүйцэтгүүлэхээр захирлын зөвлөлийн гишүүд санал нэгтэй дэмжсэн,*

3.173 “Тавантолгой төмөр зам” ХХК-аас ТЕГ-т хүргүүлсэн 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн “Хүсэлт хүргүүлэх тухай” Н-2004 дугаартай албан бичигт Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын салшгүй нэг хэсэг болох ТНАЛТ-ийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах зэрэг ажил нь төрийн нууцад хамаарах эсэх талаар дүгнэлт ирүүлэхийг хүсээд, “Бодь интернэшнл” ХХК-иар гүйцэтгүүлэх нь үр дүнтэй гэж үзэж байгаагаа илэрхийлсэн байна.

3.174 “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны “Гэрээ байгуулах эрх олгох тухай” 15 дугаар тогтоолоор “Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 20 дугаар тогтоолын 2-т заасан санхүүжилтээр ТНАЛТ-ийн зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээг гүйцэтгэгч компанитай байгуулах”-ыг Гүйцэтгэх захирал (Н.Удаанжаргал)-д зөвшөөрсөн байна.

3.175 “Тавантолгой төмөр зам” ХХК нь “Бодь интернэшнл” ХХК-тай ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтын дагуу ТНАЛТ-ийн барилга байгууламжийг барьж байгуулах ажлын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх ТТЗ-МН22/04, BI-NANT-CONT-0001 дугаартай гэрээний ерөнхий хэлэлцээрийг 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдөр байгуулахдаа 217.5 тэрбум төгрөгөөр байгуулсан нь Засгийн газрын 89 дүгээр тогтоолд заасан “ТЭЗҮ, зураг төслийг боловсруулан хянан баталгаажуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ... зохион байгуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 20 дугаар тогтоолын 2-т заасан санхүүжилтийн 217.5 тэрбум төгрөгийг ямар эрх бүхий байгууллагын шийдвэрээр баталгаажсан зураг төсөл, төсөвт үндэслэсэн нь тодорхойгүй байна.

3.176 ТЭЗҮ боловсруулах зураг төслийн зөвлөх “Соёолон инженеринг” ХХК, барилгын ажлын гүйцэтгэгч “Бодь интернэшнл” ХХК-д гуравдагч этгээдийн баталгаагүйгээр их хэмжээний урьдчилгаа төлбөрийг олгосон төдийгүй “Соёолон инженеринг” ХХК-ийг хэрхэн сонгосон нь тодорхойгүй байна.

- “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Бодь интернэшнл” ХХК-ийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу 78.8 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөр,
- “Соёолон инженеринг” ХХК-тай байгуулсан гэрээнд ажлын 5 өдөрт багтаан гэрээний үнийн 60.0 хувь буюу 826.9 сая төгрөгийг урьдчилгаа төлбөр болгон олгохоор заасны дагуу тус тус олгосон байна.

3.177 “Тавантолгой төмөр зам” ХХК нь Барилгын тухай хуулиар онцгой төвөгшилтэй байгууламжид хамаарах ТНАЛТ-ийн ТЭЗҮ-д магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулалгүй, холбогдох хуулийг зөрчиж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр дүгнэлт гаргуулсан, уг дүгнэлтийг үндэслэн “Бодь интернэшнл” ХХК-тай байгуулсан гэрээний ерөнхий хэлэлцээрт 2022 оны 3 дугаар сарын 14-ний нэмэлт өөрчлөлт оруулж, нийт дүнг 313.2 тэрбум төгрөг болгосон байна.

3.178 “Эрдэнэс Тавантолгой” ХК ТНАЛТ-ийн төслийн хүрээнд “Тавантолгой төмөр зам” ХХК-д 254.3 тэрбум төгрөгийг /2022 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар/ олгосон байна. “Тавантолгой төмөр зам” ХХК уг санхүүжилтээс 226.2 тэрбум төгрөг буюу гэрээгээр олгох санхүүжилтийн 74.2 хувийг гүйцэтгэгчид олгосон байна.

3.179 “Соёолон инженеринг” ХХК-ийн боловсруулсан ТНАЛТ-ийн ТЭЗҮ, БОННУ-ний хувьд Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.1⁸, 25.2.2⁹, 25.2.3¹⁰, 25.2.4¹¹-т заасны дагуу магадлал хийх зураг төслийг жагсаалтад багтсан бөгөөд төслийн ажлын бодит гүйцэтгэл 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 78.0 хувьтай гэж талууд баталгаажуулсан байхад Барилгын хөгжлийн төв ТӨҮГ нь ТНАЛТ, нүүрс шилжүүлэн ачих тоног төхөөрөмж, үйлдвэрийн байгууламжийн баталгаажуулалтын ажлын зураг төслийн 1777/2023 дугаартай магадлалын дүгнэлтийг 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр нөхөн баталгаажуулсан байна

3.180 Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.1¹², 25.2.2¹³, 25.2.3¹⁴, 25.2.4¹⁵-т заасны дагуу зайлшгүй магадлал хийх, мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т магадлал хийлгээгүй бол барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгохыг хориглоно гэж заасан байхад Тавантолгой төмөр замын Гүйцэтгэх захирал ТНАЛТ-ийн бүтээн байгуулалтын ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгосон байна.

Холболтын төмөр зам /Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудын холболт/

3.181 Засгийн газрын 2020 оны “Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай” 112 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр холбох төмөр замын шугамын чигийг хавсралтаар баталж, төмөр замын шугамын чигийг газрын кадастрын улсын мэдээллийн санд бүртгэхийг Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газарт даалгажээ.

3.182 Засгийн газрын 2020 оны “Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай” 113 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг

⁸ газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт

⁹ газар хөдлөлтийн долоогоос доош баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт

¹⁰ барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд

¹¹ инженер-геологийн дүгнэлт, геодезийн зураглалд

¹² газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт

¹³ газар хөдлөлтийн долоогоос доош баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт

¹⁴ барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд

¹⁵ инженер-геологийн дүгнэлт, геодезийн зураглалд

холбох төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийг Тавантолгой төмөр зам ХХК-д олгож дараах үүрэг даалгавар өгсөн байна. Үүнд:

- Төмөр замын суурь бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төсөл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсний үндсэн дээр барилгын ажлыг 2020 онд багтаан эхлүүлэх арга хэмжээ авахыг ЗТХС, УУХҮС-д;
- Төмөр замын зураг төсөл боловсруулах, суурь бүтцийг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-д;

3.183 “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны А/59 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн боловсруулсан “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр зам”-ын ТЭЗҮ-д төмөр замын дэлгэмэл урт 27.3 км, 1 км замын өртөг 5.97 тэрбум төгрөг /ам.долларт шилжүүлбэл 1.88 сая доллар/ нийт хөрөнгө оруулалт 229.6 тэрбум төгрөг байхаар тусгасан бөгөөд ЗТХЯ-ны болон Тавантолгой төмөр зам ХХК-аас оролцсон бүрэлдэхүүн гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

3.184 ЗТХС, УУХҮС нарын хамтарсан 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн “Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” А/217/А-293 дугаар тушаалаар дараах шийдвэрийг гаргажээ.

- Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын барилгын ажлыг эхлүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Тавантолгой төмөр зам” ХХК (Н.Удаанжаргал)-д үүрэг болгосон байна.
 - Суурь бүтцүүдийг холбох төмөр замын ТЭЗҮ, БОНУ боловсруулан холбогдох байгууллагаар батлуулсны үндсэн дээр санхүүжилтийг батлуулах;
 - Суурь бүтцүүдийг холбох төмөр замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж эрх бүхий байгууллагаар магадлуулах;
 - Суурь бүтцүүдийг холбох төмөр замын барилгын ажлыг магадлуулсан зураг төсөлд үндэслэн 2020 онд эхлүүлэх ажлыг зохион байгуулах;
 - Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Тагнуулын ерөнхий газрын 2019 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 01/208 дугаартай албан бичгийг үндэслэн зохион байгуулах;
- Төслийн барилга угсралтын ажлыг 2020 онд багтаан эхлүүлж, 2021 онд ашиглалтад оруулахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ-д;

3.185 “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн боловсруулсан “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын ТЭЗҮ-ийн судалгааны ажлын тайлан”-г 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 06/2021 дүгнэлтээр магадлахад Г.Вандандагва /Төмөр зам, замын байгууламжийн зураг төсөлд/ Д.Гэрэлням, Г.Хоролмаа нар¹⁶ /Байгаль орчны үнэлгээний тайланд/ экспертийн дүгнэлт гаргасан байх бөгөөд гүүр, хоолой, дохиолол, холбоо, шилэн кабель, эрчим хүч, гэрэлтүүлэг, хөдлөх бүрэлдэхүүн, автозам барих зэрэгт хэрхэн экспертийн дүгнэлт гаргасан нь тодорхойгүй байна.

3.186 Судалгааны ажлыг магадалсан нь Барилгын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4¹⁷, 39.5¹⁸, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 213 дугаар тушаалаар баталсан “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам”-ын 7.2¹⁹, 7.3²⁰ дахь заалттай нийцээгүй байна.

¹⁶ Д.Гэрэлням - Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга,

Г.Хоролмаа - БОАЖЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн

¹⁷ Барилгын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ.

¹⁸ Барилгын тухай хуулийн 39 дүгээр 39.5-д “Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаархи дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ.

¹⁹ Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам”-ын 7.2-д “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээд нь тухайн зураг төсөлд өөрийн холбогдох хэсэгт магадлалын холбоотой зөрчилд мэргэжлийн хариуцлага хүлээнэ

²⁰ Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам”-ын 7.3 Экспертийн эрх бүхий иргэн нь тухайн зураг төслийн өөрт холбогдох хэсгийн магадлалын дүгнэлтэд, хуулийн этгээд нь иж бүрэн зураг төслийн магадлалын дүгнэлтэд мэргэжлийн хариуцлага хүлээнэ

3.187 “Бодь интернэшнл” ХХК нь Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох Цогтцэций-Тавантолгой өртөө хоорондын төмөр замын барилгын ажлыг гүйцэтгэх сонирхлоо 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Тавантолгой төмөр зам ХХК-д илэрхийлсэн байна.

3.188 Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн “Гэрээ байгуулах эрх олгох тухай” 14 дүгээр тогтоолоор ТЭЗҮ-д заасан магадлагдсан дүн 229.6 тэрбум төгрөг буюу 80.5 сая ам.долларын үнийн дүнгээр “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ” байгуулахыг Гүйцэтгэх захирал Н.Удаанжаргалд зөвшөөрсөн байна.

3.189 “Тавантолгой төмөр зам” ХХК-иас Тагнуулын ерөнхий газарт хүргүүлсэн албан бичиг²¹ холболтын төмөр замын төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах зэрэг ажил нь төрийн нууцад хамаарах эсэх талаар дүгнэлт ирүүлэхийг хүсээд, уг ажлыг “Бодь интернэшнл” ХХК-иар гүйцэтгүүлэх нь үр дүнтэй гэж үзэж байгаагаа илэрхийлсэн байна.

- *Тагнуулын Ерөнхий газар 2021 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 1114 дугаартай албан бичгээр “Холболтын төмөр замын төслийн ажил нь ...үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслийн ажилд хамаарна. Иймд уг төслийн бүтээн байгуулалттай холбоотой худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасны дагуу зохион байгуулах боломжтой” гэсэн хариуг хүргүүлсэн байна.*

3.190 “Тавантолгой төмөр зам” ХХК ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтын дагуу “Бодь интернэшнл” ХХК-тай 2021 оны 8 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр зам”-ын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээний үнийг тогтооходоо 2020 оны 12 дугаар сард боловсруулж, магадлуулсан ТЭЗҮ-ийг үндэслэсэн гэсэн боловч нарийвчлан боловсруулсан зураг төсөл биш Судалгааны ажлын тайланд үндэслэсэн байна.

3.191 Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ нь талууд гэрээ байгуулж, ажил эхэлснээс хойш 4 сарын дараа буюу 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр “Тавантолгой-Гашуунсухайт болон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын нарийвчилсан зураг төсөл”-ийн 221/2021 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтийг хянаж баталгаажуулжээ.

3.192 Мөн “Тавантолгой төмөр зам” ХХК нь ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас 1.6 жилийн дараа буюу 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр “Мейк Грийн” ХХК-тай тус төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний АГГ-01/09/03 дугаартай гэрээг байгуулж, төслийн барилга угсралтын ажил дуусаж, 2022 оны 7 сараас туршилтын тээвэр эхэлснээс хойш буюу 2023 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хүлээн авсан байна.

3.193 ЗТХС-ын 2022 оны Техникийн комисс байгуулах тухай А/152 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн шийдвэрээр төмөр замын дээд, доод бүтэц, хиймэл байгууламжийг ажлын түр хөдөлгөөнд ашиглах тухай дүгнэлтийг 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр гаргаснаас хойш төмөр замаар тээвэр хийгээд 1.6 жил өнгөрсөн боловч улсын комисс ажиллуулаагүй, байнгын ашиглалтад хүлээж аваагүй байна.

3.194 Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төслийн ажлын талуудын баталгаажуулсан бодит гүйцэтгэл 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 89.7 хувьтай байна.

3.195 “Тавантолгой төмөр зам” ХХК нь Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоол, ЗТХС, УУХҮС нарын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр А217/А293 дугаартай хамтарсан тушаалаар өгсөн дараах үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлэхгүйгээр гэрээ байгуулж, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлд өндөр болон онцгой төвөгшилтэй барилга

²¹ 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн “Хүсэлт хүргүүлэх тухай” 1/502 дугаар, 6 дугаар сарын 21-ний өдрийн “Хүсэлт хүргүүлэх тухай” 1/523 дугаар албан бичиг

байгууламжийн ажлын зураг төсөлд магадлал хийгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно гэж заасныг зөрчиж төслийн барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлсэн байна.

3.196 Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн санхүүжилтийг нүүрс борлуулах замаар хийхтэй холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Бодь Интернешнл ХХК-ийн нэрлэсэн 29 худалдан авагчтай 18 сая тонн коксжих нүүрс, 2.3 сая тонн исэлдсэн нүүрс борлуулах 37 гэрээ байгуулсан. Эдгээр нүүрсний борлуулалтын гэрээний сарын дундаж үнийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тухай бүр мөрдөгдөж байсан үнэ тогтоох аргачлалын үнэтэй харьцуулан нийт гэрээний үнийн зөрүүг тооцоход алдагдсан боломжийн зардал ойролцоогоор 204.3 сая ам доллар байна.

Газрын тос дамжуулах хоолой төсөл

3.197 Засгийн газрын 2022 оны “Газрын тос дамжуулах хоолой барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 94 дүгээр тогтоолоор тус төсөлд шаардагдах 397.0 сая ам.долларыг бүтээгдэхүүн урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг УУХҮС, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-д зөвшөөрсөн бөгөөд төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулсан байна.

- УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/08 дугаар тушаалаар байгуулагдсан “Газрын тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах” Үнэлгээний хороо тендерийн материалыг 2021 оны 10 дугаар сард хүлээн авсан байна.
- Тендер шалгаруулалтад 3 орны 4 компани тендерийн материал ирүүлснээс “NORINCO International Cooperation” компани нь дамжуулах хоолойн хөрөнгө оруулалтын 90 хувьтай тэнцэх зардлыг эргэн төлөлтийг зээлийн хүү шимтгэлгүй, Засгийн газрын баталгаа шаардахгүйгээр барилга угсралтын 3 жилийн хугацаанд Монголоос нүүрс худалдан авах замаар төлөх санал ирүүлсэн байна.
- Газрын тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны шийдвэрээр, техник технологийн хувьд хэрэгжих боломжтой, хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНХАУ-ын “NORINCO International Cooperation” компанийг сонгон шалгаруулж, УУХҮЯ-аас тус компанид гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 2021 оны 12 дугаар сард хүргүүлсэн.

3.198 “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдамж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 23 дугаар тогтоолоор тус төслийн 388.0 сая ам.долларын санхүүжилтийг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэх их хэмжээний хэлцэл хийж, гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт олгосон байна.

- “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК болон “Норинко интернэйшнл Кооперейшн” компанийн хооронд 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн MR-01/2022 дугаартай Газрын тос дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (EPC) гэрээ,
- “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хооронд 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ЭТТ-2022/252, 09/22 дугаартай Газрын тос дамжуулах хоолойн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн гэрээ,
- “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Норинко интернэйшнл Кооперейшн” компанийн хооронд 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Нүүрс худалдах, худалдан авах байгуулсан байна.

3.199 EPC гэрээнд урьдчилгаа төлбөр гэрээний үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх буюу 38.8 сая ам.долларын үнийн дүн бүхий нүүрсийг заасан бөгөөд 2022.05-07 дугаар сард 36.8 сая ам.долларын нүүрс нийлүүлэхээр тусгажээ.

3.200 Төслийн захиалагчийн хяналтыг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 2023 оны 10 дугаар сарын байдлаар 15-ны өдрийн байдлаар 88.0 сая ам.доллар буюу 22.7 хувьтай үргэлжилж байна.

3.201 Ерөнхий гүйцэтгэгч Норинко интернэйшнл Кооперейшн компани төслийн бүтээн байгуулалтын ажилд БНХАУ-ын болон дотоодын нийт 13 компанитай туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулж ажиллаж байна.

3.202 “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК хооронд байгуулсан төслийн бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн гэрээнд эргэн төлөлтийг 2027 оны 07 дугаар сараас эхлэн 10 жилийн хугацаанд сар бүр 3.23 сая ам.доллараар төлөхөөр гэрээнд тусгасан байна.

3.203 Газрын тос дамжуулах үйлдвэрийн зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний төлбөрт 3.сая тн коксжих нүүрс нийлүүлэхээр “Эрдэнэс Тавантолгой” ХК, Норинко интернэйшнл Күүперейшн компани болон түүний нэрлэсэн худалдан авагч Глори таун холдинг лимитед компани хооронд 2022 оны “Нүүрс худалдах, худалдан авах тухай” ЭТТ-2022/253 дугаартай гэрээг байгуулсан бөгөөд нүүрсний борлуулалтын гэрээний сарын дундаж үнийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тухай бүр мөрдөгдөж байсан үнэ тогтоох аргачлалын үнэтэй харьцуулан нийт гэрээний үнийн зөрүүг тооцоход алдагдсан боломжийн зардал ойролцоогоор 34.6 сая доллар гарахаар байна.

Нүүрс баяжуулах үйлдвэр

3.204 Нүүрс баяжуулах үйлдвэрийг барих төсөл арга хэмжээ нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 955,8 тэрбум төгрөгөөр тусгагдсан байна.

3.205 “Эрдэнэс Тавантолгой” ХК нүүрс баяжуулах үйлдвэрийн гүйцэтгэгчийн сонгон нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зарласан боловч гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж чадаагүй тул гэрээ шууд байгуулах аргаар зарлаж, Норинко интернэйшнл күүперейшн болон Дади инженеринг девелопмент түншлэлтэй 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр гэрээ байгуулсан байна.

- *Гэрээний үнийн дүн нь анх 955.8 тэрбум төгрөг байсан ба ТУЗ-ийн 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн тогтоолоор гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээний үнийн дүн 1,087.9 тэрбум төгрөг болж өөрчлөгдсөн байна. Гэрээний явц 2023.12.01- ний өдрийн байдлаар 65 хувьтай байна.*

3.206 “Эрдэнэс Тавантолгой” ХК, Норинко интернэйшнл Күүперейшн компани болон түүний нэрлэсэн худалдан авагч Глори таун холдинг лимитед компани хооронд Тавантолгойн ордын нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний төлбөрт 2.5 сая тн коксжих нүүрс нийлүүлэх “Нүүрс худалдах, худалдан авах тухай” ЭТТ-2022/223 дугаартай гэрээг байгуулсан байна.

3.207 Нүүрсний борлуулалтын гэрээний сарын дундаж үнийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тухай бүр мөрдөгдөж байсан үнэ тогтоох аргачлалын үнэтэй харьцуулан нийт гэрээний үнийн зөрүүг тооцоход алдагдсан боломжийн зардал ойролцоогоор 34.1 сая доллар гарахаар байна.

Загийн усны хоолой төсөл

3.208 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд “Загийн усны хоолойгоос ус татах шугам хоолойн барилга угсралтын ажил”-ыг 118.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр тусгасан байна.

3.209 Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 и хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Засгийн газрын тогтоол, Тагнуулын Ерөнхий газрын албан тоотыг үндэслэн 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр баталсан “Төрийн нууцад хамруулсан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах журам”-ын дагуу цаасан суурьтай хэлбэрээр зохион байгуулсан байна.

3.210 Сонгон шалгаруулалтад “НАБСАН” ХХК болон “Тэргүүн инвест” ХХК-ийн түншлэл, “Эс энд Эй Трэйд” ХХК болон “Бридж Констракшн” ХХК-ийн түншлэл, “ЧММ” ХХК болон “Сан” ХХК-ийн түншлэл тус тус шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.

3.211 “Загийн усны хоолойгоос ус татах шугам хоолойн барилга угсралтын ажил” 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 90.4 хувийн хэрэгжилттэй байна.

Уурхайн суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын төсөл /Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг орон нутгийн зэрэглэлтэй хот болгон хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг/

3.212 Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх ажлын хүрээнд БХБС-ын 2020 оны 224 дугаар тушаалын дагуу “Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК, “Тавантолгой төмөр зам” ТӨХК, “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХК зэрэг байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулсан ажлын хэсэг Өмнөговь аймгийн Цогтцэций сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, цаашид шинэчлэн боловсруулах талаар санал бэлтгэх чиг үүрэгтэй ажилласан байна.

3.213 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “А6-20” дунд хугацааны бизнес төлөвлөгөө, 2021 оны хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтад “Эрхэт констракшн” ХХК-ийг зураг төслийн гүйцэтгэгчээр шалгарч, нийт 500.3 сая төгрөгийн үнийн дүн бүхий ЭТТ-2021/748 дугаартай гэрээг 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан байна.

3.214 “Эрхэт констракшн” ХХК нь “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний баримт бичгийг боловсруулж, Өмнөговь аймгийн ИТХ, Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөл, БХБЯ-ны Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөл, Барилга хөгжлийн төв зэрэг эрх бүхий байгууллагуудаар батлуулсан бөгөөд “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2023 оны 10 дугаар сарын байдлаар нийт 490.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Кокс-эрчим хүчний төсөл

3.215 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс УИХ, Засгийн газраас баталсан тогтоол, шийдвэр болон бодлого төлөвлөлтийн баримт бичигт үндэслэн дунд хугацааны А6-20 бизнес төлөвлөгөөнд Кокс-эрчим хүчний төслийг хэрэгжүүлэхдээ бэлтгэл ажлыг болох туршилт судалгаа, техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлыг 2022 оноос эхлүүлж, бүтээн байгуулалтын ажлыг 2025 оноос эхлүүлэхээр төлөвлөсөн байна.

3.216 Олон улсын мэргэжлийн зөвлөх компани John T Boyd-ын хөндлөнгийн хараат бус техникийн тайлангийн хүрээнд 2020 онд Shanxi Zhongxin Clean Coal Technology Design institute Co., LTD Кокс-эрчим хүчний үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулсан бөгөөд уг урьдчилсан ТЭЗҮ-ийг Монгол Улсын стандарт, шаардлагад нийцүүлэн боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийн шалгаруулалтад дараах компаниуд шалгарч, гэрээ байгуулсан байна.

- *Коксын үйлдвэрийн ТЭЗҮ-ийг гүйцэтгэгчээр “Белохоризонт” ХХК нь шалгарч 99.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдөр,*
- *Коксоос эрчим хүч гаргах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг гүйцэтгэгчээр “Эм Эм Маркет” болон “Смарт энерги групп” ХХК-ийн түншлэл шалгарч 168.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр тус тус байгуулсан.*

3.217 Белохоризонт ХХК ТЭЗҮ-ийг 2023 оны 2 дугаар сард УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн магадлуулж, ажлыг бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөн, “Эм Эм Маркет” ХХК ТЭЗҮ-ийг 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдөр ирүүлсэн ба ЭХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Эрдэнэ тавантолгой ХК-ийн зүгээс дээрх компаниудад нийт 260.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Зээлийн санхүүжилт - ШИВЭЭ-ОВОО ХК, БАГАНУУР ХК

3.218 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Засгийн газрын 2018 оны 132 дугаар тогтоол, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Эрдэнэс Монгол” ХХК-аар дамжуулан зээлийн санхүүжилтийн гэрээ байгуулж, “Багануур” ХК-д 28.6 тэрбум төгрөг, “Шивээ-овоо” ХК-д 16.8 тэрбум төгрөгийг богино хугацаат өр төлбөрийг барагдуулах, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор олгосон байна.

3.219 Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 35 дугаар тогтоолд заасны дагуу Шивээ Овоо ХК-д жилийн 2 хувийн хүүтэй нөхцөлөөр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр төлөгдөж дуусахаар 8.7 тэрбум, Багануур ХК-д жилийн 2 хувийн хүүтэй нөхцөлөөр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр төлөгдөж дуусахаар 9.2 тэрбумын зээлийн санхүүжилтийн гэрээ байгуулж олгосон байна.

3.220 “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар “Шивээ Овоо” ХК-д нийт 25.5 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгосноос 2.0 тэрбум төгрөгийг эргэн төлж 24.5 тэрбумын зээлийн үлдэгдэлтэй, “Багануур” ХК-д нийт 37.8 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгосноос 412.5 сая төгрөгийг эргэн төлж, 39.2 тэрбумын зээлийн үлдэгдэлтэй байна.

Бортээгийн уурхайн гэрээт олборлогчийг сонгон шалгаруулах тендер (хуурай баяжуулах үйлдвэр)

3.221 “Бортээгийн уурхайн гэрээт олборлогчийг сонгон шалгаруулах” нээлттэй тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр 3 удаа зохион байгуулсан байна. Тендерийг 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр, 09 дүгээр сарын 16-ны өдөр тус тус зарласан байна.

3.222 Тендер шалгаруулалт зохион байгуулахдаа эхний тендерийг тодорхой үндэслэлгүйгээр цуцалж, хоёр дахь тендер шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулсан Үнэлгээний хороог, гурав дахь тендер шалгаруулалт зохион байгуулахаас хоёр өдрийн өмнө өөрчилсөн нь “МТАС” түншлэлд давуу байдал үүсгэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой байсан гэж үзэхээр байна.

3.223 Гурав дахь тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны А/350 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан байна. Тус Үнэлгээний хороо ТББ-т доорх өөрчлөлтийг оруулжээ.

3.224 ТББ-ийн ТШӨХ-ийн (4.5)-д “...гэхдээ гишүүн тус бүр 4.2. (е) 2, 4.4 (а), (б) болон (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг /зөвхөн уулын ажил, өрөмдлөгө, тэсэлгээний ажилд хамаарна/.....” гэсэн нь тендерийн баримт бичгийн ТӨӨЗ-ны 4.5-д “Тендерт оролцогч 4.4 (а), (б) болон (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно. Гэхдээ гишүүн тус бүр 4.4 (а), (б) болон (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна. Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийн тендерээс татгалзана.” гэж заасантай нийцэхгүй байна.

3.225 Тендер шалгаруулалт зохион байгуулахдаа эхний тендерийг тодорхой үндэслэлгүйгээр цуцалж, хоёр дахь тендер шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулсан Үнэлгээний хороог гурав дахь тендер шалгаруулалт зохион байгуулахаас хоёр өдрийн өмнө өөрчилсөн нь “МТАС” түншлэлийн гишүүн “Админерал” ХХК болон “Таван хур” ХХК-д давуу байдал үүсгэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой байсан гэж үзэхээр байна.

3.226 Үнэлгээний хороо /ТББ-т “Сүүлийн 3 жил буюу 2018, 2019, 2020 онуудын нийт борлуулалтын орлого нь төсөвт өртөгийн 15 хувь буюу 107,393,418,195 төгрөгөөс багагүй байна.”/ Түншлэлийн гишүүдийн үзүүлэлтийг 4.5 дахь заалтын дагуу нэмж тооцно/ гэж оруулсан нь “Админерал” ХХК, “Таван хур” ХХК болон “Монголиан контракт майнинг сервис ХХК-д давуу байдал үүсгэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой байсан гэж үзэхээр байна.

3.227 “Монголиан контракт майнинг сервис” ХХК-ийн 2018, 2019, 2020 оны борлуулалтын орлого 92,256,758.0 мян төгрөг бөгөөд хоёр дахь тендерт уг шаардлагыг хангахгүй гэсэн шалтгаанаар шалгаруулаагүй тул гурав дахь тендер шалгаруулалтаар “МТАС” түншлэлийн гишүүдийн борлуулалтын орлогыг нэмж тооцох замаар түншлэлийг төлөөлөх эрх бүхий этгээд “Монголиан контракт майнинг сервис” ХХК болон түншлэлд бүхэлд нь давуу байдал олгосон байна.

3.228 ТШӨХ 4.2 (г) –д Нүүрс баяжуулах хэсэгт ZM-600 эсхүл түүнтэй дүйцэх хүчин чадалтай үйлдвэр худалдан авахаар тусгасан байсан. 2021 оны 09сарын 14-ны өдрийн Уул уурхай, технологийн газраас ирүүлсэн Ажлын даалгавартаа “Хуурай аргын технологи бүхий 50-аас дээш хувийн гарцтай, жилд 1 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэр байна” гэж өөрчилсөн. Энэ нь “Админерал” ХХК-ийн хуурай баяжуулах үйлдвэрийн төсөлтэй урьдаас нийцүүлсэн үйлдэл гэж харахаар байна.

3.229 ТШӨХ-ийн 4.4.б-д “Сүүлийн 3 жилийн /2018, 2019, 2020 он/ аль нэг жилд ашигт малтмалын баяжуулах, ангилан ялгалтын үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай судалгаа хийсэн тухай тайлан, баяжуулах технологийг нэвтрүүлсэн тухай нотлох баримт бичиг /дээрх бичиг баримтуудын аль нэгийг ирүүлж болно/, ижил төстэй баяжуулсан нүүрсний лабораторийн үр дүнгийн тухай дүгнэлт зэргийг хавсарган ирүүлнэ” гэж заасан байсныг “Монгол Улсад хуурай баяжуулах, ангилан ялгалтын үйл ажиллагаа эрхлэхээр судалгаа боловсруулсан байх нотлох баримт бичиг ирүүлэх /технологийн хувьд хамгийн өндөр үр ашигтай байх ширхэглэлийн хэмжээг хангах шаардлагатай байна/” гэж өөрчлөн тусгасан нь Админерал ХХК-ийн баяжуулах үйлдвэрийг шууд сонгох давуу байдал үүсгэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.230 Тендерийн баримт бичигт “Тендерт оролцогч 4.2 (е) 2, 4.4 (а), (б) болон (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно. Гэхдээ гишүүн тус бүр 4.2(е) 2, 4.4 (а), (б) болон (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг /зөвхөн уулын ажил, өрөмдлөг, тэсэлгээнд хамаарна/, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна. Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийн тендерээс татгалзана” гэж оруулсан уг өөрчлөлт нь тухайлсан этгээдэд буюу “Админерал” ХХК-д давуу байдал олгосон гэж үзэх үндэслэлтэй байна.

3.231 Эдгээр өөрчлөлт нь уулын ажил, өрөмдлөг, тэсэлгээний ажил гүйцэтгэгчээс бусад этгээдийн чадварыг үнэлгээнд харгалзахгүй байх үндсэн зорилготой буюу санхүүгийн болон техникийн чадавхигүй, ажлын туршлагагүй этгээдэд тендерт оролцох боломж олгож байна.

3.232 Тендерт шалгарах этгээдэд зориулж доорх өөрчлөлтийг тендер зарласнаас хойш Үнэлгээний хорооны гишүүн Д.Уужимсанаагийн дотоод албан бичгийг үндэслэн ТББ-т “ТШХ болон Гэрээний тусгай нөхцөлд “Тендерт оролцогчид нь Бортээгийн уурхайгаас өөрсдөө олборлосон, баяжуулсан нүүрс болон завсрын бүтээгдэхүүнийг зах зээлийн ханшаар борлуулах үүрэг хүлээнэ”, “Захиалагч 6.4 дүгээр зүйлд заасан холбогдох баримт бичгүүдийн хамт төлбөрийн нэхэмжлэлийг хүлээн авсанаас хойш ажлын 10 хоногийн дотор төлбөрийг нүүрсээр тооцож хийнэ” гэж тусгасан нь “МТАС” түншлэлд давуу эрх олгосон байна.

3.233 Түншлэлийн гишүүн “Админерал” ХХК нь 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр үүсгэн байгуулагдсан тул байгуулагдсанаас нь хойш 2 сарын дараа зохион байгуулагдаж буй тендерт оролцох санхүүгийн болон техникийн чадавх, туршлагыг огт хангаагүй байсан буюу тендерт оролцох боломжгүй юм.

3.234 Үнэлгээний хороо ирүүлсэн тендерийг хянаж үзээд “Монголиан контракт майнинг сейрвис” ХХК, “Таван хур” ХХК, “Админерал” ХХК, “Спейшлмайнинг сервис” ХХК-уудын “МТАС” түншлэлийн ирүүлсэн тендерийг шаардлагад нийцсэн гэж үзэж, 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлж, 2021 оны 11 дүгээр сарын 17-ний өдөр 715,9 тэрбум /нүүрс баяжуулах ажлын нэгж үнэ 17,100 төг/тн, уулын цулын ажлын нэгж үнэ 12,000 төг/м3/ төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 36 сарын хугацаатай байгуулсан байна.

3.235 Улмаар “Админерал” ХХК үйлдвэр болон бусад барилга байгууламж барих зорилгоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Бор тээгт 35 га газар ашиглах эрхийн гэрчилгээг 2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр авсан байна.

3.236 Дээрх баримтаас харахад “Бортээгийн уурхайн гэрээт олборлогчийг сонгон шалгаруулах” үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалт, худалдан авалт гэж дүгнэх үндэслэл тогтоогдохгүй байгаа нь энэ үйл ажиллагаа хөрөнгө оруулалт, худалдан авалт бус зөвхөн “Админерал” ХХК-д илт давуу байдлыг ТБОНӨХБАҮХАТХ-ийг ашиглан олгосон үйлдэл гэж үзэх үндэслэлтэй байна.

3.237 “Эрдэнэс Тавантолгой” ХК-д Бортээгийн уурхайг ашиглах, ашиглахдаа хуурай аргаар баяжуулах зүй ёсны шаардлага байсан хэдий ч хэрэгжүүлэхдээ тухайн уурхай дээр хувийн хөрөнгөөр үйлдвэр бариулж “Админерал” ХХК-д илт давуу байдлыг олгосон хууль бус үйлдэл гэж дүгнэхээр байна.

3.238 Баримтаар нотлогдож буй дээрх үйлдлүүд нь хуурай аргаар баяжуулах үйлдвэрийг “Эрдэнэс Тавантолгой” ХК өөрийн хөрөнгөөр барих эсхүл Монгол Улсын Төр, хувийн хэвшлийн тухай хууль /“Концесын тухай хууль”/-ийн хүрээнд үйлдвэр барих ажиллагааг зохион байгуулж тодорхой хугацааны дараа өмчлөх эрх үүсгэх хуулийн эрх, зүйн орчин нээлттэй, санхүүгийн боломжтой байхад түүнийг ашиглахгүй, ТБОНӨХБАУХАТХ-ийг ашиглан үйлдлээ халхавчлах замаар “Админерал” ХХК-д Бортээгийн уурхайд баяжуулах үйлдвэр байгуулах эрх олгох үйл ажиллагаа байсан гэж дүгнэж байгаа тул уг үйл ажиллагааг хууль хяналтын байгууллагаар шалгуулах шаардлагатай байна.

Hongkong Hengde Co Ltd компаниас сайжруулсан шахмал түлш арилжааны гэрээгээр авсан асуудал

3.239 Хяналт шалгалтын хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас Hongkong Hengde Co Ltd -тай байгуулсан “Нүүрсээр сайжруулсан шахмал түлш арилжих тухай гэрээ” /цаашид арилжааны гэрээ гэх/-тэй холбоотой 2022 онд хамаарах нотлох баримтуудыг гаргуулан авахаар “Эрдэнэс Тавантолгой” ХК, Эрчим хүчний яам, Байгаль орчин, аялал жуучлалын яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, “Тавантолгой Түлш” ХХК-д хандаж шаардлагатай баримт материалыг нотлох баримтын шаардлага хангуулан авсан.

3.240 Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос хяналт шалгалтад шаардлагатай баримт материалыг ирүүлэхийг албан бичгээр удаа дараа шаардсан боловч 6 зүйлийн баримт бичиг шаардсанаас зөвхөн 1 зүйлийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд бусад нь архивд байхгүй гэсэн хариуг өгч байсан.

3.241 Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2022 оны 2 дугаар сард зохион байгуулагдсан 3 дугаар хуралдааны үеэр “Админерал” ХХК-иар дамжуулан шахмал түлш нийлүүлэх асуудал танилцуулагдсан.

3.242 Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Б.Алтанзулаас “Эрдэнэс Тавантолгой” ХК-нд хүргүүлсэн 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 2022/217 дугаартай “Санал хүргүүлэх тухай” албан бичигт “... нүүрсийг коксжсон нүүрсийг хагас коксон түлшээр солих гэрээний төсөлд саналаа ирүүлэх”-ийг хүссэн байна. Нүүрс хүлээн авагч тал нь БНХАУ-ын Hongkong Hengde Co Ltd байна гэж ирүүлжээ.

3.243 Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой түлш” ХК, “Админерал” ХХК-тай хамтарсан ажлын хэсэг байгуулж, тус ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн сайжруулсан шахмал түлш авч, коксжих нүүрс нийлүүлэх тухай ЭТТ-2022/518 дугаартай, гэрээг 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр гадаадын хуулийн этгээд Hongkong Hengde Co Ltd -тай байгуулсан

3.244 Гэрээг Орчны Бохирдлыг Бууруулах Үндэсний Хорооны 2022 оны 6 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан гэх боловч уг тогтоол болон шийдвэрийн талаар мэдээ, мэдээлэл, нотлох баримт гаргуулахаар удаа дараа хандсан боловч шаардсан баримт яамны архивд байхгүй гэсэн хариу өгсөн. Уг гэрээнд:

- *Hongkong Hengde Co Ltd нь 400,000 тн химийн үйлдвэрлэлийн шахмал хагас коксон түлш, 100,000 тн нунтаг кокс нийлүүлнэ;*
- *“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Түлш нийлүүлэх цэгээс хамаарч 1 тн шахмал түлш : 1.4-1.74 тн коксжих нүүрс харьцаатайгаар нийлүүлэх;*
- *“Эрдэнэс Тавантолгой” ХК нь уурхайн амнаас БНХАУ-ын нэрлэсэн боомт хүртэлх нүүрс тээврийг хариуцах, Hongkong Hengde Co Ltd нь түлшийг БНХАУ дахь тээвэр болон нэрлэсэн боомтод хүргэх, нэрлэсэн боомтоос “Тавантолгой Түлш” ХХК-ийн Зүүн бүсийн үйлдвэр хүртэлх тээврийг “Эрдэнэс Тавантолгой” ХК хариуцах ба Hongkong Hengde Co Ltd тээврийн хөлсийг төлсөн тохиолдолд хатуу коксжих нүүрсээр төлөх;*
- *Сул коксжих нүүрсний үнэ уурхайн ам нөхцөлөөр 79.56 ам.доллар, Гашуунсухайт боомт бол 100.94 ам.доллар, хатуу коксжих нүүрс уурхайн ам нөхцөлөөр 113.65 ам.доллар, Гашуун сухайт боомт нөхцөлөөр 144.20 ам.доллар байх*

- Түлшний үнийг “Тавантолгой түлш”, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо хэлэлцэн тохирч, баталсан үнээр тооцно
- Нүүрс импортлохтой холбоотой бүх татварыг Hongkong Hengde Co Ltd хариуцах зэрэг зохицуулалт туссан байна.

3.245 Энэхүү нэгжийн өртгөөр тооцон Hongkong Hengde Co Ltd-ийн нийлүүлэх 109,000 тн хагас кокжсон шахмал түлшний үнийг тооцож үзвэл 290.7 тэрбум төгрөг байна.

3.246 БОАЖС бөгөөд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргын 2022.08.12-ны А/39 тоот тушаалаар Хагас коксыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тээвэрлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.

3.247 Ажлын хэсэгт Орчны бохирдлыг бууруулах үндэсний төв, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой Түлш” ХХК, Авто тээврийн үндэсний төвийн төлөөлөл орсон боловч ажлын хэсгийн хурлуудад Админерал ХХК-ний төлөөлөл н.Мөнхтамга гэх хүн оролцож байсан.

3.248 2022 оны 11 дүгээр сард “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хагас кокс болон нүүрс тээвэрлэлттэй холбоотой ЭТТ-2022/518 гэрээнд хяналт шалгалтын ажил эхэлснээр уг ажил бүрэн зогссон. Гэрээний дагуу 6,62 тэрбум төгрөгийн үнэ бүхий нүүрс нийлүүлж 10,000 орчим тн сайжруулсан түлш хүлээн авсан гэх мэдээлэл байна.

3.249 ТБОНӨХБАУХАТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.1. “Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна” гэсэн заалтыг зөрчиж Түлш худалдан авах, Түлш болон нүүрс тээвэрлэх ажлыг тендер шалгаруулалтаар зохион байгуулаагүй байна.

3.250 Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажиллах журмын 5.5.6 “Ажлын алба нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан зохих журам, маягт (загвар)-ын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж заасан чиг үүргийг зөрчсөн.

3.251 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь ЭТТ-2022/518 гэрээний дагуу нийт 6,62 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй нүүрс нийлүүлсэн байх ба байгуулсан гэрээний хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой Түлш” ХХК, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтарч уг гэрээг дүгнэх, энэ ажлыг хууль хяналтын байгууллагаар шалгуулах шаардлагатай бөгөөд баримт материал дутуу тул дүгнэлт гаргах боломжгүй байлаа.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-д эрх бүхий байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтууд, тэдгээрийн үр дүнд авсан арга хэмжээ

Төрийн болон хөндлөнгийн аудитын байгууллагын хяналт, шалгалт

3.252 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн тайлангийн аудитыг дараах компаниуд гүйцэтгэж, холбогдох санал дүгнэлт өгч, нийт 76 зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

- “БДО аудит” ХХК 2012, 2016 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт,
- Үндэсний аудитын газар 2013, 2015 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт,
- “Кэй пи эм жи аудит” ХХК 2014 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт,
- “Конфиденсе аудит” ХХК 2017, 2018 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 2019 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт,
- “Гроут финанс аудит” ХХК 2020, 2021 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт,

3.253 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-ийн захиалгаар “Эрнст энд Янг Монголиа аудит” ХХК-аас 2014, 2015 онд хараат бус аудитыг гүйцэтгэж “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

3.254 Үндэсний аудитын газар бүрэн эрхийнхээ хүрээнд “Аудитын сэдэв батлах тухай” тогтоолын дагуу “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2016-2018 оны санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн, хувьцаа хуваарилалт, ногдол ашиг олголт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар 2019 оны 02/349, 02/350, 02/351, 02/352, 02/357 дугаартай албан шаардлага хүргүүлсэн байна.

- Гадаадын бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай холбоотой 5,787.6 сая, дотоодын байгууллагатай холбоотой 257.0 сая төгрөг, Сангийн яамтай холбоотой 6,591.6 сая төгрөгийн авлага, дотоодын байгууллагуудтай холбоотой 5,823.5 сая төгрөгийн өглөг, нийт 18,459.7 сая төгрөгийн авлага өглөгийн үлдээдлийг баталгаажуулж, тооцоо нийлээгүй;

- Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Д.Ариунболд 2017 оны А/218 дугаар тушаал гарган Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын эмзэг бүлгийн 10 өрхөд 25.0 сая төгрөгийн үнэ бүхий таван ханатай гэр, 2.0 сая төгрөгийн замын зардал зарцуулсан Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг дагаж мөрдөөгүй;
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүдийн цалинг 1.8 сая төгрөг, бусад гишүүдийн цалинг 1.3 сая төгрөгөөр тогтоосон нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолтой нийцээгүй;
- Аудитын багт шаардсан хугацаанд мэдээллийг бүрэн гүйцэт, үнэн зөв ирүүлээгүй, Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан;
- Хөрсний овоолгын хэмжээг алдаатай тайлагнасан нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.2-т заасантай нийцээгүй байна.

3.255 Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/36 дугаар тушаалаар баталсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах дүгнэлтийг гаргасан байна.

- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хэрэгжилтэд ахиц дэвшил гараагүй нь оролцогч талуудын хамтын ажиллагаа хангалтгүй, бүх түвшинд хариуцлага, хяналтын тогтолцоо сул байгаагаас шалтгаалсан;
- Тавантолгой ордыг нэгдсэн төлөвлөлтөд үндэслэн үр ашигтай цогц байдлаар ашиглахгүй байгаа нь ордын үнэ цэнийг бууруулахад нөлөөлсөн;
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаа зах зээлийн зарчмаар бус төрөөс хэт хамааралтай байгаа нь ордыг нэгдсэн төлөвлөлт, цогц байдлаар үр ашигтай ашиглах боломжийг хязгаарлаж байна.

Татварын байгууллагын хяналт, шалгалт

3.256 Татварын байгууллагаас “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2011-2019 оны үйл ажиллагаанд дараах татварын хяналт шалгалт хийсэн бөгөөд 2020-2023 онд тус компанийг “Өндөр эрсдэлтэй” гэж тодорхойлсон хэдий ч 2019 оноос хойш татварын иж бүрэн шалгалт хийгээгүй байна.

Хүснэгт 21 Татварын байгууллагаас “Эрдэнэс Тавантолгой” ХК-д татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийсэн мэдээлэл

№	Хяналт, шалгалт явуулах шийдвэрийн агуулга	Татварын улсын байцаагчийн акт баталгаажсан огноо
1	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2012 оны 02/875 тоот албан бичгийн дурдсан “Компанийн удирдлагууд солигдсонтой холбоотой татвар ногдуулалт, төлөлтийн байдлыг шалгуулах тухай” хүсэлтээр, Татварын ерөнхий газрын, Хяналт шалгалтын хэлтсийн даргын (21/12) 0303 тоот томилолтын дагуу 2011 оны татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийсэн.	2012.12.14
2	Татварын ерөнхий газрын дэргэдэх Улсын төсвийн орлого, хяналтын газрын, хяналт шалгалтын хэлтсийн даргын 2013 оны (21/13) 0325 тоот томилолтын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2012 оны татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийсэн.	2013.03.05
3	Татварын ерөнхий газрын дэргэдэх Улсын төсвийн орлого, хяналтын газартай харьцдаг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2013-2016 оны татварын ногдуулалт, төлөлтийн байдалд Татварын хяналт шалгалт хийх томилолт, Татварын хяналт шалгалт хийх ерөнхий удирдамж, Төлөвлөгөөт /бүрэн/ шалгалт хийсэн.	2017.05.15
4	Том татвар төлөгчийн газартай харьцдаг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2017-2019 оны татварын ногдуулалт, төлөлтийн байдалд /эрсдэлд суурилсан/-ийн дагуу татварын хяналт шалгалт хийх ерөнхий удирдамж, 3620103232 тоот томилолтын дагуу иж бүрэн шалгалт хийсэн.	2021.03.00

Эх сурвалж: Татварын Ерөнхий газар

3.257 Татвар нөхөн ногдуулах, алданги, торгууль ногдуулах хөөн хэлэлцэх хугацааг УИХ-аас 2019 онд баталсан Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-д 4 жил гэж хуульчлан тогтоосон бөгөөд 2020 онд хамаарах татвартай холбоотой хэрэг, зөрчлийг “хөөн хэлэлцэх хугацаа” дуусгавар болсон үндэслэлээр хэрэгсэхгүй болгох эрсдэл үүсэхээр байна.

3.258 Татварын хяналт шалгалтын хүрээнд татварын улсын байцаагчийн тогтоосон актыг Татварын маргаан таслах зөвлөлийн хурал болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нэхэмжлэлээр гурван шатны шүүхээр хэлэлцэж дараах шийдвэрийг гаргасан байна.

- Татварын улсын байцаагчийн 2017 оны 210022565 дугаар актад шалгалтаар илэрсэн 31.1 тэрбум төгрөгийн зөрчилд 6.7 тэрбум төгрөгийн нөхөн татвар, 0.5 тэрбум төгрөгийн хүү, 2.3 тэрбум

төгрөгийн торгоуль, 2.3 тэрбум төгрөгийн алданги, нийт 11.3 тэрбум төгрөгийн төлбөр ногдуулсныг Татварын маргаан таслах зөвлөлийн 2018 оны 20 дугаар тогтоолоор нийт 10.8 тэрбум төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2019 оны 14 дүгээр тогтоолоор 7.1 тэрбум төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр шийдвэрлэсэн;

- Татварын улсын байцаагчийн 2021 оны НА-2121000028 дугаар актад шалгалтаар илэрсэн 318.5 тэрбум төгрөгийн зөрчилд 46.9 тэрбум төгрөгийн нөхөн татвар, 14.1 тэрбум төгрөгийн торгоуль, 1.2 тэрбум төгрөгийн алданги, нийт 62.2 тэрбум төгрөгийн төлбөр ногдуулсныг Татварын маргаан таслах зөвлөлийн 2021 оны 16 дугаар тогтоолоор нийт 34.6 тэрбум төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2023 оны 001/ХТ2023/0016 дугаар тогтоолоор 17.6 тэрбум төгрөгийн төлбөр төлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Тавантолгой” ХК-ийн олборлолт, борлуулалт, тээвэр, худалдан авах үйл ажиллагаа, санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдэд оролцсон хуулийн этгээдийн хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдлыг хянасан байдал

3.259 Хяналт шалгалтын ажлын хүрээнд УБЕГ-аас ирүүлсэн 32 мянга гаруй хуудас буюу 564МВ файл бүхий хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагааны мэдээлэл(өгөгдлийн сан-1)-ийг түшиглэн 2011 оноос хойш улс төрийн өндөр албан тушаалтан болон дараах байгууллагуудын ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын багт ажиллаж байсан болон ажиллаж байгаа албан тушаалтан, ИТХ-ын төлөөлөгч тэдгээрийн хамаарал бүхий 5882 иргэн дээр бүртгэлтэй 16253 хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанд бүртгэгдсэн мэдээллийг хүлээн авсан.

- *Өмнөговь аймгийн ИТХ, Өмнөговь аймгийн Ханбогд сумын ИТХ, ГЕГ, ЗХЖШ, ХХЕГ, ТЕГ, ЦЕГ, АТГ, УЕПГ, АТУТ-ын удирдлага, “Эрдэнэс Тавантолгой” ХК, Тавантолгой ХК, “Эрдэнэс Монгол” ХХК, “Монголын төмөр зам” ТӨХК, Тавантолгой төмөр зам ХХК, “Тавантолгой Түлш” ХХК, Гашуунсухайт автозам ХХК*

3.260 Хамаарлын судалгааг боловсруулахдаа шинжээчид Эрдэнэс Тавантолгой ХК, Тавантолгой ХК-ийн олборлолт, борлуулалт, тээвэр, худалдан авах үйл ажиллагаа, санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийг хариуцсан “А баг” болон “хамаарлын судалгааг хариуцсан “Б баг” гэх байдлаар хоёр тусдаа ажиллах зарчим баримталсан.

- “А баг”-аас ирүүлсэн тухайн судалж буй сэдэвт хамаарах хуулийн этгээдийн жагсаалт тус бүрийг “Б баг” УБЕГ-т илгээж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагааны мэдээллийг файл хэлбэрээр хүлээн авсан. “Б баг” хамаарал бүхий этгээд, нэгдмэл сонирхолтой этгээд, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдлыг тодорхойлохдоо “өгөгдлийн сан-1” болон “өгөгдлийн сан-2” тус бүрд агуулагдах файлуудад огт боловсруулалт хийгээгүй болно.
Хоёр тусдаа өгөгдлийн санд агуулагдах давхардаагүй тоогоор нийт 30977 хуулийн этгээд дээр идэвхтэй, идэвхгүй байдлаар бүртгэгдсэн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигч, эрх барих этгээд, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд давхардаагүй тоогоор нийт 68,247 иргэн, хуулийн этгээдийн давтагдахгүй цорын ганц өгөгдөл болох регистрийн дугаарыг өгөгдлийн шинжилгээний “Rstudio” программ дээр бодолт хийх байдлаар тулгалт хийхэд давхардаагүй тоогоор “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн дагуу 3.1.5.“хамаарал бүхий этгээд” гэж тодорхойлогдох 118, 3.1.6.“нэгдмэл сонирхолтой этгээд”-д гэж тодорхойлогдох 418, 3.1.11. “ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж тодорхойлогдох 289 илэрцийн үр дүн тус тус гарсан болно.

ДӨРӨВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо нь холбогдох хууль, ажлын төлөвлөгөө, хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Тавантолгой ХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дараах дүгнэлтийг гаргалаа.

“Тавантолгой” ХК-ийн хувьд:

1. Өмнөговь аймгийн ИТХ нь 51 хувийн хувьцаа эзэмшигчийн төлөөллөө үр ашигтай хэрэгжүүлээгүйгээс нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон түүний хамаарал бүхий этгээд компанийн ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан төдийгүй зарим улс төрд нөлөө бүхий этгээд, ИТХ-ын төлөөлөгч, ТУЗ-ийн гишүүний хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээдийн компани нүүрсний борлуулалтын гэрээ, хөрсний ажлын гэрээ байгуулж байсан байна.
2. Хөрс хуулалтын ажил гүйцэтгэгч болон бусад бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөөгүй, нүүрс худалдан авагчийг хэрхэн сонгон шалгаруулж байсан нь тодорхойгүй, ТУЗ-ийн тогтоолоор нүүрсний үнэ, их хэмжээний хэлцэлд хамаарахгүй гэрээ, хэлцэл болон ажил гүйцэтгэгч, нүүрс худалдан авагчийн жагсаалтыг баталж ирсэн байна.
3. Өмнөговь аймгийн ИТХ-ын зүгээс компанийн үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд тавих хяналт хангалтгүй, ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, эрх бүхий хөндлөнгийн хяналтын байгууллагуудын хяналт шалгалт үр нөлөөгүйгээс худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчим бүрэн хэрэгжээгүй байна.
4. Архивын сан хөмрөгийн бүрдэл, бүртгэл хангалтгүй, анхан шатны нотлох баримтууд иж бүрэн бус, архив болон цахим системийн дата бүрэн хадгалагдаагүй, баримт материалаа хүлээлцээгүй, цаг хугацааны хязгаарлагдмал байдал зэрэг нь хяналт шалгалтын үйл ажиллагааг хязгаарлахад хүргэсэн болно.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьд:

5. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаа төрөөс хэт хамааралтай²² байгаа нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөл бие даан шийдвэр гаргах боломжийг хязгаарлаж, компанийн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, компанийн үнэ цэнэ, олон улсын зах зээлээс санхүүжилт босгох боломж, компанийн сайн засаглалыг бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлж байгаа нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас гаргасан компанийн засаглалын суурь зарчмыг алдагдуулж байна.
6. Тавантолгой ордын цанхийн хэсгийн батлуулсан ТЭЗҮ-д тусгасан нэмүү өртөг шингээх төслүүдийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас шалтгаалан нүүрсний III, IV давхаргын сайн чанарын коксжих нүүрсийг сорчлон (нийт олборлосон нүүрсний 92% нь коксжих нүүрс байна.) олборлож байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь заалттай нийцэхгүй байна.
7. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2011-2023 онуудад нийт 944 гэрээгээр 13.3 их наяд төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд хяналт шалгалтад 500 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 11,5 их наяд төгрөгийн 92 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг нягтлахад 4,8 их наяд төгрөгийн дүн бүхий 40 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа хуульд нийцээгүй байна. (2011-2014 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан тус компанийн архивд байхгүй тул хяналт шалгалтын нэгдсэн дүнд ороогүй болно.)

²²Эрдэнэс Тавантолгой ХК үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойших компанийн орлого, ашгаас Төрийн шийдвэрээр нийт 1,196.5 тэрбум төгрөгийг нийгмийн болон төсвийн шинж чанартай асуудлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

8. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2011-2023 оны 10 сар хүртэл хугацаанд 398 гэрээгээр 110.1 сая тонн буюу 20.2 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн бөгөөд нийт нүүрсний борлуулалтын гэрээний сарын дундаж үнийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тухай бүр мөрдөгдөж байсан үнэ тогтоох аргачлалын үнэтэй харьцуулан нийт гэрээний үнийн зөрүүг тооцоход алдагдсан боломжийн зардал ойролцоогоор 826.4 сая ам.доллар байна.
9. Засгийн газрын 2010 оны 350 дугаар тогтоолын 3-т “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны үнэлгээг зөвлөх үйлчилгээний компанитай хамтран тогтоох талаар үүрэг өгсөн боловч “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эзэмшиж буй Тавантолгойн ордод үнэлгээ хийж компанийн хувьцааны нэрлэсэн үнийг тогтоохгүйгээр Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолоор нэгж хувьцааны үнийг 933 төгрөг гэж заасан нь ордын үнэлгээг бодитой тогтоогүй байна.
10. Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолын 2.11-т бонд гаргаж, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээг санхүүжүүлнэ гэж заасан боловч үнэт цаасны арилжаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн 42.0 хувийг гэрээт олборлогчдын төлбөрийг барагдуулахад зарцуулсан байна.
11. “Эрдэнэс Тавантолгой” ХК нь төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, усан хангамж, кокс-эрчим хүчний үйлдвэр зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хамаарах, нэмүү өртөг шингээх 8 төсөлд нийт 5,024.7 тэрбум төгрөг, Засгийн газар, ТУЗ-ийн холбогдох шийдвэрийн дагуу компанийн үндсэн үйл ажиллагаанд үл хамаарах Богдхан төмөр зам, Газрын тос дамжуулах хоолой зэрэг төсөлд нийт 463.2 тэрбум, Тавантолгой түлш ХХК-д 1,069.4 тэрбум төгрөгийн санхүүжилт, “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК-д нийт 63.3 тэрбум төгрөгийн зээл тус тус олгосон байна.
12. “Эрдэнэс Тавантолгой” ХК нь төмөр замын 5 төсөлд мөнгөн хөрөнгө болон нүүрсээр нийт 4,643.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл бүрэн хэрэгжсэн, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажил дуусаж, хөдлөх бүрэлдэхүүн, хөдлөх бүрэлдэхүүний засварын тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдээгүй, Богдхан төмөр замын төсөл судалгааны ажлын түвшинд зогссон байна.
13. Төмөр замын төслийн захиалагч болох Монголын төмөр зам ХХК, Тавантолгой төмөр зам ХХК-иуд нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтыг үндэслэн төслийн ерөнхий гүйцэтгэгч Барилга, инженерийн цэргийн удирдах газар, Улаанбаатар төмөр зам ХНН, “Бодь интернэшнл” ХХК-тай шууд гэрээ байгуулсан, холболтын төмөр замын 218.0 тэрбум төгрөгийн, ТНАЛТ (Тавантолгойн нүүрс ачилтын логистикийн төв)-ийн 217.5 тэрбум төгрөгийн үнийн дүн ЕРС гэрээг магадлалаар баталгаажуулаагүй зураг төсөл, үнийн дүнд үндэслэн “Бодь интернэшнл” ХХК-тай байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн бөгөөд ТЭЗҮ-ийн дүнг үндэслэн гэрээний үнийн дүнг 95.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
14. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар нийт 2.3 сая тн ачаа тээвэрлэсэн хэдий ч зүтгүүр, вагоны тоо хангалтгүйгээс төмөр замын ашигт ажиллагаа ТЭЗҮ-д заасан хэмжээнд хүрээгүй байна. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар нийт 488.4 мянган тн нүүрс тээвэрлэсэн бөгөөд одоогоор зураг төслийн ажил үргэлжилж буй хил холболтын төмөр зам ашиглалтад орсноор эхний жилд 10.6 сая тн, 2 дахь жилд 21.1 сая тн, 3 дахь жилд 26.4 сая тн, 4-20 дахь жилүүдэд тус бүр 31.9 сая тн, 21-30 дахь жилүүдэд тус бүр 50.2 сая тн нүүрс тээвэрлэхээр байна.
15. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-иудаас нүүрс худалдан авч экспортолсон аж ахуйн нэгжүүдэд олгосон “С” төрлийн зөвшөөрлийн бичгийн 2010-2017 оны анхан шатны бичиг баримт төрийн байгууллагуудад хадгалагдаагүйгээс хяналт шалгалт хийх боломжгүй, “С” зөвшөөрлийн бичиг олголтын үйл ажиллагаа, түүнээс төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн зарцуулалтад дээд шатны болон хөндлөнгийн аудитын байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй, холбогдох ажлын хэсгийн дарга нар нь ажил үүргээ гүйцэтгэх явцдаа авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдож ял шийтгэгдэж байжээ.

Хяналт шалгалтын бусад асуудлын хүрээнд:

16. Монгол Улсын гаалийн байгууллага экспортолсон нийт нүүрсийг бүртгэхдээ тухайн худалдан авч буй талын бүртгэлтэй улсын нэрээр статистик мэдээлэлд оруулдаг байна. Манай улсаас БНХАУ-аас бусад улс орнууд руу экспортолж буй нүүрс нь БНХАУ-ын хилээр гарч бүртгэгдэж байгаа бөгөөд тус улсын гаалийн байгууллага хэрхэн бүртгэж байгааг тодорхойлох боломжгүй байлаа. Хятадын нүүрсний экспорт, импортын статистик мэдээллийн платформ дахь МУ-аас импортолсон нийт нүүрсний хэмжээг, Дэлхийн банк, НҮБ, дэлхийн худалдааны байгууллагуудын худалдааны статистикийн нэгдсэн мэдээллийн платформын мэдээлэлтэй харьцуулалт хийхэд зөрүү 39 мянган тонн байна. Манай улсын 2013-2022 оны хооронд экспортолсон нийт нүүрсний биет хэмжээг, Хятадын нүүрсний экспорт, импортын статистик мэдээллийн платформ дахь МУ-аас импортолсон нүүрсний тоон мэдээлэлтэй тулган шалгахад БНХАУ-аас бусад улс орон руу экспорт хийсэн дүнг оруулж тооцоход 980.0 мян.тонн илүү, оруулаагүй тохиолдолд 6.1 сая тонны дутуу зөрүү үүсэж байна.
17. Цагаанхад бүсэд байрлах 36 нүүрс ачиж, буулгах терминалын пүүний программд бүртгэгдсэн ачилтын мэдээлэл болон ГЕГ-ын CAIS систем дэх гаалийн бүрдүүлэлтийн дотоод манифестын өгөгдлийг MS Access програм уншуулан тулган баталгаажуулалт хийхэд олон улсын тээврийн С-зөвшөөрөл бүхий 487 хуулийн этгээдээс 246 тээвэрлэгч нь нийт 52,030 удаагийн тээвэрлэлтээр 5,2 сая тонн нүүрсийг улсын хилээр гаалийн бүрдүүлэлтгүй гаргасан байж болзошгүй байна.
18. Өмнөговь аймгийн Ханбогд суманд гаалийн хяналтын талбай, автотээврийн зогсоол, кемпийн зориулалттай газрыг 2020-2022 онд дуудлага худалдаагаар худалдаагүй бөгөөд дуудлага худалдааны анхны үнэ төлөгдөөгүй байхад газар олгон дараа нь нөхөн төлүүлж, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалттай 34 аж ахуйн нэгжид, 42 эзэмших эрхийн гэрчилгээгээр 475.3 га газар олгосон байна. Мөн 2 хуулийн этгээдэд 4100 га газрыг эрчим хүчний зориулалтаар хууль бусаар газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон байна.
19. “Бортээгийн уурхайн гэрээт олборлогчийг сонгон шалгаруулах” нээлттэй тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр 3 удаа зохион байгуулахдаа тендер шалгаруулалтын шаардлагыг хангаагүй этгээдийн ерөнхий нөхцөл, санхүү болон техникийн чадавхад нийцүүлж тендерийн бичиг баримтад өөрчлөлт оруулан шалгаруулж, гэрээ байгуулсан нь нэг этгээдэд давуу байдал үүсгэсэн гэж үзэх үндэслэлтэй байна.
20. Хяналт шалгалтаар “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн дагуу 3.1.5-т "хамаарал бүхий этгээд" гэж, 3.1.6-т "нэгдмэл сонирхолтой этгээд" гэж, 3.1.11-т "ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн улс төрийн нөлөө бүхий этгээдийн хамаарлыг тодорхойлж ажилласан болно.
21. Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг 2023 оны 12 дугаар сарын 04-07, 18-22-ны өдрүүдэд Төрийн ордонд нээлттэй зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор нийт 574 гэрч оролцуулахаар мэдэгдэх хуудас хүргүүлснээс 412 (71.8 хувь) гэрч хүрэлцэн ирж оролцсон байна. Нээлттэй сонсголыг Монголын үндэсний олон нийтийн телевизийн нэг, хоёрдугаар суваг, ТВ8, ТВ9, Тэнгэр телевизүүдээр олон нийтэд хүргэсэн.
22. Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголд 16 хянан шалгагч, шинжээч болон ажиглагчаар Нээлттэй нийгэм форум, Цогц хөгжлийн үндэсний төв ТББ-ын төлөөлөл, Сонсгол даргалагчийн урилгаар УЕПГ, Нийслэлийн прокурорын газар, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар зэрэг төрийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд ажиллалаа.
23. Хоёр үе шаттай зохион байгуулагдсан сонсголын нийт 67 цаг 23 минут үргэлжилж, 831 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл гарсан байна.

ТАВ. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

“Тавантолгой ХК”-ийн талаар

1. “Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн 51 хувийн хувьцааг УИХ-ын 1999 оны “Аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай” 29 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн өмчлөлд шилжүүлсэн асуудал болон хувьцаа эзэмшигчийн төрийн өмчийн төлөөллийн үйл ажиллагаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянан үзэж, шаардлагатай арга хэмжээ авах.
2. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтыг төлөвлөх, сонгон шалгаруулах, тайлагнах, олон нийтэд мэдээлэх, архивын баримтыг бүрдүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТХ, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмыг мөрдөж ажиллах.
3. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг мөрдөж ажиллах, нүүрс ачилт, тээвэрлэлтийн үйл ажиллагааны анхан шатны баримт, пүүний программын мэдээллийн сангийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангуулж ажиллах.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар

4. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаа төрөөс хэт хамааралтай байгаа нь техник, эдийн засгийн үндэслэл, нэгдсэн төлөвлөлтийн дагуу ордыг ашиглах боломжгүй байдалд хүргэж байх тул компанийн засаглалыг сайжруулах хүрээнд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ОECD)-аас гаргасан компанийн засаглал, удирдлагын тогтолцооны үе шат бүхэнд баримтлах зарчмууд, дотоод хяналт ба эрсдлийн удирдлагын тогтолцооны бүтэц, эрх хэмжээг тусгасан засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх баримт бичгүүдэд үндэслэн Компанийн засаглалын бодлого, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, эрх зүйн орчныг бүрдүүлэх.
5. Тавантолгой ордын нөөцийн зэрэглэлийг нэмэгдүүлэх, ордын ашиглалтыг зохистой төлөвлөж, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д заасны дагуу сорчлон ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн төлөвлөлт, удирдлагаар хангаж ажиллах.
6. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эзэмшиж буй 8 тусгай зөвшөөрлийн талбайн эрхийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч, гэрээ байгуулан Улсын бүртгэлд бүртгүүлэх.
7. Цаашид төсвийн шинжтэй, компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээж, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд шаардлагатай төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хяналтыг сайжруулах.
8. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтыг төлөвлөх, сонгон шалгаруулах, тайлагнах, олон нийтэд мэдээлэх, архивын баримтыг бүрдүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТХ, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмыг мөрдөж ажиллах.
9. Нүүрсний салбарын статистик мэдээлэл бүх шатандаа нэршил, ангилал, тоо хэмжээ, үнийн дүнгийн бүртгэл зөрүүтэй байгаа тул хоёр улсын гаалийн байгууллагуудын мэдээллийн урсгалын солилцоог сайжруулах, бүртгэлийн нэг стандартад оруулах, холбогдох бусад төрийн байгууллагуудын мэдээллийн урсгалыг нэг болгож, хяналтыг сайжруулах.
10. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны үнэлгээг хийлгэж, хөрөнгийн биржид нээлттэй арилжаалж, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН
ШАЛГАХ ТҮР ХОРОО**

_____ооо_____

ХАВСРАЛТУУД

Хяналт шалгалтын ажлын явцад цуглуулсан болон судалсан зүйлс, энэхүү тайланд бичигдсэн дүгнэлт, бичвэрийг дэмжих дараах мэдээллийг хавсралтаар тусгав.

Хавсралт 1

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023Q3
Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгө	0.30	31.57	29.90	2.82	65.38	7.13	41.53	88.40	605.26	656.36	134.58	49.18	385.34	596.58
Дансны авлага	-	196.13	325.94	3.24	55.16	38.42	20.09	24.18	49.63	222.96	22.75	2.64	30.76	201.98
Татвар НДШ-ийн авлага	-	-	-	6.52	107.88	8.88	1.87	10.21	0.07	0.54	2.93	5.39	3.47	2.77
Бусад авлага	-	-	-	0.04	0.02	0.40	0.39	0.42	0.40	26.83	8.53	14.39	0.98	3.26
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-	405.74	232.35	1.55	-	6.59	15.33	15.32	0.00	-	-	-
Бараа материал	-	24.86	47.65	185.37	174.38	73.27	66.19	178.22	104.11	105.54	129.69	263.76	393.82	407.19
Урьдчилж төлсөн зардал	-	23.74	12.20	24.35	24.84	13.83	8.57	6.61	8.73	12.33	898.67	1,613.36	1,711.23	2,464.07
Дуусаагүй үйлдвэрлэлийн зардал	-	-	-	46.47	-	-	-	-	-	-	-	-	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй ЭБХ									0.39	0.39	0.39			
Нийт эргэлтийн хөрөнгө	0.30	276.30	415.69	674.55	660.02	143.48	138.64	314.63	783.91	1,040.29	1,197.54	1,948.71	2,525.61	3,675.84
Үндсэн хөрөнгө	-	53.04	44.55	9.18	20.17	25.37	24.09	20.24	31.65	37.42	46.92	110.96	232.65	900.60
Биет бус хөрөнгө	-	13.63	23.89	1.84	10.59	3.51	3.54	11,194.16	11,184.76	11,159.41	11,138.82	11,126.45	11,108.03	11,077.98
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-	-	-	0.35	0.55	0.60	0.58	0.46	312.19	309.34	308.60	1,346.76	1,346.76
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-	-	-	-	-	-	1.22	10.65	13.71	15.83	16.45	18.53	18.70
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-	1.25	-	10.68	14.25	28.85	10.91	0.06	23.30	41.78	116.33	117.63	117.63
Уурхайн хөрөнгө	-	-	-	3.29	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-	-	29.21	94.27	321.53	284.00	304.79	313.16	798.83	1,384.89	1,690.22	2,131.17	2,199.74
Нийт эргэлтийн бус хөрөнгө	-	66.67	69.69	43.52	136.07	365.20	341.08	11,531.90	11,540.73	12,344.86	12,937.58	13,369.02	14,954.77	15,661.40
Нийт хөрөнгийн дүн	0.30	342.97	485.38	718.07	796.09	508.68	479.71	11,846.54	12,324.64	13,385.15	14,135.12	15,317.73	17,480.39	19,337.24
Дансны өглөг	-	24.72	75.93	88.34	74.62	124.08	216.47	80.21	94.02	184.10	370.02	142.60	162.65	249.76
Цалингийн өглөг	-	-	0.33	0.37	0.44	0.57	1.70	0.96	6.59	8.86	8.14	7.38	5.85	6.15
Татварын өр	-	4.26	0.42	3.91	0.03	0.00	1.54	14.43	67.55	88.46	62.93	194.74	472.67	387.70
НДШ-ийн өр	-	0.00	0.10	-	-	-	0.11	0.03	0.08	-	0.00	-	0.37	-
Богино хугацаат зээл	-	-	-	216.01	-	289.82	-	121.36	-	-	330.00	125.11	411.66	-
Хүүгийн өглөг	-	-	2.50	8.72	37.10	60.09	95.90	94.10	(0.00)	-	0.15	15.90	18.06	11.63
Ногдол ашгийн өр	-	-	3.44	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нөөц									10.03	6.80	0.43	34.52	3.63	
Бусад богино хугацаат өр төлбөр											3.95	2.82	2.82	2.82
Урьдчилж орсон орлого	-	308.54	236.48	6.53	70.34	6.02	62.36	149.47	106.94	23.63	339.53	892.86	1,445.59	990.78

Богино хугацаат өрийн дүн	-	337.52	319.20	323.88	182.53	480.57	378.09	460.55	285.22	311.85	1,115.15	1,415.93	2,523.30	1,648.83
Урт хугацаат зээл	-	-	139.21	239.83	536.26	119.76	497.91	121.36	-	-	-	-	-	-
Нөөц	-	-	-	8.92	8.92	15.31	19.98	31.81	31.81	36.60	45.52	72.27	249.82	249.16
Бусад урт хугацаат өр	-	-	7.36	200.98	175.49	85.86	-	-	-	-	880.19	1,572.70	1,146.48	1,146.48
Хойшлогдсон орлогын өр	-	-	0.94	15.91	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-	-	-	-	-	-	-	3.79	6.77	0.00	-	6.68	16.62
Урт хугацаат өрийн дүн	-	-	147.50	465.65	720.67	220.93	517.89	153.16	35.60	43.38	925.71	1,644.97	1,402.98	1,412.27
Нийт өр төлбөрийн дүн	-	337.52	466.70	789.54	903.21	701.50	895.98	613.72	320.81	355.23	2,040.85	3,060.90	3,926.28	3,061.10
Төрийн өмч	-	-	-	0.30	0.30	0.30	0.30	-	-	-	-	-	-	-
Хуьцаат капитал	0.30	0.30	0.30	-	-	-	-	11,196.00	11,196.00	1,196.00	11,196.00	11,196.00	11,196.00	11,196.00
Эздийн өмчийн бусад хэсэг														
Хуримтлагдсан ашиг	(0.00)	5.15	18.38	(71.77)	(107.41)	(193.12)	(416.56)	36.82	807.83	1,833.92	898.27	1,060.83	2,358.11	5,080.14
Нийт эздийн өмчийн дүн	0.30	5.45	18.68	(71.47)	(107.11)	(192.82)	(416.26)	11,232.82	12,003.83	13,029.92	12,094.27	12,256.83	13,554.11	16,276.14
Нийт эх үүсвэрийн дүн	0.30	342.97	485.38	718.07	796.09	508.68	479.71	11,846.54	12,324.64	13,385.15	14,135.12	15,317.73	17,480.39	19,337.24

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ОРЛОГЫН ТАЙЛАН

Үзүүлэлтүүд	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023Q3
Борлуулалтын орлого	26.62	208.76	156.67	400.68	238.34	467.13	1,182.36	1,986.87	2,660.97	1,547.69	1,126.83	3,494.47	6,689.25
ББӨ	17.98	146.39	127.80	372.11	139.92	373.27	381.18	680.58	695.66	672.71	437.36	708.91	1,576.94
Нийт ашиг (алдагдал)	8.64	62.37	28.87	28.56	98.43	93.87	801.19	1,306.30	1,965.31	874.98	689.48	2,785.56	5,112.31
Түрээсийн орлого	-	-	-	-	-	-	-	0.08	0.11	0.16	0.19	0.18	0.15
Хүүний орлого	-	-	0.03	0.20	0.31	0.37	1.95	4.04	27.51	24.16	1.98	1.98	12.35
Бусад орлого	-	-	34.17	0.51	1.14	18.55	9.69	21.13	7.01	4.56	36.16	104.87	11.40
Борлуулалтын зардал	-	-	0.16	-	-	70.53	159.87	278.69	351.07	324.32	321.50	807.27	1,444.07
Удирдлагын зардал	4.55	43.93	4.50	5.31	29.88	6.18	10.83	16.64	19.61	18.04	22.17	23.48	18.73
Санхүүгийн зардал	-	-	-	-	51.99	54.40	39.52	4.59	-	10.42	61.40	101.63	55.65
Бусад зардал	-	-	42.49	11.87	16.30	10.41	16.87	28.72	239.57	307.60	157.86	158.84	5.30
Валютын ханшны зөрүүний олз (гарз)	2.11	(0.41)	(75.37)	(76.54)	(44.43)	(184.64)	(31.09)	28.88	16.34	1.55	(0.56)	(12.35)	(9.11)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-	-	-	(0.02)	(0.03)	(0.03)	(0.07)	(0.06)	(0.01)	-	(0.07)	-
Бусад ашиг (алдагдал)	0.06	0.25	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	6.26	18.28	(59.44)	(64.44)	(42.75)	(213.41)	554.61	1,031.71	1,405.98	245.03	164.32	1,788.95	3,603.35
Орлогын татварын зардал	1.11	4.29	19.94	0.02	3.86	(14.57)	93.54	224.15	370.41	96.01	53.55	484.46	898.31
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	5.15	13.99	(79.37)	(64.46)	(46.61)	(198.84)	461.07	807.56	1,035.57	149.02	110.76	1,304.49	2,705.04

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын ангилал	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023Q3	НИЙТ
НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ		13,967.2	562.2	441.5	25,503.1	38,751.2	789,640.7	1,428,891.3	981,194.8	1,736,671.1	1,849,731.2	6,865,354.5
Үүнээс: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН		13,967.2	562.2	441.5	25,503.1	20,151.2	320,872.3	764,166.3	800,367.6	1,657,484.4	1,657,870.6	5,261,386.6
1	ТОМООХОН ТӨСЛҮҮД	65.8	0.0	0.0	0.0	0.0	308,872.7	733,122.3	709,901.0	1,525,115.3	1,553,888.5	4,830,965.6
1.1	Төмөр замын төслүүд	0.0	0.0	0.0	0.0	0.0	308,872.7	732,939.1	702,484.9	977,745.7	1,005,839.1	3,727,881.6
	1.1.1.1 ТТ-ГС чиглэлийн төмөр замын төсөл						308,872.7	732,939.1	348,057.9	412,790.8	943,803.6	2,746,464.1
	1.1.1.2 Төмөр замын нүүрс ачих байгууламж (ТНАЛТ I)								81,021.7	88,748.4	62,035.5	231,805.6
	1.1.1.3 Холболтын төмөр замын шугам									218,000.0		218,000.0
	1.1.1.3 ТТ-ЗБ чиглэлийн төмөр замын төсөл*								273,405.4	127,287.9		400,693.2
	1.1.1.5 Богдхан төмөр замын төсөл								0.0	130,918.6		130,918.6
1.2	Терминалын төслүүд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	3,856.9	0.0	3,856.9
	1.1.2.1 Гашуун сухайт чингэлээ тээврийн терминал									3,856.9		3,856.9
1.3	Нэмүү өртөг шингээх төслүүд	65.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	183.2	1,723.5	180,214.9	317,190.5	499,377.8
	1.1.3.1 Нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл								1,017.7	95,693.4	316,939.8	413,651.0
	1.1.3.2 Ус хангамжийн төсөл	65.8						183.2	705.8	84,521.5	250.7	85,726.9
1.4	Эрчим хүчний төслүүд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	5,692.6	7,221.3	29.7	12,943.6
	1.1.4.1 Тавантолгой дулааны цахилгаан станц								5,692.6	7,034.3		12,726.9
	1.1.4.3 Кокс-эрчим хүчний үйлдвэрийн төсөл									187.0	29.7	216.7
1.5	Бүтээн байгуулалтын төслүүд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	63,173.0	230,829.2	294,002.3
	1.1.5.1 Газрын тос дамжуулах хоолойн төсөл									62,898.4	230,829.2	293,727.6
	1.1.5.2 Уурхайн суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын төсөл									274.7		274.7
1.6	"Тавантолгой түлш" ХХК хөрөнгө оруулалт**									292,903.4		292,903.4
2	КОМПАНИД ХИЙГДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	13,901.5	562.2	441.5	25,503.1	20,151.2	11,999.6	31,044.0	90,466.6	132,369.1	103,982.0	430,421.0
2.1	Барилга, байгууламж	31.0	51.9	57.5	11,665.0	884.1	3,452.7	8,693.8	7,413.7	39,250.1	8,328.2	79,827.8
2.2	Дэд бүтэц	69.5		94.9						44.0	16,565.4	16,773.7
2.3	Уулын техник, тоног төхөөрөмж, машин механизм	3,489.8	217.8		3,929.5	1,613.5	1,383.7	711.8	75,661.2	73,820.8	67,139.5	227,967.6
2.4	Компьютер, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл	118.4	179.9	109.0	1,264.1	743.8	1,196.3	777.9	371.6	8,133.2	1,814.3	14,708.6
2.5	Биет бус хөрөнгө	4,135.3	89.5	108.0	8,504.6	16,600.4	4,659.1	2,786.5	6,397.4	3,461.9	118.5	46,861.2
2.6	Тавилга, эд хогшил	1,510.7	23.1	63.5	78.1	307.3	115.4	149.0	45.8	1,865.6	49.4	4,207.8
2.7	Зөвлөх үйлчилгээ	4,423.5		8.6					576.8	0.0	0.0	5,008.9
2.8	Дотоодын цэрэг харуул хамгаалалтад авахад шаардлагатай									5,374.7	5,586.4	10,961.1
2.9	Он дамжин хэрэгжсэн бусад хөрөнгө оруулалт	123.3			61.8	2.2	1,192.6	17,925.1		418.8	4,380.4	24,104.2
3	САНХҮҮЖИЛТ	0.0	0.0	0.0	0.0	18,600.0	468,768.4	664,725.0	180,827.2	79,186.7	191,860.6	1,603,967.9
3.1	ТТ-ЗБ чиглэлийн төмөр замын төслийн санхүүжилт*						357,000.0	526,000.0			32,430.0	915,430.0
3.2	"Тавантолгой түлш" ХХК-ийн санхүүжилт**					18,600.0	111,768.4	138,725.0	180,827.2	79,186.7	159,430.6	688,537.9

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ОЛБОРЛОСОН НҮҮРС /давхарга тус бүрээр, сая тн/

№	Нүүрсний давхарга	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он /10сар/	Нийт
1	Цанхийн зүүн уурхай	0.01	0.92	2.50	2.74	0.90	-	7.39	5.79	7.06	11.02	8.86	4.13	7.13	13.93	72.38
1.1	III давхарга	-	-	-	-	-	-	1.38	1.95	1.96	3.87	2.67	0.98	3.39	6.82	23.00
	коксжих	-	-	-	-	-	-	1.23	1.88	1.93	3.42	2.65	0.98	3.36	6.77	22.21
	исэлдсэн	-	-	-	-	-	-	0.15	0.07	0.03	0.45	0.02	-	0.03	0.04	0.80
1.2	IV давхарга	0.01	0.92	2.50	2.74	0.90	-	5.96	3.84	5.10	6.30	4.21	2.54	3.52	4.99	43.53
	коксжих	-	0.90	2.46	2.49	0.89	-	5.12	3.50	4.68	5.80	3.89	2.51	3.34	4.95	40.53
	исэлдсэн	0.01	0.02	0.04	0.25	0.00	-	0.85	0.33	0.41	0.51	0.32	0.03	0.17	0.03	2.99
1.3	Бусад давхарга	-	-	-	-	-	-	-	-	0.01	0.84	1.97	0.48	0.20	2.13	5.64
	коксжих	-	-	-	-	-	-	-	-	-	0.41	1.47	0.38	0.10	1.92	4.29
	исэлдсэн	-	-	-	-	-	-	-	-	0.01	0.43	0.50	0.10	0.10	0.21	1.36
1.4	Актаар бүртгэсэн*	-	-	-	-	-	-	0.05	-	-	0.00	0.01	0.13	0.02	-	0.21
2	Цанхийн баруун уурхай	-	-	-	2.56	3.61	3.85	0.34	4.32	4.06	5.17	4.26	4.47	4.20	8.57	45.41
2.1	III давхарга	-	-	-	-	-	-	-	0.75	0.80	0.49	1.28	0.79	2.27	4.53	10.91
	коксжих	-	-	-	-	-	-	-	0.71	0.80	0.48	1.21	0.77	2.27	4.46	10.70
	исэлдсэн	-	-	-	-	-	-	-	0.04	-	0.00	0.07	0.02	-	0.07	0.20
2.2	IV давхарга	-	-	-	2.56	3.61	3.85	0.28	3.51	3.14	4.61	2.76	2.20	1.21	1.98	29.70
	коксжих	-	-	-	2.19	3.58	3.54	0.25	2.95	2.77	4.58	2.71	2.01	1.19	1.98	27.76
	исэлдсэн	-	-	-	0.37	0.03	0.31	0.02	0.55	0.38	0.03	0.05	0.19	0.02	-	1.94
2.3	Бусад давхарга	-	-	-	-	-	-	-	0.06	-	0.03	0.18	1.48	0.72	2.06	4.54
	коксжих	-	-	-	-	-	-	-	0.03	-	0.01	0.11	0.64	0.35	1.50	2.65
	исэлдсэн	-	-	-	-	-	-	-	0.03	-	0.02	0.07	0.84	0.37	0.56	1.89
2.4	Актаар бүртгэсэн*	-	-	-	-	-	-	0.06	0.01	0.11	0.04	0.05	0.00	-	-	0.26
3	Нийт	0.01	0.92	2.50	5.30	4.51	3.85	7.73	10.11	11.12	16.19	13.13	8.60	11.32	22.50	117.79
3.1	III давхарга	-	-	-	-	-	-	1.38	2.70	2.76	4.35	3.95	1.77	5.66	11.34	33.91
	коксжих	-	-	-	-	-	-	1.23	2.59	2.73	3.90	3.86	1.74	5.63	11.23	32.91
	исэлдсэн	-	-	-	-	-	-	0.15	0.11	0.03	0.46	0.09	0.02	0.03	0.11	1.00
3.2	IV давхарга	0.01	0.92	2.50	5.30	4.51	3.85	6.24	7.34	8.24	10.91	6.97	4.74	4.72	6.96	73.23
	коксжих	-	0.90	2.46	4.68	4.48	3.54	5.37	6.45	7.45	10.38	6.60	4.52	4.53	6.93	68.30
	исэлдсэн	0.01	0.02	0.04	0.62	0.04	0.31	0.87	0.89	0.79	0.53	0.37	0.22	0.19	0.03	4.93
3.3	Бусад давхарга	-	-	-	-	-	-	-	0.06	0.01	0.88	2.15	1.96	0.92	4.19	10.18
	коксжих	-	-	-	-	-	-	-	0.03	-	0.42	1.58	1.03	0.44	3.42	6.93
	исэлдсэн	-	-	-	-	-	-	-	0.03	0.01	0.45	0.57	0.94	0.47	0.77	3.25
3.4	Актаар бүртгэсэн*	-	-	-	-	-	-	0.11	0.01	0.11	0.04	0.06	0.13	0.02	-	0.47

"ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 2010-2022 он

сая төгрөг

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгө	92,254.52	33,154.13	3,315.47	50,114.51	1,754.18	298.03	99,190.80	232,048.50	116,444.92	57,508.75	95,945.67	81,489.05	408,542.72
Дансны авлага	17,713.39	69,691.13	50,299.99	48,215.42	29,801.16	21,637.72	29,535.49	23,098.16	19,538.08	25,687.31	16,007.45	15,579.05	25,020.60
Татвар НДШ-ийн авлага	-	-	-	2,655.66	1,547.27	23.68	2.31	8.57	208.79	762.65	621.17	177.58	163.00
Бусад авлага	-	-	-	13.40	22.24	27.90	24.41	26.17	106.29	112.50	79.18	99.89	90.45
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бараа материал	1,176.48	1,749.29	1,663.08	1,238.44	20,205.88	18,505.94	1,040.17	1,385.43	1,561.78	17,703.47	7,826.36	37,471.81	5,313.77
Урьдчилж төлсөн зардал	680.54	4,191.19	5,671.68	2,948.93	2,160.32	2,671.26	3,375.89	893.55	246.98	457.85	1,935.97	2,247.12	976.92
Дуусаагүй үйлдвэрлэлийн зардал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-	-	30.82	30.62	-	40.20	40.89	42.68	37.44	18.94	25.98	23.22
Борлуулах зорилгоор эзэмшиж буй ЭГ	-	-	-	-	-	3,367.70	3,367.70	1,390.76	1,221.50	1,053.69	1,053.69	1,053.69	-
Нийт эргэлтийн хөрөнгө	111,824.93	108,785.74	60,950.22	105,217.18	55,521.67	46,532.23	136,576.97	258,892.03	139,371.02	103,323.66	123,488.43	138,144.17	440,130.68
Үндсэн хөрөнгө	6,668.71	6,565.45	6,164.57	6,993.15	7,688.36	9,704.97	10,397.63	11,682.42	15,998.91	16,793.62	14,502.69	14,781.29	15,030.37
Биет бус хөрөнгө	68.27	146.73	135.43	124.72	192.19	284.72	278.28	1,830.17	1,790.73	1,714.05	1,677.06	1,339.44	1,119.66
Биологийн хөрөнгө	-	-	-	-	-	35.01	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-	-	-	171.75	414.18	434.18	434.18	434.18	434.18	434.18	434.18	434.18
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Уурхайн хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт эргэлтийн бус хөрөнгө	6,736.98	6,712.18	6,300.00	7,117.87	8,052.30	10,438.88	11,110.09	13,946.77	18,223.82	18,941.85	16,613.93	16,554.91	16,584.21
Нийт хөрөнгийн дүн	118,561.91	115,497.92	67,250.22	112,335.05	63,573.97	56,971.11	147,687.06	272,838.80	157,594.84	122,265.51	140,102.36	154,699.08	456,714.89
Дансны өглөг	2,961.68	5,278.91	-	8,743.92	7,284.77	11,390.18	12,504.92	4,424.85	12,941.46	582.64	12,950.96	10,729.63	2,531.04
Цалингийн өглөг	51.52	78.35	-	68.87	59.90	53.03	107.76	90.51	85.72	136.33	128.98	197.36	721.58
Татварын өр	10,878.13	180.10	-	4,290.41	2,573.17	5,462.41	31,946.89	76,323.50	37,355.31	15,299.37	24,790.09	49,901.31	84,540.59
НДШ-ийн өр	0.09	1.61	-	-	0.64	7.51	-	7.56	-	-	-	26.45	-
Богино хугацаат зээл	-	-	22,815.63	-	4,000.00	-	-	-	-	-	-	-	-
Хүүгийн өглөг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Ногдол ашгийн өр	158.37	215.83	-	3,368.40	3,689.30	10,451.61	583.55	529.92	541.50	821.15	11,990.13	658.52	658.52
Нөөц	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	-	-	-	108.62	0.27	0.27	-	-	-	0.37	0.20	0.99	1.11
Урьдчилж орсон орлого	4,850.63	67.50	-	866.74	52.52	898.33	23,481.13	24,502.69	15,779.52	15,460.48	14,154.29	32,853.52	44,489.92
Богино хугацаат өрийн дүн	18,900.42	5,822.30	22,815.63	17,446.96	17,660.57	28,263.34	68,624.25	105,879.03	66,703.51	32,300.34	64,014.65	94,367.78	132,942.76
Урт хугацаат зээл	-	-	-	-	-	-	54.03	12.51	-	-	-	-	-
Нөөц	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад урт хугацаат өр	-	-	-	-	-	107.06	-	-	453.48	436.50	12.51	-	-
Хойшлогдсон орлогын өр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат өрийн дүн	-	-	-	-	-	107.06	54.03	12.51	453.48	436.50	12.51	-	-
Нийт өр төлбөрийн дүн	18,900.42	5,822.30	22,815.63	17,446.96	17,660.57	28,370.40	68,678.28	105,891.54	67,156.99	32,736.84	64,027.16	94,367.78	132,942.76
Төрийн өмч	46.30	48.19	48.19	48.19	48.19	48.20	48.19	48.19	48.19	48.19	48.19	48.19	48.19
Хувьцаат капитал	48.19	46.30	46.30	46.30	46.30	46.30	46.30	46.30	46.30	46.30	46.30	46.30	46.30
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	511.03	511.03	511.03	511.03	511.03	511.03	511.03	511.03	511.03	511.03	511.03	468.41	468.41
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг	99,055.97	109,070.10	43,829.07	94,282.57	45,307.88	27,995.18	78,403.26	166,341.74	89,832.33	88,923.15	75,469.68	59,768.40	323,209.23
Нийт эздийн өмчийн дүн	99,661.49	109,675.62	44,434.59	94,888.09	45,913.40	28,600.71	79,008.78	166,947.26	90,437.85	89,528.67	76,075.20	60,331.30	323,772.13
Нийт эх үүсвэрийн дүн	118,561.91	115,497.92	67,250.22	112,335.05	63,573.97	56,971.11	147,687.06	272,838.80	157,594.84	122,265.51	140,102.36	154,699.08	456,714.89

ТАВАНТОЛГОЙ ХХК-НИЙ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /2010-2022 он/

сая төгрөг

№	Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ													
1.1	Мөнгөн орлогын дүн /+/	185,563.04	143,669.92	113,021.01	168,949.28	15,957.04	22,269.61	156,824.58	415,119.91	217,916.97	256,275.31	258,122.71	196,556.14	770,466.91
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	185,063.05	142,045.02	112,334.75	166,811.15	15,883.05	22,203.10	156,808.40	414,811.22	217,711.07	255,824.90	257,914.05	196,409.88	770,186.56
1.1.2	Буцаан авсан албан татвар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
1.1.3	Даатгалын нөхөрөөс хүлээн авсан мөнгө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
1.1.4	Бусад мөнгөн орлого	499.99	1,624.90	686.26	2,138.13	73.99	66.51	216.18	308.69	205.9	450.41	208.66	146.46	280.35
1.2	Мөнгөн зарлагын дүн /-/	89,641.45	137,117.87	81,551.97	110,312.57	39,831.08	15,649.29	53,319.97	233,093.70	213,313.05	273,726.46	190,852.87	171,469.95	462,048.34
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,361.71	1,659.55	1,802.49	1,826.61	1,810.38	1,423.10	1,583.45	2,658.00	3,393.64	3,125.61	4,740.77	6,014.62	6,155.07
1.2.2	НД-ын байгууллагад төлсөн	382.94	463.16	462.68	519.53	419.12	402.26	411.64	386.20	937.00	1,027.00	1,125.83	1,817.76	1,452.18
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	57,177.85	127,839.46	67,241.81	41,683.22	27,120.80	10,836.68	27,310.66	108,601.68	94,898.97	172,711.45	123,273.39	109,638.96	184,356.55
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	-	-	25.04	23.55	0.12	88.62	18.71	17.36	466.53	301.82	274.69	13.78
1.2.5	Түлш шагааруун, тээврийн хөлөг, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,155.46	5,648.05	7,062.90	3,658.18	13.00	23.17	44.25	243.21	14.62	18.18	10.75	2,631.72	17.95
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-	-	-	-	415.69	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	22,026.46	33.00	1,800.00	57,794.15	8,459.11	1,741.04	22,096.71	118,995.84	111,284.93	93,916.32	60,400.33	50,041.92	213,071.44
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	29.33	4.57	98.01	53.56	41.2	4.20	21.48	108.41	21.85	3.61	151.81	4.47
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,537.03	1,445.32	3,177.52	4,707.83	1,931.56	766.03	1,800.44	2,168.58	2,658.12	2,439.52	996.37	898.47	56,976.90
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	95,921.59	6,552.05	31,469.04	58,636.71	(23,874.04)	6,620.32	103,504.61	182,026.21	4,603.92	(17,451.15)	67,269.84	25,086.19	308,418.57
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ													
2.1	Мөнгөн орлогын дүн /+/	-	-	-	477.67	1,445.85	41.59	223.44	2,792.72	3,099.51	2,469.60	1,391.46	838.13	816.00
2.1.1	Хүлээн авсан орлого	-	-	-	477.67	1,445.85	41.59	223.44	2,792.72	3,099.51	2,469.60	1,391.46	838.13	816.00
2.2	Мөнгөн зарлагын дүн /-/	(85.00)	(17,631.38)	(313.47)	-	(171.76)	(262.29)	(79.30)	(3,632.45)	(5,428.50)	(2,821.30)	(722.70)	(852.45)	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(85.00)	(17,631.38)	(313.47)	-	(171.76)	(262.29)	(79.30)	(3,632.45)	(5,428.50)	(2,821.30)	(722.70)	(852.45)	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2.2.4	Бусад олгосон эзэл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(85.00)	(17,631.38)	(313.47)	477.67	1,274.09	(220.70)	144.14	(839.73)	(2,328.99)	(351.70)	668.76	(14.32)	816.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ													
3.1	Мөнгөн орлогын дүн /+/	-	-	981.19	-	5,827.83	61.29	4,843.21	2821.71	5836.34	2067.75	1371.1	29.63	33540.78
3.1.1	Эзэл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-	981.19	0	4,000.00	61.29	4,843.21	2,821.71	5,836.34	2,067.75	1,371.10	29.63	33,540.78
3.1.2	Төрөл бүрийн хандив	-	-	-	-	1,827.83	-	-	-	-	-	-	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн /-/	(19,932.76)	(47,908.78)	(60,086.90)	(12,315.35)	(31,183.64)	(7,821.39)	(9,599.20)	(51,150.49)	(123,714.85)	(43,201.07)	(30,872.78)	(39,558.13)	(15,721.67)
3.2.1	Эзэл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.2.2	Төрөл бүрийн хандив	(2.72)	(1.40)	(2,383.30)	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.2.3	Төлсөн ногдол ашиг	(19,930.04)	(47,907.38)	(57,703.60)	(12,315.35)	(31,183.64)	(7,821.39)	(9,599.20)	(51,150.49)	(123,714.85)	(43,201.07)	(30,872.78)	(39,558.13)	(15,721.67)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(19,932.76)	(47,908.78)	(59,105.71)	(12,315.35)	(25,355.81)	(7,760.10)	(4,755.99)	(48,328.78)	(117,878.51)	(41,133.32)	(29,501.68)	(39,528.50)	17,819.11
	Валютын ханшийн зөрүү	(4,346.77)	(112.27)	(1,888.51)	0	-404.55	-95.67	0	0	0	0	0	0	0
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	71,557.06	(59,100.38)	(29,838.65)	46,799.03	(48,360.31)	(1,456.15)	98,892.76	132,857.70	(115,603.58)	(58,936.17)	38,436.92	(14,456.63)	327,053.68
	Мөнгө, гүүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,697.45	92,254.51	33,154.12	3,315.46	50,114.49	1,754.18	298.03	99,190.79	232,048.50	116,444.92	57,508.75	95,945.67	81,489.04
	Мөнгө, гүүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	92,254.51	33,154.13	3,315.47	50,114.49	1,754.18	298.03	99,190.79	232,048.49	116,444.92	57,508.75	95,945.67	81,489.04	408,542.72